


Болдбаатарын ГҮНБИЛЭГ



БИ
ЧАМ
ТАЙ

Би чамд хайртай
Зохиолч: Б.Гүнбилэг

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

1. Харц

Тавдугаар ангид ордог жил... Манай ангийн хүүхдүүд бие биенийгээ ямар их өссөнийг, яаж өөрчлөгдсөнийг гайхан ярилцацгаагаад л... Ялангуяа охидууд хөвгүүдийнхээ сахилгагүй зан ихэд дарагдаж, нэлээд буйр суусан байгааг ажигласан бололтой жиг жуг шивнэлдэцгээнэ. Магадгүй тэд ч бас намба сууж эхэлсэн болохоор бидний өөрчлөгдөж, өссөнийг ийнхүү намбатай нь аргагүй хэлэлцэж буй бизээ. Урьд нь юм л бол охидынхоо гээгнээс чангаан чарлуулж байдаг хөвгүүд охидуудтайгаа их л хүндэтгэсэн байртай харьцаагаж, тэднийг харахдаа хүртэл харц нь дальдчиж, эсвэл тогтуун зөөлнөөр харах болсон байлаа. Би ч гэсэн бусадтай адил өөрчлөгдөж, охидын талаар урьдынхаас шал өөр бодолтой болсон байв. Зуны амралтаар тэднийгээ удаан хараагүйдээ юмуу, аль эсвэл тэд тийм сэтгэл татам гоё болцгоосон юмуу, өөрийгөө R&B дуучин гээд итгэчихэж. Амандаа дуу аяланхан байв.

Бүх юм хуучнаараа л байгаа юм шиг санагдана. Гэхдээ л хүүхдүүд өөрчлөгджээ. Тэр нь бүр мэдэгдээд байв. Манай ангийн охид миний бодлоор бол нэг их өөрчлөгдсөн юмгүй гэлтэй. Гэтэл хөвгүүд бидэнд яагаад өөр болсон юм шиг харагдаад байна вэ?

Нэг л мэдэх нь ээ нүдний минь харц шилжин шилжсээр манай ангийн онц сурлагатан Бүжин дээр туслаа. Тэр над руу харан инээмсэглэж байв. Инээмсэглэл...

Урьд нь бид хоёр байнга тэрсэлддэг байсан болоод ч тэр үү, би түүний энэ ялдам инээмсэглэлийг урьд ер ажигладаггүй байжээ...

Тэр охин нээх гоё

Тэрэн рүү дөхөх гэхээр их аймаар

Хазаад авмаар бумбагар хацартай

Хажиглахвий гэсэн бяцхан айдастай



Манай ангийн хамгийн хөөрхөн нь Бүжин. Түүний минь нүдэнд дулаахан дугариг царай, цовоо сэргэлэн ааль, уян налархай хөдөлгөөн, үргэлж инээмсэглэж явдаг бор нүд зэрэг нь миний сэтгэлийг эзэмдэж чадсан юм. Нэг л мэдэхэд түүнд сэтгэл алдарснаа би ойлгосон билээ.

Ер нь надад түүний бүх л юм дэндүү сайхан, дэндүү нандин, дэндүү гоёхон болж үзэгддэг боллоо. Гэхдээ энэ дотроос хамгийн ихээр сэтгэлийг минь татсан зүйл бол түүний хөнгөн шингэн алхаа, хөөрхөн бор нүд бус, хэнд ч үл гомдох цайлган сэтгэл, хэнийг ч үл ялгах ер бусын шударга зан, хэнтэй ч эелдэг харьцах ер бусын сайхан ааш нь байлаа. Би яагаад урьд нь энэ сайхан бүхнийг ажиглаагүй байдаг билээ гэж өөрөөсөө асуухад хүрнэ. Ийнхүү би тавдугаар ангидаа Бүжинд дурласан юм.

Ингээд миний өмнө дурлал гэдэг соньхон ертөнц нээгдэж, өөрийгөө хэр бөх, хэр амттайг мэдрүүлэх гэж сүндэрлэн босоод, одоо зөвхөн хайрын төлөөх тэмцэлд хөл тавин алхах л үлдлээ. Анхандаа Бүжинг сэтгэл зүрхэндээ хоногшуулчихаад шөнөжин зүүдэлж, өдөржин санагалздаг байлаа. Урьд ерөөс ийм байдалд орж үзээгүй би гэдэг хүн энэ хачин байдлаасаа ичих шиг, хэн нэгнээс зовох ч шиг...

Тэр үеэс би ангийнхантайгаа бужигнаж, ноцолдож байдаг зангаа бүр гээж, завсарлагаанаар ганцаар ангидаа үлдээд, Бүжингийн суудаг эхний эгнээний нэг дэх ширээг гөлрөн суудаг болов. Хамгийн хэцүү нь ийм байдалд орсныг минь Бүжин л мэдчихвий гэж айна. Хайр гэдэг

зүйлийг хүндэлсэндээ тэрүү хамаагүй зүрхлэн ойртож үл чадна.

Нэг удаа тооны хичээл орж байх үед би Бүжинг сэм сэмхэн, нүднийхээ булангаар хардаг дадлаараа ажиглав. Багшийн самбар дээр бичсэнийг дэвтэр дээрээ тэмдэглэчихээд Бүжин рүү хартал гай болж, Бүжин намайг бас харж байдаг байгаа. Ууц нуруугаар хүйтэн хөлс чийхарч, эргүүтсэн төлөг шиг яах учраа олохгүй доошоо харж, ичиж зовох, айх гайхах, баярлах гомдох зэрэгцэн бие нэг их сонин болж, юунаас юм мэдэхгүй толгой “хуурайшиж” хөшөөд байгаа мэт сэтгэгдэл төрнө. Томьёо цээжлээгүй гэж багшаар толгой руугаа татуулснаас илүү сааталд орчихсон би бээр бадайран салгалах биеэ арайхийн барьж билээ. Гэтэл Бүжин огт юм бодсон шинж алга. Надтай харц тулгарчихаад, юу ч бодоогүйгээр барахгүй намайг өөдөөс нь хараад байсанд:

-Яав, юугаа хараад байдаг юм гэж уцаарлав. Би юм хэлсэнгүй. Тэгж анх удаа дурлалын “цахилгаа”-нд цохиулснаас хойш хөөрхөн төрсөн түүнийгээ харахаас нэг л зовж, бүр бодохоос хүртэл айдаг хачин зантай болж орхисон юм. Бүжин намайг яагаад харав. Тэр намайг өөрийг нь хараад байдгийг мэдчихжээ гэх бодол төрнө. Ийм хачин дурлал гэж байх уу?

2. Зүүд

Бүжинг би олон шөнө зүүдлэв.

Хүн бүр өдөр бодсон бодол, үзсэн зүйлээ шөнө нь зүүдэлдэг гэдэг нь үнэн юм билээ. Нэг өдөр би ингэж зүүдэллээ.

Өглөө сурсан зангаараа том хүн болох гэж, аавынхаа ажилд барьдаг байсан хуучин, бор хавтсыг сугандаа хавчуулчихаад хичээлээсээ хоцрох шахам гүйсээр сургуулийн хашаанд орж ирлээ. Орчин тойронд хэн ч алга. Ганцхан би аахилж уухилсан амьтан жаахан гайхасхийн сургууль руугаа гүйн ортол үүдэн дээр намайг Бүжин хүлээгээд зогсож байдаг байгаа. Тэр миний өчигдрийн киноноос харсан шиг цав цагаахан даашинзаар гоёж, гартаа уруулынхаа өнгөтэй ижил ув улаахан сарнай цэцгийн баглаа атгажээ. Хайр дурлал, баяр жаргалдаа бялхсан Бүжин миний гараас хөтлөн, бидэнд баяр хүргэх хүмүүс болон цэцэг чимгээр дүүрсэн урт шатаар явсаар ангидаа орлоо. Хачирхалтай нь тэр намайг эгнээний хамгийн хойно орших суудалд минь суулгалгүйгээр өөрийнхөө хажууд суулгалаа. Би энэ суудал, Бүжингийн хажууд суухыг хэчнээн их мөрөөдөж байсан гээч. Ийм их аз завшаантай учирсандаа би ихэд баярлав.

Сургуулийн хаалгаар орж ирээд Бүжинтэй хөтлөлцөн шатаар өгсөх замд манай сургуулийн хүүхэд, багшгүй бүгд л бид хоёрт баяр хүргэж хөөрцөглөцгөөв. Анги нэгт нөхөд маань, ялангуяа хөвгүүд надад атаархаж байгаа нь илт. Гэхдээ тэд бүгдээрээ Бүжин, бид хоёрын найзууд учир бид хоёрт цэцэг өгч, сайн сайхныг ерөөсөн бөгөөд ангийн дарга бүдүүн Болдоо хүртэл оргилуун дарс хундагалсан болор жүнзнүүдийг жин жинхийлгэн тулгацгааснаа, бид хоёрт хандан Орос кинон дээр гардаг шиг “Горько! Горько!” буюу “Гашуун! Гашуун!” хэмээн орилолдов. Би эхлээд Бүжинг үнслээ. Уруул дээр нь үнсэх гэснээ олны нүднээс ичээд, хацар дээр нь үнсчихэв. Тэгээд дараа нь Бүжин зөөлөн ягаан уруулаараа миний хацар дээр шопхийтэл үнслээ. Хайртай хүндээ үнсүүлэх, ижийдээ эрхлэх хоёр их өөр юм билээ. Би жаргалдаа умбав...

Тэгснээ Бүжин дух, хүзүү, хамар дээр үнэрлээд л, долоолоо. Бүр саймсарч ирээд л шүлсээ гоожуулан долоох юм... Шүлс нь савираад л... Юун сайхан хайр дурлал, ийм сайхан охин чинь хүн анх удаа үнсэж байж ийм заваан байх гэж дээ, би ер нь Бүжинд хайртай билүү гэх бодол төрж, бүр дур гутаад:

-Хүүе! Бүжээн, чи чинь яаж байнаа гээд нүдээ нээтэл, хажууд маань миний Чаки нэртэй хав нүүр долоож байдаг байгаа. Ээж нөгөө өрөөнөөс:

-Миний хүү босоорой! Хичээлдээ явах цаг чинь боллоо. Ээж нь өглөөний унд бэлдээд тавьчихсан шүү. Одоо бос, бос! гээд өглөө болгон намайг босгох гэж энхрийлэн дууддаг заншлаараа дуудаж байна. Өндийж хувцсаа өмсөх зуураа “Хэчнээн гоё зүүд байлаа. Ямар балай төгсдөг эд вэ?” гэж бодов. Бүжин намайг долоож, шүлсээ савируулж, “Мангас авирласан” ч гэсэн энэ бол зүүд байлаа. Би түүнд хайртай.

3. Шинэ жил

Газар дэлхий цагаан цасан хучлагаа нөмөрч, хүн ард өвлийн цэлмэг өдөр ажил албандаа яаран бие биенээсээ түрүүлэх гэсэн мэт нэгэн зүг яаран алхална. Хүмүүсийн энэ урсгал өглөө баруунаас зүүн тийш, орой зүүнээс баруун тийш яг л ийм хэмнэлтэйгээр шилжин өнгөрдгийг би сайн мэднэ. Бас машинтай хүмүүс гараажийнхаа үүдийг онгойлгон шинэ, хуучин янз бүрийн загварын гоёмсог тэрэгнүүдээ асаан гарцгааж байна.

Надад энэ хүмүүсийг бараг алган дээрээ тавьсан мэт харж, тэдний юу бодож санаж байгаа хийгээд тунгалаг ариухан, цэлмэг тэнгэртэй энэ өдөр тэд юу хийхийг бараг алдалгүй мэдэж байгаа юм шиг санагдана. Гэтэл энэ хүмүүс надтай ямар хэцүү, ямар зовлонтой зүйл учирчихаад байгааг үл анзааран, анзаарах байтугай намайг тэднийг харж байгааг ч мэдэхгүй яваа нь гомдолтой санагдана. Хүнд дурлана, тэгээд хайраа илчлэх гэдэг хэцүү ажээ. “Би чамд хайртай” гэдэг гуравхан үгийг хэлэхэд ямар их зориг шаардагдана вэ? Даанч тэр надад дургүй. Би энэ үгийг хэлээд ч яах билээ.

...Үүр дөнгөж хаяарч байлаа. Босох цагаасаа эрт сэрсэндээ ч тэрүү, аль эсвэл өнөөдөр энэ оны хамгийн сүүлчийн өдөр болоод ч тэрүү, яагаад ч юм бүү мэд, ундууцах сэтгэл төрөөд болсонгүй. Би уг нь өөртөө энэ оныг дуусахаас өмнө заавал биелүүл гэж нэг даалгавар өгсөн юм. Гэтэл би ерөөсөө яаж ч хичээгээд тэр даалгавраа биелүүлж чадалгүй явсаар оны сүүлчийн өдөртэй золгочихоод байдаг. “Хүн шинэ он гарахаас өмнө ямар нэг өр шир, бодож төлөвлөж байсан зүйлээ гүйцэлдүүлбэл ирэх ондоо өөдрөг бүтэмжтэй явдаг жамтай” гэж эртээд манай ээжийн залж ирсэн ламтан айлдсанаас болсон юмуу, өөртөө өгсөн даалгавраа заавал биелүүлж байж шинэ онд ормоор бодогдоно.

Миний тэгж их даалгаварсаад байгаа зүйл бол хоёр жил гаруйн турш сэтгэлдээ тээж явсан “Би чамд хайртай!” гэдэг үгийг Бүжинд хэлж, хайр сэтгэлээ илчлэх явдал юм. Түүнийхээ энхрий зөөлөн, ер бусын увидастай харцтай мөргөлдөхийн төдийд сэтгэлд нар мандуулж, гэгээ тусгадаг бор нүд, сонсох бүрт эгшиг дээдийн жаргал бэлэглэдэг болсон яруу сайхан дуу хоолой зэргийг санахлаар зүрх минь дурлалдаа шатаж, сэтгэл тогтохгүй хямарна. Түүнийг хэдий чинээ их бодно, төдий чинээ сэтгэл үймэрч, надад зовлон авчирдаг ч гэсэн хааяа надад ингэж зовох маань ч таалагдах мэт.

Бүжинг харахаар юу ч хэлж чадахаа больчихно. Би их аймхай юмаа...

Уг нь би олон удаа хайраа илчлэх гэж оролдсон боловч тэр болгондоо бүтэлгүйтэж байв. Эхлээд сургууль дээр байх үедээ хэлье гэж боддог байлаа. Гэтэл уулзахаар хэл татчихаад, юун хайраа илчлэх манатай юм болно. Дараа нь утсаар хэлье гэж бодлоо. Мөн нөгөө хэл нь Бүжингийн дууг сонсохоороо татчихаад, ярьж чадалгүй утсаа тавьчихна. Эцэст нь хамгийн зөв арга бол захиа бичих гэж бодлоо. Бодож санах юмгүй Бүжинг магтаад бөөн юм бичээд байсан чинь хайрын нандин үгээ бичихээ мартчихаж. Захиагаа биччихээд дараа нь өөрөө уншихад аймаар байлаа. Захианд маань уран тансаг үгс, жишээ нь “Бүсгүй таны гоо үзэсгэлэнг магтан дуулья. Өөдгүй муу шүлэгч хөвгүүн би бээр уран тансаг үггүйгээр чинь, уянгалаг сайхан хоолойгүйгээр чинь цаашид амьдрах, амьсгалах тэнхэл алга” л гэнэ. Бас “Бүхнийг гэрэлтүүлэгч сэтгэлийн хатан хаан мину, таны тэгш сайхан бие тэнэгэр уужим

ухаан, дөлгөөн тунгалаг нүд...” гээд авч алджээ. Тэгэхлээр нь ерөөсөө энэ захиаг энэ чигээр нь өгчихье гэж бодоод бушуухан дугтуйлаад бүдүүн Болдоогоор дамжуулан Бүжинд өглөө. Учир нь дөнгөж долдугаар анги байж “Би чамд хайртай” гэж хэлэх нь миний хувьд дэндүү ахадсан зүйл шиг санагдсан юм. Бүжин Болдоогоос хэн өгч байгаа юм бэ? гэж асууж байгаа бололтой шалгаахад, миний итгэлт анд “хэлэхгүй” хэмээн толгой сэгсэрч харагдана.

Бүжин захиагаа задлан уншлаа. Манай ангийн охидууд түүнийг нь ажсан бололтой хоорондоо жиг жуг гэлцэнэ. Тэр үед эцэст нь юу болохыг мэдэх сөхөө хүрээгүй би гэдэг хүн захиан дээрээ нэрээ тавиагүйгээ гэнэт саналаа. “Баларсан юм. Ганц зориглож, зориглож бичсэн чинь нэрээ бичээгүй байдаг” хэмээн нас өндөрссөн хөгшин чавганц шиг дотроо харамсан шогширч байсан юм. “Гэхдээ яахав эр хүн арван гурван мэхтэй гэдэг. Түүнийгээ арай ч дуусчихаагүй байна” гэж ганц захиа бичээд өөрөө өгчихөж чадахгүй байж, хүчээ хэт үнэлэн өөрийгөө тайтгаруулсан юм. Бүжин миний захидлыг уншаад, хацар нь бага зэрэг улайж, хүүхдүүд рүү ичингүйрэн харав. “Хэн бичсэн бол???” гэж бодсон нь илт. Тэгснээ нэрээ бичээгүй захиа юм чинь хөвгүүд надаар тоглоом хийж байна гэж бодсон бололтой захиаг минь ураад хог руу хаячихав. Анхны хайрын захиа ингэж бүтэлгүйтсэн юм...

Өглөө босонгуут ээж, аав хоёр ажилдаа явахаасаа өмнө нөгөө л сургадаг заншлаараа “Энийгээ тэгээрэй! тэрийгээ ингээрэй! Хичээлээ давтаарай! Эгчдээ туслаарай!” хэмээн сургаж сургаж, захиж захиж явцгаалаа. Өнөөдөр энэ оны сүүлийн өдөр учраас оройн хоолонд юу хийх, дэлгүүрээс юу авах, ширээгээ яаж засах, гэрээ хэрхэн цэвэрлэх гээд олон зааварчилгаатай даалгавар эгч, бид хоёрын толгой дээр буув. Ээж, аав хоёр маань баярын өдөр ч байсан ажлаасаа их орой ирдэг улсууд тул эгч бид хоёр л гэрийнхээ бүх ажлыг амжуулдаг юм. Бид хоёр ч гэж эгч маань л ихэнх юмыг хийж, би туслахчаан аядана. Гэтэл би гэдэг хүн өнөөдөр маш том ажилтай болчихоод байдаг.

Цаг минут өнгөрсөөр өдрийн нэг цаг болов. Эгч, бид хоёр дэлгүүр, хоршоогоор явж бялуу, чихэр, жимс, ундаа, оргилуун дарс зэрэг баярын ширээ засахад хэрэгтэй зүйлсээ авчихаад гэрээ цэвэрлэх гэж байлаа. Би өглөөнөөс хойш Бүжингийн тухай бодсон тэр л хэвээрээ бөгөөд ерөөсөө зав гарахгүй байсаар байгаад өдрийн талыг ардаа орхичихсон нь намайг жаахан харамсмаар, түгшмээр байдалд оруулав. Би “Бүжинтэй ерөөсөө одоо утсаар ярьж нэг газар уулзъя! гэж хэлье. Тэгээд очиж уулзаад:

-Бүжээн! Би чамайг хоёр жилийн өмнөөс бодож эхэлсэн. Би чамгүйгээр амьдарч чадахгүй нь. Чи намайгаа ойлгооч дээ хэмээн яг л кинонд гардаг шиг урсгаж гаръя” гэж бодлоо. Би ертөнцийн ихэнх сайн, муу зүйлсийг зурагтнаас дан ялангуяа киноноос олж мэддэг учир бүх юмыг кинонд гардаг шиг сайхнаар, түргэн өрнөлтэйгөөр төсөөлөх дуртай.

Ингээд би утсаар ярьж, Бүжинтэй уулзах газар, цагаа товлоод түүнтэй уулзан, надад ахадсан гэмээр энэ айхтар хайрандаа шатсан би гэдэг хүн хунтайжийн дүрд хувилж “Үзэсгэлэнт гүнжид хайраа илчилье. Харин ингэхээсээ өмнө би өөрөө яг очиж чадах эсэхээ мэдэхгүй байгаа учир эгчээсээ эхлээд асуусан нь дээр байх” гэж бодов. Заримдаа манай гэрийнхэн намайг хичээлээ давтаагүй юмуу, эсвэл гэрээ цэвэрлээгүй бол гадаа гаргадаггүй юм. Би:

- Эгээ! Би нэг хүүхэдтэй уулзаад ирье, за юу? Би удахгүй гэв. Тэр үед яг гай таарч эгч ууртай байлаа. Найз залуутайгаа утсаар ярьж байхдаа:

- Чи одоохон над дээр ирэхгүй бол хоёулаа больё. Чиний найзууд чинь ямар хамаатай юм. Өчигдөр чи надтай уулзаагүй ш дээ хэмээн маргалдаж байхыг би сонссон билээ. Энэ эмэгтэйчүүд ядаргаатай гэдгийг би мэднэ. Хоёр хоног уулзаагүй л биз, тэгээд юу гэж. Ямар аваад суусан авгай, алаад зүүчихсэн үнэг биш гэж том бодсон хэрнээ “Намайг миний Бүжин яг ингэж загнаасай. Чи өчигдөр надтай уулзаагүй. Өнөөдөр бас уулзахгүй санаатай юу” гэж ирээд “мундагдвал” би л лав баярлана. Надтай адил эгчийн цаад найз нь бас тэгж бодож байгаа болов уу.

Эгч:

- Хэзээ яваад ирье гэж... хэмээн зандрангуй аятай асуухад:

- Мэдэхгүй ээ, би нэг хүүхэдтэй утсаар ярьчихаад дараа нь очиж уулзах юм. Болох уу? Та уурлахгүй биз дээ. Ганцаараа бүх юмаа хийлээ гэж гэв. Би явбал “гялс” гараад ирье гээд харанхуй болтол тоглодгийг мэдэх эгч:

- Чи тоглож байна уу? Ийм их ажилтай байхад хүүхэд уруу татаж дэмий тэнэх гээ юу? Тэр хүүхэд чинь ч гэртээ их ажилтай байгаа байлгүй хэмээн яав ч гаргахгүй янзтай дуугарлаа.

Уг нь миний эгч тийм ч их ууртай хүн биш л дээ. Тэр цаад нэг хар юм нь л уурыг нь хүргэчихгүй юу. Гэсэн ч одоо би эгчийгээ үзэн ядаж байлаа. Өнөөдөр энэ оны сүүлийн өдөр, арван хоёр сарын гучин нэгэн шүү дээ. Ингэж хүнд гай учруулсан хүнийг өнөөх бурхан тэнгэр яадаг бол...

Нүгэл үйлдсэн хүнийг бурхан гэсгээдэг юм гэсэн. Лав л эгч намайг ингэж зовоож, үл тоомсорлосных нь төлөө найз залууг нь ирүүлэхгүйгээр гэсгээх байх даа гэх мэтээр бодов. Уг нь үнэнээ хэлээд, учраа тайлбарлавал эгч намайг явуулна л даа. Гэхдээ ямар би эгчид, эгчийн танихгүй Бүжингийн тухай ярьж, “Би Бүжинд хайртай гэдгээ хэлэх гэсэн юм. Та намайг явуулчих” гэж хэлэлтэй биш. Тэгвэл эгч намайг шоолоод:

-Чамд бас хайртай охин байдаг юмуу? Хэ-хэ гэх биз... Хэ-хэ. Мөрөөсөл болсон хайрт бүсгүй дээрээ очих гэж “Шадар гурван цэрэг” киноны Д’Артаньян ямар зоригтойгоор аялж, тулалддаг билээ. Яг л түүн шиг намайг хорьж буй бүхнийг зад татаад, гараад явчих юмсан гэсэн гоё бодол толгойд орж ирэв. Гэсэн ч би явсангүй. Дуулгавартай, томоотой, үгэнд ордог сайн дүүгийн дүрд тоглохоор шийдлээ. Зориг дугав.

...Зурагтаар хийл хөгжмөөр тоглох бүжгийн аясанд хосууд гайхалтай бүжиглэж буй нь гарч байна. Манайхан бүгд л энгүүн хөгжилтэй, сэргэлэн жавхаатай харагдах агаад том өрөөний хойморт залрах сүлд мод, олон өнгийн гэрлэн чимэглэлээ ээлжлэн, өнгө алаглуулан гялалзуулж, бүх юм гоёмсог, сэтгэл татам болсон үзэгдэнэ. Эгч ч бас өдрийнх шигээ үглэж зовоохгүй сайхан зантай, амандаа дуу аялан найз залуугаа түрүүн ирээд явсанд сэтгэл нь өег болсон бололтой шал өөр болчихсон байх ажээ. Баярын ширээн дээр янз бүрийн амттан, бүр миний хамгийн их дуртай алимтай бялууг хүртэл өрсөн байв. Гэсэн ч би энэ бүхнийг хайхарсангүй, гагцхүү одоо яаж Бүжинд хэлэх вэ? л гэж бодож суулаа. Одоо надад ганц л зам үлдсэн бөгөөд тэр нь утсаар ярьж хайраа илчлэх. Яг арван хоёр цаг болохоор Бүжин рүү утасдахаар шийдэв. Энэ удаа харин өөрийгөө тэгж зовоохгүй их зоригтой байх болно гэж

СЭТГЭВ.

Арван хоёр цаг хариугүй болох нь...

Нэг минут дутуу. Миний даалгавраа биелүүлэх цаг ч ойртлоо. Би босоод утас руугаа явлаа. Нэг алхлаа, хоёр алхлаа. Утас руу би ойртсоор...

Уушиг, зүрх ч амаар гарах нь уу гэлтэй хүчтэй савалж, санаа сэтгэл хачин ихээр догдолж, биеэр нэг тархсан хайрын халуун доргио байсхийгээд цахилгаан гүйдэл гүйж байгаа мэт жирс жирсхийлгэнэ. Яг л аймшгийн кинонд гардаг шиг бүх юм түгшүүртэй. Гэтэл гэнэт миний дотроос хоёр хүний цочмоор хоолой бие биенээ давах гэсэн шиг чанга чанга дуугаар орилолдон хашгиралдацгааж нэг нь намайг:

- Залуу минь, урагшаа алх! Тэр утасны харилцуурыг аваад зоригтой, өөртөө итгэлтэй байж, Бүжинд сэтгэлээ илчлэх хэрэгтэй. Эс тэгвэл чи аймхай, хулчгар амьтанд тооцогдох болно гэхэд нөгөөдөх нь:

- Хэрэггүй ээ. Тэгж өөрийгөө зовоогоод яахав. Тэртэй, тэргүй чи чадахгүй ш дээ. Чи дэндүү балчир байна. Аймхай минь, боль гэм. Чи ч уг нь ингэж охиноос айж, ичиж явах тавиланд төрөөгүй л хүүхэд дээ. Гэхдээ цаадах чинь чамайг тоохгүй. Одоо бушуухан буцаж очоод, суудалдаа суугаад зурагтаа үз! Тэгээд бүр зүгээр сууж чадахгүй бол аав, ээжээсээ нууж байгаад, тэдний тулгаад байсан хундагатай архийг хөнтөрчих. Тэгвэл чи бүхнийг мартаж, сэтгэл чинь уужрах болно. Мэдэв үү? Ха- ха! гэж зэвүүнээр хэлэх нь тэр. Тэгснээ өнөөх хоёр чинь “Яв гэм! Урагшаа алхаач! Утсаа аваад Бүжинтэй ярь! Хайр сэтгэлийнхээ төлөө урагшаа” хэмээн зоригжуулаад ч байгаа юм шиг эсвэл “Болиоч! Боль гэм! Хөөе, хулчгараа. Хэрэггүй, яах юм” гэж аргадан, басамжлан шоолж, миний дотроос намайг хатган орилолдоцгоож байв. Би яах ч учраа олохоо болилоо. “Одоо яах вэ? Утсаар ярих уу, байх уу? Би ярьж чадах болов уу? Үгүй юу?” хэмээн эргэж буцан өөрийгөө “шаналгаж” байтал өнөөх “Чи чадахгүй ээ! Хулчгараа боль, боль!” гэх дуу сонсдож, миний шар буцлаад явчихлаа. Энэ үед би өөрийгөө хэтэрхий аймхай, хулчгар юм байна гэдгийг мэдсэн ба энэ зантайгаа тэмцэж урагшиллаа. Би утас руу улам бүр ойртсоор, биеэр гүйх цахилгаан гүйдэл хурдассаар, нөгөө хоёрын дуу ч миний дотроос хатган хашгиралдсаар...

Ар нуруугаар хүйтэн хөлс цувлаа. Хөл найгаж, тогтож чадахаа болилоо. Зүрх ширүүн цохилж, цээжийг минь өвгөлөө. Ухаан алдах нь ээ! Гэсэн ч миний зүрх сэтгэл “Утсаа аван Бүжинд хайртайгаа хэл!” гэж тушаалаа. Ингээд би эцсийн удаа, хорвоогоос халихын өмнө гүн амьсгаа авч байгаа юм шиг санаа алдаад, зориглон утсаа автал...

Яасан гээч... Яасан гээч... Манай утас таг болчихсон, ямар ч дохио дуугарахаа больсон байв. Утасны ачаалал ихсээд шугам ажиллахгүй болсон аж. Он гарчихлаа... Шинэ жилийн мэнд хүргэе!... Одоо яалтай билээ... Он гарчихсан болихоос доо...

Тиймээ! Тэр жилийн орой үнэхээр хөгжил баясал, гуниг тайвширлаар дүүрэн байсан юм. Хий хоосон айдсаар хүн амьдрах нь өөрийгөө зовоох нэг хэлбэр бөгөөд Бүжин надад хайртай, үгүй нь хамаагүй би өөрийнхөө түүнд хандах сэтгэлээ илчлэх нь л чухал гэдгийг улам бүр ойлголоо. Би түүнд “Би чамд хайртай!” гэж заавал хэлэх ёстой. Тэгэхийн тулд өөрийгөө

бэлдэх хэрэгтэй.

4. Би чамд хайртай!

Бүжинд дурласнаас хойш гурван жил өнгөрчээ. Хайраа илчилж чадалгүй байсаар энэ гурван жилийг өнгөрөөсөн миний хувьд түүнийг сэтгэлдээ хайрлаж, нэрийг нь амандаа үглэсээр байгаад бараг миний шүтээн аятай болгож орхив. Хааяа би Бүжингийнх рүү залгана. Ээж нь бололтой нэг эмэгтэй хүн аваад, Бүжинг дуудна. Тэгэхээр нь би ярьж зүрхлэхгүй утсаа тавьчихна. Зөндөө олон удаа тэгсэн.

Энэ тухай Бүжин харин мэдэхгүй. Гэхдээ тэр намайг өөрт нь сайн гэдгийг гадарлаж байлаа. Өнгөрсөн гурван жилд надад Бүжинг зүүдэлж хоноогүй шөнүүд байхгүй. Чухам түүний төлөө л төрсөн юм шиг, түүний л төлөө амьд яваа юм шиг сэтгэгдэл төрнө. Заримдаа энэ байдлаасаа ч залхах шиг. Ерөөс кинонд гардаг хар тамхинд тархиа идүүлсэн амьтан шиг гөлийсөн, яах, юу хийхээ ч мэдэхээ байсан над шиг хүн энэ байдлаасаа эцэст нь залхах аргагүй юм. Гэхдээ Би Бүжинд хайртай. Энэ их хайр минь хэдийгээр Бүжин намайг тогтож харах хүсэлгүй, тэр ч байтугай үзэн ядах болсонтой зэрэгцүүлэхийн аргагүй. Нэг нь хайрлаж, нөгөө нь үзэн ядна гэдэг амьдралын эрээн бараан. Бүжинг хайрлаж, юм болгонд нь туслахыг оролдож, анд нөхдийнхөө дунд түүнийг бусдаас илүүд үзэх нь яршигтай, бас залхмаар байсан нь мэдээж. Хэрэв би анги хамт олныхоо дунд ямар нэг зүйлийн тухай, эс бөгөөс ямар нэгэн шинэ санаа дэвшүүлэхэд Долгионы хэлсэн зүйл хамгийн утгагүй байдаг. Тиймээс ямар ч санаа дэвшүүлсэн Долгионы буруу гэж бодон миний санааг эрс эсэргүүцэх нь олонтаа.



Дун цагаан өвлийн өдөр хичээлээ тараад ангиараа цасан өвгөн хийж тоглоход, Долгион л түүний цасыг бөөрөнхийлж өгнө. Өөр хэн ч биш. Учир нь ангийн хамгийн том биетэй нь Долгион. Бусад хөвгүүдэд Бүжингийн цасыг бөөрөнхийлж өгөх эрх олгохгүй. Хөвгүүд охидуудыгаа хөөн цасаар нүүрийг нь угаахад, Бүжинг Долгион л хөөж, Долгион л нүүрийг нь

угаана. Хэрэв өөр хүн Бүжинг хөөвөл Долгион тэр хөвүүнийг түлхэж унагачихаад, өөрөө Бүжинг үргэлжлүүлэн хөөнө. Юм болгон дээр Бүжин надаас өөр хүний тусламжийг авч чадахаа байж, бүр надаас өөр эрэгтэй хүүхэдтэй харьцах эрхгүй болсон байлаа. Тийм учраас Бүжин намайг юм болгонд оролцдог хэмээн үзэн яддаг болсон юм. Магадгүй, тэр өөр хөвгүүнд сайн байж болно шүү дээ. Гэтэл энэ маанаг Долгион зам дээр нь хөндөлдөөд байж мэдэх. Гэхдээ Бүжин бид хоёр л бидний хооронд ямар харьцаа үүсээд байгааг гадарлаж байв. Гайхмаар нь ангийн ганц нэг охид анзаарсан байж болох ч, хөвгүүд бол намайг Бүжинд сайн гэж төсөөлөө ч үгүй болов уу гэж надад бодогдоно. Би Бүжинд хайртай. Харин тэр өөрийг нь хайрласан миний энэ сэтгэлийг буруугаар ойлгосон нь харамсалтай.

Бүжин намайг тоохгүй байгаад миний сэтгэл ихээр зовнино. Өдөр бүр өмдөө индүүдэж, үсээ самнаж, гутлаа тослож гял цял харагдахыг хүснэ. Сайн хүн болохоо харуулах гэж хүүхдүүдийн өмнүүр гүйж, хамгийн түрүүнд би тэргүүлэгч шүү, надаас өөр сайн хүн байхгүй гэж Бүжинд ойлгуулахыг бодно. Ийм учир өнгөрсөн жилээс миний хичээл, сурлага эрс сайжирч, ангийнхаа хүүхдүүдээс хичээл, сурлагаараа эхний тавд бичигддэг болсон юм.

Үүнд ээж, аав хоёр маань их л сэтгэл хангалуун байлаа. Харин Бүжин бол үгүй. Тэр харин хуучны хичээлдээ тааруу Долгион ингэж шамдан суралцаж, өөрөөс нь өмнө тоогоо бодож багшид үзүүлж, өөрөөс нь илүү сайн дүн авч байгаад дотроо дургүйлхэнэ. Яагаад гэвэл түүнээс илүү онц сурлагатан ангид байх дургүй билээ. Энэ чанараараа бид хоёр адилхан ч юм шиг. Хичээл хийж оролдох тусам нөгөө дургүй ойлгодоггүй байсан хичээлүүддээ дуртай болж, хичээл хийх сонирхол минь улам нэмэгджээ. Бүжинтэй уралдаж тоогоо бодох, шүлгээ цээжлэх илүү дүн авах бүрт Бүжингээс илүү гарч байж, Бүжинд таалагдана гэсэн сэтгэл минь шаналдаг байлаа. Энэ ч аргагүй шүү дээ. Эмэгтэй хүн өөрөөсөө илүү хүчирхэг эрэгтэй хүнтэй хамт байхыг хүсдэг гэж би нэг сонин дээрээс уншсан юм. Ер нь ч тийм юм байдаг болов уу.

Би өөрийгөө толинд харав. Томоос том нүдний шил, онигор нүд, дэлдэн чих цамцаа түлхэн нааш түнхийх бичигхэн гүзээ, нүд рүү унжиж орсон, ямар ч хэлбэр дүрсгүй самнасан урт үс, багадсан цамц, тохой нь цайж урагдах дөхсөн жинсэн хүрэм гээд ер нь миний өөрийн минь бие цогцос болоод өмссөн хувцас минь өрөөлд таалагдах нь битгий хэл өөрөө өөрийгөө харахаас ч ичиж үхмээр амьтан байлаа. Нөгөөх л Бүжинд таалагдах тухай бодол минь толгойд эргэлдсээр...

Бүжин намайг тоохгүй байх олон шалтгаан байлаа. Би гүзээтэй, бөгтөр, царай муутай, нүдний шилтэй. Бас дэлдэн. Намайг хүмүүс маш олон янзаар хочилдог. Гүзээт, Гүзээтбаатар, Бүдүүнээ, Бүдка, Бүдүүн гахай, Гахай, Дэлдэн, Дэлдэн гахай, Бүдүүн шар шувуу, Шар шувуу гэх мэт. Энэ бүхэнд би гутарч байлаа. Турахыг хичээсэн боловч миний чадал хүрэх ажил биш аж.

Нэг удаа надтай адил бүдүүн Болдоотой яаж турах талаар санал солилцов.

- Хөөш Долгионоо байна ш дээ тээ. Ингэсэн байхгүй юу. Манай эгчийн найз Болороо гээд эгч байдаг ш дээ. Нэг их аймаар бүдүүн байж байгаад турчихдаг.

- Тийн. Тэр яасан.

- Тэр ингэж турсан байнаа.

- Яаж турсан гэж.

- Эхлээд Болороо эгч тураах төвд яваад, аэробикоор хичээллээд овоо ганц нэг кг турсан гэнэ.

- Аанхан.

- Тэгээд зөндөө их ядраад байхаар нь маш хурдан турах гээд. Тэгээд бас хуримаа хийх гэж байсан гэсэн. Тураах цай эм авч уужээ.

- Аанхан. Тэгээд турсан уу.

- Байж л бай л даа. Одоохон хэлье.

- За, за.

- Тэгээд тураах цай, эм хоёр уугаад хэд хоносон чинь гэнэт нэг өдөр гэдэс нь гүйлгээд үхэнгээ алджээ. Яг үхэнгээ алдаад арай гэж зүгээр болгоод, ерөөсөө энэ эм цай энэ тэрээ уухаа больё. Би ерөөсөө турахгүй юм байна гэж сэтгэлээр унаж гэнэ. Хуримынх нь өдөр улам л ойртоод байж гэнэ.

Би энэ үед дуугүй л байлаа. Болдоо над руу нэг харснаа яриаг нь дуулгавартай, ихэд сонирхон сонсож байгааг мэдээд цааш нь үргэлжлүүлэв.

- Тэгсэн чинь нэг өдөр Болороо эгчийн эмээ гурван настай ач нь бөгсөө маажгаад байгааг ажаад, “Энэ хүүхэд одоо цагаан хорхойтой болчихсон юм байх даа. Бөгсөө маажгаад байх юм. Энэ чигээрээ удвал турж, эцээд муу ач маань нүднээс гарчихна. Эмчид очиж үзүүлнээ” гэж ярьж гэнэ.

Би дотроо “Заваан юм яриад байх юм, юу ярих гээд байгаа юм бол” гэж бодсон ч бас л дуугүй байлаа.

- Үүнийг сонсоод Болороо эгчийн толгойд нэгэн мэргэн санаа орж ирсэн нь “Цагаан хорхойтой болбол нээрэн турах юм байна. Хүссэнээрээ идэж уугаад ч ер таргалахгүй ямар гоё вэ?” гэж боджээ.

- Тэгээд тэр Болороо эгч чинь цагаан хорхойтоо юу? гэж асуутал Болдоо:

- Тийн. Тэгээд цагаан хорхойтой болсноос хойш аймаар чка эгч болсон ш дээ. Хурим мурим нь их гоё болсон гэсэн гэв.

- Хаанаас цагаан хорхой олсон бол гэж би чин сэтгэлээсээ асуулаа. Дотроо мэдээж турж, Бүжинд таалагдахыг үнэхээр хүсч байсан билээ. Болдоо:

- Эмч дээр очиж цагаан хорхой аваад идсэн байхаа. Би мэдэхгүй гэлээ.

- Пүү, ямар заваан юм. Хүний бөгснөөс гарсан цагаан хорхойг идэж байгаа юмуу, тэр Болороо эгч чинь гэж хэлээд миний дотор ёстой муухайрав. Бөөлжис цутгам. Тэгсэн чинь Болдоо:

- Яадгийм олдвол би ч гэсэн иднээ. Тэгээд сайхан турахгүй юу.

- Битгий заваараад бай. Заваан юм яриад.

- Чи намайг цагаан хорхойтоод турсны дараа атаархана даа. Аягүй бол цагаан хорхойноосоо жааханг өгчих гэж гуйгаад л. Тэгэнгүүт нь би өгөхгүй гээд л. Тэгээд гуйлгаж, гуйлгаж өгөхдөө би “Миний цагаан хорхойг амьдаар нь буцааж өгөөрэй” гэж хэлнэ. Ха-ха инээв. Миний ч гэсэн инээд хүрч хоёулаа бие биенийгээ шоолон элгээ хөштөл инээлдсэн юм.

Харин ихэд сонин нь тэр ярианаас хойш би таргалсаар байхад, Болдоо нэг л тураад байгаа юм шиг санагддаг боллоо. Хааяа нэг яагаад тураад байгааг нь асуухад мань хүн өөдөөс шууд л:

- Үгүй би цагаан хорхой идээгүй гэж мэлзэнэ. Харин надад яагаад ч юм Болдоо худлаа яриад байгаа юм шиг санагдаад болдоггүй байв. Би турах гэж хэчнээн оролдоод ч нэг бол дасгал хийхээс залхуу хүрээд, нэг бол хоолоо сойх гэхлээр ерөөс болоогүй юм.

Ингээд турах гээд болдоггүй. Харин дараа нэг өдөр Болдоо бас нэг өөр санаа надад хэлэв. Гэхдээ энэ бол турах талаар биш, дэлдэн чихээ хэрхэн, яаж засах талаар байлаа.

Болдоод байрных нь нэг найз дэлдэн чихээ яаж зассан түүхээ ярьж өгчээ. Тэгээд мань хүн тэр түүхийг сонсоод надад тус болохыг хичээж, тэр түүхийг ярьж өгсөн юм.

Тэр хүүхэд их дэлдэн гэнэ. Нэг удаа малгайгүй хичээлдээ яваад, гэртээ ирэхдээ чихээ хөлдөөгөөд иржээ. Тэгээд чих нь их хөлдсөн байхаар нь маарлаар ороогоод, хэд хоног явсан байна. Чих нь зөндөө их өвдөж, шархлаад тэгээд эдгэсний дараа тэр жаал боолтоо тайлсан чинь дэлдэн чих нь тэв тэгшхэн болоод эдгэсэн байжээ.

Цагаан хорхой идсэн түүхээс энэ түүх хавьгүй дээр сонсогдлоо. Баярлах ч шиг. Тэгээд энэ аргыг туршиж үзэхээр шийдэв. Болдоо ч надад туслана гэнэ.

Гадаа идэр есийн хүйтэн тачигнаж байлаа. Би гэдэг хүн бүдүүн, бөгтөр, хараа муутай бас дэлдэн. Нэг ч гэсэн согоого засъя л даа, энэ чинь гээд, гараад өгвөө. Малгайгаа гартаа барьчихаад, хүзүүгээ сунгаад хол хол алхаж өгөв. Хажууд Болдоо нэг баруун, нэг зүүн талд гараад л гүйгээд байна.

- Яасан найзаа. Хөлдөж байна уу?

- Мэдэхгүй. Одоогоор мэдрэгдэх юм алга л байна.

Дахиад арван минут алхлаа. Нөгөө Болдоо чинь:

- Яасан найзаа. Яасан найзаа л гээд байна. Хэдэн минут алхаад, тэгээд харин нэг юм чих

хөлдлөө... Хөлдлөө...

- Яая. Ий –ий. Ёстой ямар аймаар часхийж байна аа. Бүр янгинаад байна гэж намайг хэлтэл Болдоо:

- Миний найз тэснэ шүү. Дахиад жаахан тэсчих. Арай хөлдөөгүй байж магадгүй. Сайн хөлдөөж л байж маарлаар боодог гэсэн гэв. Дахиад жаахан байтал бүр их өвдлөө. Нөгөө Болдоо чинь тэс, тэс л гээд байна.

Арван минут өнгөрөв... Чих ямар ч мэдээ алга...

Тэгж, тэгж нөгөө Болдоо чинь:

- Одоо л болсон байх явъя. Гэртээ орж байгаад чихийг чинь бооё гэв. Болдоогийнд оров. Ороод шууд л спирт түрхэж байгаад, маарлаар боочихлоо. Миний чих өвдөж эхэллээ. Халуу дүүгээд, тэгснээ хорсоод л, бамбайж хавдаад л. Өвдөв. Би уйлав. Аймаар өвдөв. Болдоо намайг гаргаж өгөхдөө:

- Миний найз сэтгэлээ барь. Ганц, хоёр хоногийн дараа гоё чихтэй болно. Чамайг охидууд тоож эхэлнэ ч гэх шиг балай, балай юмыг бөөн бөөнөөр ярив. Хэд хоног чих минь асар их өвдөж байсан ч Бүжингээ бодсоор үнэхээр нэг удаа “ёо” гэсэнгүй. Ээж аав хоёр хөдөө явж, тэд эзгүй таарсан тул чихний талаар эгчээс өөр лавлах хүнгүй. Харин эгч намайг унтсан хойно орж ирээд, өглөө гарахад сэрээгүй унтаж таарна.

Чихнийхээ боолтыг Болдоо, бид хоёр хааяа нэг солино. Солихдоо чихээ байнга хатуу хавгастай номоор дараастай. Чихээ ер хөдөлгөхгүй их нарийн үзнэ. Чихнээс шүүс, мүүс гарч өвдөж байгааг ч үл хайхран эгчид үзүүлэлгүй байсаар, бас унтахдаа хатуу хавгастай ном чихээрээ даран дэрлэж унтсаар хэд хонолоо. Өвчин нь гайгүй болов. Болдоо, бид хоёр боолтоо авахаар шийдлээ.

Толины өмнө зогсоод боолтоо тайлав. Дотроо хайрт Бүжингээ бодон, гоё чихтэй болгож өгөөч хэмээн бурханаас гуйж байлаа. Болдоо миний боолтыг тайлж байх зуураа бас л дотроо миний найзын чихийг гоё болгож өгөөч хэмээн гуйж байгаа нь илт. Ингээд тайлаваа. Хамгийн сүүлчийн ороолтыг тайллаа.

Би тэссэнгүй ид шидийг зориг зүрхтэйгээр харж чадалгүй нүдээ аньчихав. Болдоо миний чихэнд “Нүдээ нээ, нүдээ нээ” гэж шивнэв. Нүдээ нээлээ. Би нүдэндээ ч итгэсэнгүй. Толинд дэлдэн гахай биш. Дэлдэнгүй гахай харагдах нь тэр. Ямар гоё вэ?

Амьсгаа ч авч чадахгүй шахам зөөлөн хөдлөн, тэв тэгшхэн чихээ барихаар гараа явууллаа. Чих маань үнэхээр тэгшхэн болжээ. Жаахан чичигнээд ч байх шиг. Тэгтэл яасан гээч. Яасан гээч. Яасан гээч. Гэнэт чих маань хоёр тийшээ нэгэн зэрэг, нэг хөдлөлтөөр махийж орхив. Урьдахаасаа илүү махигар, дэлдэн.

Болдоо руу хартал ертөнцийн гайхамшгийг бүтээгч, илбэчин шиг маадгар зогсож байсан хүн чинь бүр гайхаад, бас надаас айгаад шалчийж орхилоо.

Би одоо зүгээр нэг дэлдэн биш бүр дэлдэнээс дэлдэн, махигар чихт болжээ, хөөрхий. Болдоо руу нэг уурлах гэснээ энэнд уурлаад ч яах билээ гээд болив. Одоо Бүжин намайг тоохоос бүр өнгөрчээ...

Чихний түүх бүтэлгүйтлээр дууссан ч гэлээ би сайхан залуу болох хүслээсээ салсангүй. Урьд нь хувцас хунартаа анхаарал тавьж шинэ сайхан хувцас авах юмсан, энэ тэр гэж боддоггүй байсан бол энэ талаар бодох болж, ээждээ хэлсэнд, ээж ч намайг дэмжин шинэ хувцас авч өгөхөөр болсон юм. Арга ч үгүй биз, ойрдоо хувцас хунар авалгүй удсаныг минь тэр ойлгож байлаа.

Гоё сайхан, булчинлаг, тэгш бие, өргөн цээжтэй ах нарыг дуурайн бялдаржуулах төвд дасгал хийж эхлэв. Үсээ тайрч пинтүү буюу спорт маягаар засуулж, өмсөх хувцсаа ч арай орчин үежүүлж байнга өмсдөг байсан хуучин жинсэн хүрэм, шулуун индүүдлэгтэй өмдөө өмсөхөө больж, эгчтэйгээ хамт дэлгүүр хэсч нэг их үнэтэй биш ч аль гоё, сүүлийн үеийн гэсэн хувцаснаас авч өмслөө. Шинэ хувцас өмсөж, үсний шинэ засалттай болсон намайг нэг өглөө л шал өөр болсонд ангийнхан маань болоод бүр гэрийнхэн маань ч “Энэ Долгион юу болоов” гэж уулга алдацгаасан нь мэдээж. Бага зэрэг эвгүй байсан ч би өнөөх “Бүжин” гэсэн үгээ амандаа давтсаар л...

Амьсгаа давчдуулж, хөлс цувуулах биеийн тамирын заал. Хүн бүр өөрийн хийх ёстой зүйлсийг чанартай сайн хийхийг чармайж, амьсгалаа зөв авч, зөв гаргаж, дасгалынхаа хэмнэлийг алдахгүйг хичээнэ. Булчин, шөрмөс нь зангирсан ах нар том том хүнд туухайнуудаар сүрийг үзүүлэн, чанга чанга тоолон дасгалаа хийхэд, бидний үеийн бяцхан булчинтангууд болоод охид, бүсгүйчүүд тэднийг шагшин харцгаана. Өөрийг нь хүмүүс анхааран харж, дасгалаа хэрхэн яаж хийж байгааг нь шохоорхсоныг анзаарсан ах нар улам ч ихээр хүчлэн тэр хүнд төмрүүдийг өргөх ажээ. Хийж дуусаад, хэсэг завсарлах зуур “мангар” булчингуудаа толинд гаргаж харна. Хийснийхээ дараа хөөсөн булчингаа өөртөө болоод бусдад харуулах бүр дуртай. Түүнээсээ сэтгэлийн таашаал авч, цаашид бэлтгэл хийх урам зоригтой болдог шиг санагдана.

Би чухам л тэр ах нар шиг болохыг хүсэв. Эхний хэдэн өдөр бие булраад, шантарна. Гэвч би энүүхэн зэрэгт шантарна гэж үү, хэрэв энүүхэнд шантарвал тэр эгч нар, тэр ах нарыг хардаг шиг Бүжин намайг харахгүй байх хэмээн бодогдоно. Тийм учир би бүх зүйлээ Бүжингийн төлөө хийж байв. Дасгал хийж байхдаа өөрийн эрхгүй гар сулраад даахгүй болж, гар тавих гээд байгаа агшинд “Бүжээн. Би чамд хайртай. Хэрэв энийг хийхгүй бол Бүжингээр өөрийгөө хайрлуулж чадахгүй” хэмээн бодно. Би өөрөө өөртэйгөө тэмцэж байв.

Цаг хугацаа урсан өнгөрсөөр нэлээд хэдэн сарыг ардаа орхив. Дасгалаа таслалгүй хийж, байнга хичээллэсний үр дүн гарч, миний цээж хуучнаасаа мэдэгдэхүйц томорч, гэдэс татарч, шанаа өргөсөөд, бас явдал суудал ч арай өөр болсон байлаа. Үеийнхнээсээ угаас том биетэй, өндөр, махлаг байсан миний бие улам ч зузаан харагдах болж, ангийнхан дотроо хамгийн түрүүнд эр хүний төрх суув. Мөн хичээлээ ч сайн хийсээр байлаа.

Спорт гэдэг агуу их зүйл ажээ. Өөртөө итгэх итгэл минь өндөрсөж, улам л ихийг хийж, улам л хүнд юм өргөхийг хичээх болов. Том штангны дор орчихоод цээжний дасгал хийж байхад даахгүй үе зөндөө гарна. Тэгэх бүртээ “Бүжин” хэмээн дотроо шивнэн, эгээ л эх орныхоо

төлөө гэдэг шиг “Бүжингийн төлөө” хэмээн өргөхөд би даадаг байлаа. Бүжингийн төлөө бүхнийг хийж эхэлсэн минь энэ. Бас нэг сургуулийнхан маань крос гүйлтэнд гүйв. Би Бүжинд өөрийгөө харуулах гэж нэлээд чармайлаа. Амьсгаа давхцаж, хөл гуйвсан ч, би гүйсээр л байлаа. Тэгээд нэгдүгээр байранд орж, өөртөө сэтгэл хангалуун үлдэв. Энэ бүхэнд миний амны уншлага, шившлэг “Бүжин” хэмээх үг ихэд нөлөөлсөн нь мэдээж. Ийнхүү Бүжингийн төлөө гэж бодсоор байгаад сүүлдээ Бүжин хэмээх бодит хүний тухай бодохоо больж, харин түүний оронд Бүжин хэмээх бурхантай болсон юм шиг болов.

Урьхан хаврын бороо асгарсан нэг өдөр 8А ангийн хэсэг төлөөлөгчид болох бид ангийнхаа багшид бэлэг авахаар дэлгүүрээр явсан санагдана. Харин энэ өдрийн өглөө бид хамгийн сүүлийнхээ улсын шалгалтыг өгч дуусгасан байлаа. Шалгалтын дараа бид “...сүүлчийн хонх.” хэмээн анги хамт олноороо дуулж, хонхны баярынхаа тухай, ирээдүйд ямар хүмүүс болцгоох тухайгаа ярьцгаасан юм. Харин би Бүжинг л ажиж байлаа. Түүний минь хөөрхөн алаг нүд, инээмсэглэл дүүрэн царай, ер юу гэж ч зураглах юм, бүх л тэр хөөрхөн, сайхан шинж төрхүүд рүү өөрийн мэдэлгүй би харц унаган суув. Дотор минь нэг л бодол. “Би чамд хайртай!” гэж хэлэх. Одоо би арван таван настай. Наймдугаар анги төгсөж байна. Есдүгээр ангиас манай ангийн бараг бүх хүүхдүүд өөр сургууль руу шилжицгээнэ гэсэн. Тэдэн дотор Бүжин маань ч шилжинэ. Хэрэв шилжчихвэл, би түүнийг өөртөө хайртай болгож чадаагүй ч гэсэн, өөрийг нь хайрладаг байсан гэдгээ мэдэгдэх хайрын үг болох “Би чамд хайртай!” гэж хэлж чадалгүй явуулах болоод байдаг. Гэтэл хэзээ хэлэх вэ?... Би хэлж чадах болов уу?... гэдэг үнэхээр хариулахад хэцүү асуулт.

Ингээд би Бүжинг ангиас дуудан гаргаж ирэв. Сэтгэл хөөрч, догдолсон нь ойлгомжтой. Нуруугаар хүйтэн хөлс ч цувах шиг. Олигтойхон амьсгал ч авч чадсангүй.

- Бүжээн. Чи наймаа төгсөөд, тэгээд шилжих гэж байна уу? гэж асуухад:

- Шилжих байхаа. Юу гэж? гэж үл тоомсорлосон байдалтай хариулав.

- Зүгээр л гээд нөгөөх үгээ яаж хэлэх учраа олж ядан :

- Чи тэгээд нээрэн шилжих гэж байгаа юм уу? гэхэд миний нүд рүү цоо ширтэж, дээгүүр харан:

- Тийм. Шилжих байх гээд байна ш дээ. Юу асуух гэсэн юм гэж уцаарлангуй хэлэхэд би дахиад л эргэж буцан:

- Зүгээр л. Гэтэл энэ үед Бүжин миний дэмий шахуу юм асуусанд уурласан бололтой.

- За,за. Надаар битгий тоглоод бай. Би явлаа гээд ширэв татаад гүйж одов. Би дэмий амаа ангалзуулж, гараа савлан хоцорсон юм.

Би урьд нь нэг удаа Бүжинг кино хамт үзье гэж гуйсан юм. Тэгсэн тэр:

- Би юу боллоо гэж чамтай хамт кино үзэх юм гээд ер халгаагаагүй. Хүн өөдөөс хэдэрлээд, эсвэл үл тоомсорлосон байдал гаргаад байхаар би яаж ч хайраа илчлэх билээ дээ. Уг нь би

арай дэврүүнээр төсөөлж байсан юм.

- Бүжээн гэж намайг дуудахад, тэр минь:

- Аан... гэх буюу эсвэл:

- Юу... гэж намуун зөөлнөөр хэлж, миний амнаас ямар үг гарах бол хэмээн тэсэн ядан хүлээж, энхрий дөлгөөхнөөр над руу ширтэж, “За, тэгээд хайртай гэж хэлээч дээ” хэмээн дотроо догдлон бодож байвал маш сайхан.

Тэгээд:

- БИ ЧАМД ХАЙРТАЙ! гэж хэлээд:

- Хоёулаа үерхье гэж хэлэх байлаа. Тэр зөвшөөрч, эсвэл шууд хэлэхээс татгалзаж:

- Би жаахан бодъё гэхэд би түүнд бодох боломж олгох байсан болов уу. Гэтэл тэгсэнгүй, тэгэх боломж ч байсангүй. Надад Бүжин их хүйтнээр хандлаа. Гайхалтай. Би түүний төлөө ихийг хийж, бүхнээ зориулж байгаа юм шиг санагдана. “Гэтэл тэр” гэхээс дотор муухайрна. Юу ч болсон бай. Миний хайр бүтэхгүй ч бай. Би түүнд өнөөдөр заавал хэлэх болно. Энэ гуравхан үгийг л хэлчихвэл дотор уужрах юм шиг...

Бороо шаагин орсоор, гудамж талбайд хүмүүс бороонд норохгүйг хичээн гүйлдэцгээнэ. Би Бүжин, Болдоо, Тэмүүлэн, бас хэдэн охид, бид хэд багшдаа ямар бэлэг авахаа тохирч чадсангүй. Охидууд болохоор ваар, гоёлын жижиг сажиг зүйл авч өгье гэж санал гаргасан боловч, хөвгүүд бид зөвшөөрсөнгүй. Арай өөр, гоё юм авч өгье гээд дэлгүүрүүдээр явж байгаа минь энэ. Манай хотын дэлгүүрийн гудамж болсон гурав, дөрөвдүгээр хорооллоор явцгаав. Бороо шаагин орсоор байсан ч хүмүүс гудамжаар гүйлдэцгээсээр...

Бэлэг сонгоход үнэхээр хэцүү байв. Гоё сайханд нь бидний мөнгө хүрэхгүй ажээ. Тэгж явсаар миний саналаар уран зохиолын түүвэр зохиолоос нэлээд хэдэн боть авахаар болов. Мэдээж намайг ийм санал гаргасанд Бүжин дургүйцсэн боловч, бусад нь дэмжсэнд яалт ч үгүй бууж өгөн миний сонгосон бэлгийг авсан юм.

Дараа нь бид гэр, гэрийн зүг харьцгаах болов. Бүжингийн гэр эндээс холгүйг би мэднэ. Хүүхдүүд явж явж сэтгэлд таарсан бэлгээ олсонд баярлан, урам зоригтой алхацгааж байв. Ангийн хүүхдүүд нэг нэгээрээ гарч ирэн багшдаа цэцэг бариад, бас нэг нэг ботин дээр гарын үсэг зурж багшдаа дурсгана гэж төлөвлөцгөөв. Ингээд би Бүжинг бас л дуудлаа. Ангийнхныгаа та нар явж бай гэж хэлэв. Харин энэ удаад найз нар маань бид хоёрыг “Яах гэж байгаа бол” гэцгээн, эргэн эргэн харсаар цааш алхацгаалаа. Бүжин энэ бүхэнд гайхсан байдалтай хандана. Би энэ удаад арай зоригтой байхыг хичээв. Ашгүй Бүжин инээж байлаа.

- Бүжээн гэж чанга хэлээд:

- Би ... Би чамд... гэж хэлэх гэтэл тэр:

- За, за. Манайх энд. Би явлаа. Баяртай гээд зам хөндлөн гараад гүйчихэв. Бүр дургүй хүрч

үхмээр. Намайг тэр юман чинээ бодохгүй, надаар тоглоод ч байгаа юм шиг. Ямар ч байсан би хэлж санаагаа амраая гэж бодоод:

- Би чамд хайртай! Хайртай шүү гэж чанга орилов. Хэлж чадлаа. Нүдэнд нулимс хурна. Одоо бүх юм надад хамаагүй, өнгөрлөө гэж бодов.

Харин Бүжин миний энэ үгийг сонссон уу, үгүй юу бүү мэд. Тэр над руу эргэж ч харсангүй. Гудамжаар бороонд норохгүйг хичээн гүйлдэж, яаран алхацгааж байсан хүмүүс намайг “Хайртай” гэж чангаар орилоход бүгд зог тусан ”Хүүе юу болов” гэсэн мэт над руу асуусан байдлаар харцгаана. Би уйлаад байгаа юм уу, эхэр татаад ч байгаа юм шиг. Дотор харанхуйлна. Ер бүү мэд. Манайхан гүйлдэн ирцгээв. Бүгд л:

- Долгионоо. Яасан. Юу болов? гэгцгээн сандарцгаана. Охидууд нулимсыг минь арчиж өгнө. Тэд юу болоод байгааг ер ойлгохгүй. Намайг ямар их шаналж байгааг бүр гадарлах ч үгүй. Хажуугаар өнгөрөх хүмүүс намайг шоолон инээлдэцгээнэ. Би ичиж эхлэв. Бүжингийн хойноос харвал тэр байшингийн булан тойроод алга болжээ. Яагаад, яагаад тэр надад ийм хатуу хандана вэ? Тэр намайг ингэж их үзэн ядтал нь би түүнийг хайрласан юм гэж үү? ...

... Гэхдээ тэр миний хэлснийг сонссон болов уу?...

Харин найз нар маань сонссон нь ойлгомжтой...

5. Бүжингүйгээр би амьдарч чадна

Бүжинг би үзэн ядах болов. Хэдийгээр тэр надад үнэн голоосоо дургүй, Долгион гэхээр л “Өнөөх бүтэлгүй амьтан” гэж боддог нь надад таалагддаггүй ч, би түүнд үнэхээр хайртай байсан юм. Харин одоо тэр их үл тоомсорлолт, намайг жигших бодол, үргэлж доошхийдэг харц, энэ бүхэн бүгд надад хамаагүй болсон байлаа. Хүйтэн бороон дунд хайртай гэж хэлж, уйлж шившгээ тарьсан ч би түүнд хайртайгаа ойлгуулах гэж, миний хэлсэн үгийг сонсоогүй байх гэж бодон энэ явдал болсны дараахан түүнд захиа өгсөн юм. Зориглож бичсэн захиаг минь ойшоогоогүй. Гэхдээ би тэр удаад аймхай, хулчгар зангаа мөн л гаргаж, найз Мөнхөөгөөрөө дамжуулуулсан юм. “Би чамд хайртай. Би хар багын л чамд сэтгэл татагдсан. Миний хайрыг хүлээн авч, надтай үерхэхийг зөвшөөрвөл чи над руу утсаар яриарай” гэж бичээд өгсөн санагдана. Мөнхөө ч олон охид дунд сууж, тэдэнд их л сонирхолтой зүйл ярьж өгч байсан Бүжинд тэр дор нь л аваачиж өгсөн. Хүүхдүүд биднийг ажаад л. Харин Бүжин үүнийг анзаарсан бололтой. Захиаг минь уншаад, гайхсан байдалтай Мөнхөө рүү нэг хараад, дараа нь над руу бас харав. Мэдээж, охидууд захиа руу нь өнгийн харцгааж, шоолон инээлдэцгээнэ. Бүжин их л додигор, бусаддаа гайхуулан захиаг уншиж байсан санагдана. Тэгээд тэр босч, Мөнхөө дээр очин нэг юм хэлэв. Мөнхөөгийн хацар нь улайгаад ичиж байна гэж жигтэйхэн. Сандраад над руу гөлөлзөөд байв. Би их шаналж байв. Юу гэсэн бол?...

Охид Бүжинг дэмжин, бие бие рүүгээ харан инээлдэж, Бүжин Мөнхөөд юу гэж хэлж байгаа бол хэмээн догдлон хүлээцгээж байгаа нь илт. Мөнхөөгийн чихэнд Бүжин нэг юм хэлээд, буцаж байрандаа суув. Охидууд түүнийг бүчин авцгааж, Бүжин тэдэнд гайхуулан ярих нь ойлгомжтой. Харин би Мөнхөө рүү ухасхийв.

- Юу гэж байна вэ? хэмээн цээжээ оволзуулан, сандран асуутал Мөнхөө:

- Үгүй гэнэ ээ гэсэн юм. Ингээд миний анхны хайр бүтэлгүйтдэг байжээ гэж бодов. Бүжинг үзэн ядаж эхэлсэн минь тэр. Яагаад? Яагаад тэр намайг ингэж их үзэн ядна вэ?

Үүний дараа амиа хорлочихмоор санагдаж байсан удаатай. Гэхдээ би олон юм бодсон. Ээж, аав, эгч, эмээ, найз нар... би тэдэндээ дэндүү их хайртай юм билээ.

Ер нь хүн болж, ертөнцөд мэндэлнэ гэдэг гайхамшиг. Өчүүхэн жижиг бодлоор өөрийгөө чамлах шиг харанхуй зүйл үгүй билээ. Тэр тусмаа нас залуу цус шингэнд харанхуйд автах шиг муухай зүйл үгүй. Гудамжинд хог түүгээд, томчуулд чичлүүлээд явж байгаа үеийнхээ хүүхдүүдийн дэргэд миний зовлонтой амьдрал ч гэж юу билээ.

Ингээд наймдугаар ангиа төгслөө. Бүжинтэй ч уулзалдахаа болив. Зуны амралтаараа хөдөө явж, амралтаа өнгөрөөв. Хөдөө байдаг ах дүү нар маань бүгд л миний том болсныг гайхаж, хөрш айлын миний үеийн хөвгүүдтэй барилдуулж үзнэ. Би ч хуучин үргэлж унадаг байсан бол энэ жил харин ч бүгдийг нь давдаг болжээ. Тэгэхэд ах нар маань их баярлацгаана. Морь, мал, айраг, тараг гэсээр нэг л мэдэхэд намар болж би гэртээ харив. Зун нүд ирмэх зуур өнгөрсөн билээ. Энэ зун би Бүжингийн тухай нэг ч удаа бодоогүй гэвэл худал. Би түүнийг бодсон. Бидний хооронд яагаад ийм хүйтэн харьцаа үүссэнийг бодсон. Бүх зүйл надаас болсон мэт санагдана.

Бага ангид байхаас би ангийн атамаанаар өргөмжлөгдөж, өөрийгөө их нэр хүндтэй, аймар хүнд тооцдог байлаа. Багадаа ангийнхаа охидын хажуугаар өнгөрөхдөө ганц нэгийг нь шоглож, үс гээгнээс нь зулгаана. Шал худлаа хэрнээ уурласан дүр үзүүлж, муухай орилоход охид, хөвгүүд бүгд “жигжэрч”, бараг бүгд номхон зогсдог байлаа. Ангийн атаманаа үзэх гэж хэд хэдэн удаа ангийнхаа хөвгүүдтэй зодолдсон санагдана. Тэр бүрт манай ангийн Отгоо “тэмцээнийг” зохион байгуулдаг байв. Отгоо манай ангийн ганц нэг банди нар дээр очиж, тэр нь ихэнхдээ манай ангийн хоёр, гуравдугаар атаманууд, тэгээд:

-Чи одоо Долгионоос лаг болсон ш дээ. Долгион юу юм бэ? Дандаа дээрэлхэж байна. Чи Долгионыг зодчихооч. Тэгвэл чи ангийн атамаан болно ш дээ гэх. Харин нөгөө нөхрийн зүрх нь хөөрдөг юмуу, бүү мэд, “Тэгье” гэж зөвшөөрснөөс зодоон эхэлнэ. Эхэлнэ ч гэж дээ. Отгоо над дээр ирээд “Нөгөө хэн чамайг ална гэнээ” гэнэ. Тэрхэн зуур надад эмээх сэтгэгдэл төрөх боловч, атамааныхаа байр суурийг хамгаалахын тулд хичээл тараад, сургуулийн хажууханд орших цэцэрлэгийн хашаанд атамааны төлөө өрсөлдөх нөхрийг тулаанд дууддаг байв. Ингээд хичээлийн дараа зодоон болно. Хүүхдүүд зодоон үзэх гээд шавчихна. Нөгөө ангийн “Нөлөө ихтэй атаманууд” зохицуулаад л, хөгжөөн дэмжигчид хөөргөөд л. Гоё юм болно доо.

Зодоон эхлэвч, хүн амьтан хөгжөөчихөөр сонирхолтой зүйл болохгүй. Би хэд сайн цохиулж аваад, өрсөлдөгчөө тэвэрч газар унагаад дээрээс нь цохино. Дор орсон нөгөө нөхөр маань толгойгоо тэврээд цохиулж гарна даа. Хааяа нэг өшиглүүлнэ. Тэгээд ялагдагч уйлсан, хамраас нь цус гарсан, эсвэл нүднээс нь нулимс дуссан бол тэгээд гүйцээ. Би атамаан. Би ялагч болдог байлаа.

Гэхдээ ангийн атамаан байх хэцүү. Дээд ангийнхан гүйж ирээд “Хэн чинь атамаан бэ?” гэхлээр манайхан намайг заагаад өгчихнө. Нөгөөдүүл нь намайг хэд дэлсээд авахад, атамаанаа зодуулсан манай ангийнхан юу ч дуугарч чадалгүй мөнгө, төгрөг, үзэг балаа “бариулна”. Хамгийн түрүүнд атамааныг жижигрүүлчихвэл бусад нь жижгэрдэг гэдгийг “бариачид” андахгүй. Тэгээд мөнгө, төгрөгөө бариулсан хүүхдүүд дараа нь “Атамаан хөдлөөгүй болохоор бид хөдөлж эсэргүүцээгүй юм. Хэрэв чи эсэргүүцэж зодолдсон бол бид зодолдох байсан юм” гэх. Хамаг буруу нь над дээр тохогддог байлаа. Би ангийнхандаа л атамаан болохоос дээд ангийнханд атамаан биш шүү дээ. Даанч тэд үүнийг ойлгохгүй нь харамсалтай.

Энэ бүх атамааны асуудлаас болоод би багаасаа л ангийнхныгаа айлгадаг гэдэг ойлголт толгойдоо авчихсан учир охидууд, хөвгүүдгүй бүгдийг нь захиргааддаг байлаа. Бүгд надаас айна. Гэхдээ ганц л хүн надаас айдаггүй байсан санагдана. Тэр нь Бүжин. Ангийн дарга байсан Бүжин үргэлж надтай тэрсэлдэнэ. Би ч бууж өгөхгүй. Анги дэвшиж томрох тусам миний атамаан зан дарагдаж, ангийнхныхаа нэгэн адил болсон боловч, Бүжинтэй тэрсэлдэх зан минь арилаагүй юм. Би үргэлж Бүжинг дотроо дэмжиж, тусладаг боловч Бүжинд л үүнийгээ харуулахыг хичээхээс бус бусад найз нартаа Бүжинтэй би хонь, чоно гэж харагдахыг хичээдэг байв. Харин Бүжинд би өөрийнхөө хайрыг буруугаар ойлгуулсан болоод ч тэрүү. Тэр намайг үзэн яддаг нь тодорхой болсон билээ. Түүний надад хандах энэ хандлагыг би өөрчилье гэж бодох боловч, мөхөс би юу хийж чадах билээ.

Ингээд би есдүгээр ангид орлоо. Хуучин сургууль маань бүтцийн өөрчлөлт хийн цогцолбор сургууль болж, шинэ багш нар, шинэ хүүхдүүдээр дүүрсэн юм. Иймд би ангийнхаа

хүүхдүүдийн нэгэн адил сургалт сайтай гэсэн сургуульд шилжив. Учир нь энэ жил хуучин сургуульдаа үлдэх нь ямар ч утгагүй асуудал байлаа. Хуучин багш нар, хуучин ангийнхандаа дассан миний бие тэдэнгүйгээр хуучин сургуульдаа явах хэцүү санагдаж, тэгээд ч шинэ багш нарын мэдлэг боловсролд эргэлзэж байсан болохоор шилжсэн минь тэр. Нэгээс наймдугаар анги төгстөл тохой залган суусан ангийн андууд минь ийнхүү салан одоцгоов. Тэдний дотор мэдээж Бүжин ч сургуулиасаа шилжжээ.

Тэр минь үе үехэн бодогдож, би түүнийг маш ихээр санана. Шинэ сургууль дээр нь очиж уулзах юмсан гэж бодох боловч, нөгөө л хүйтэн хөндий харьцаа намайг тосох байх хэмээн эмээнэ.

За, ингээд шинэ сургууль, шинэ ангид шилжин ирэв. Би ч манаргаж гарлаа. Хичээл номоо сайн давтаж, бялдаржуулах клубтээ явсаар байв. Миний амжилтууд ч ахиж, анх би цээжний шахалт хийдэг дасгалд ердөө л гучин килограммыг өргөдөг байсан бол одоо үүнийгээ гурав дахин хүндээр хийх болжээ. Бас шинэ анги, шинэ найзуудтай болж, тэдэнтэйгээ дотносов. Намайг шинэ хүүхэд гэж тэд гоочилсонгүй, би ч шинэ гэж өөрийгөө биеэ барьсангүй. Харин Бүжин бодогдсоор л.. Сүүлдээ бүр түүний тухай улам их бодож, галзуурч байгаа юм шиг санагдана. Тэгж их шаналахаар сэтгэл, зүрх үнэхээр хөндүүрлэдэг юм билээ. Гэхдээ би Бүжингүйгээр амьдрах ёсонд суралцаж байв.

Хуучин “Бүжингийн төлөө” гэж бодон хийдэг байсан бүх зүйлээ, одоо ямар ч юм бодолгүй, мөн эргэлзээгүй хийнэ. Бүжинг биш шинэ сургуулийнхаа, шинэ охидыг сонирхохыг хичээнэ...

Бүжинг хамгийн сүүлд харснаас хойш бараг жил хагас өнгөрчээ. Би одоо бараг түүнийг бодохоо больсон байв. Гэхдээ бүр бодохоо больсон гэвэл худал. Жил хагасын хугацаанд миний бие өсч, ухаан ч жаахан тэлсэн санагдана. Бас өөртөө итгэлтэй болж байлаа. Мэдээж, энэ бүхэнд гайхамшигт спорт нөлөөлсөн.

Одоо би аравдугаар анги.

Өнгөрсөн хугацаанд би хоёр охинтой үерхжээ. Гэхдээ энэ бүхэн бүгд л тааламжгүйгээр төгссөн байлаа. Тэдний хэнтэй нь ч би таарч тохирсонгүй. Эхнийхийг нь бол найз охин гэж хэлэхийн ч аргагүй. Би ядаж хацар дээр нь ч нэг үнсээгүй салсан. Хэ-хэ.

Хоёрдахийнх нь ааш, зан яваандаа надад танигдсан хэрэг. Эхэндээ их сонирхолтой байсан боловч, эцэст нь тэд бүгд Бүжинг минь гүйцэхгүйг би ойлгоно. Ингээд л салдаг байв. Харин тэр охидууд Бүжинг мартагнахад их тус болсон мэт санагдана. Би Бүжинг бараг мартаж байлаа. Түүнгүйгээр амьдарч чадна гэдэгтээ итгэж эхэлсэн юм.

6. Улаан хүрэмтэй охин

Аравдугаар анги төгсөх дөхөөд, хүүхдүүд бүгд завгүй. Удахгүй улсын шалгалт, тэгээд их, дээд сургууль, коллежийн элсэлтийн шалгалт гэхлээр тэдний үстэй толгой арзайх нь ойлгомжтой. Хүний амьдралыг шийддэг хэдхэн алхмуудын нэг бол аравдугаар анги төгсөж сургуульд орох явдал билээ. Харин Долгион миний бие ихэд додигор байв. Би элсэлтийн шалгалтын тухай огтхон ч санаа зовсонгүй. Учир нь би энэ жил олимпиадад амжилттай оролцож, дуртай сургуульдаа орох эрхээр шагнагдсан байлаа. Иймд надад зөвхөн аравдугаар анги төгсөх шалгалт л үлдээд байсан учир зав чөлөө их гарч байв. Би жолооч болохоор шийдэж, жолооны курст бүртгүүлэв. Аавынхаа муу “Өвгөн бенз”-ийг хааяа хулгайлж унахдаа гаршаад байсан миний бие жолооны үнэмлэхтэй болохыг хорхойсоод байсан үе л дээ.

Нэг удаа хотын жолоонд гарч, сургалтын экселийнхээ хүрдийг дураар мушгин, хурд мэдэн давхиад багшдаа чихдүүлээд багагүй банга хүртэж, тэгээд багшдаа:

- Яая, яасан муухай чимхдэг юм. Боль л доо хэмээн уурсах, тунирхахын хооронд гэрлэн дохионы өмнө зогсож байтал нүдэнд танил улаан хүрэм урдуур минь өнгөрлөө. “Яасан харсан хүрэм бэ?” гээд лавшруулан харвал, хүрэмний эзэн тэр охин мөн ажээ. Тэр охин Бүжин байлаа. Хоёр жилийн өмнө өмсдөг байсан улаан хүрмээ өмсдөгөөрөө өмсөж... Нүүр царай, үс гээг нь яг л хэвээрээ...

Харин тэр намайг олж харсангүй. Хуучны юм сэдрэх нь тэр. Бүжээн би чамд хайртай!

Гэртээ хариутаа л цээжээрээ мэддэг тэр утасныхаа дугаар руу залгав.

- Байна уу?... байна уу?... гэж танил хоолой өөдөөс цангиналаа. Энэ бол Бүжингийн ээж. Би хэсэг дуугүй байснаа:

- Сайн байна уу? Эгчээ, Бүжин байгаа болов уу гэтэл тэр:

-Миний дүү Бүжин нь байхгүй байна аа. Давглагандаа явсан. Оройхон залгаарай гээд утсаа тавьчихав. Бие нэг л эвгүй. Зүрх “түг түг” гээд баярын юм уу, аймшгийн ч юмуу бүү мэд, нэг л хачин хэмнэлтэйгээр цохилно. Бүжин гэхээр нэг л хачин. Түүний инээмсэглэл, түүний хөөрхөн царай, ухаалаг харц нь нүдэнд үзэгдээд л ...

... Бас түүний уур хилэн, үзэн ядах дүр төрх нь намайг айлгана. Бас дургүй хүргэнэ. Яамаар ч юм бэ дээ. Мэдэхгүй.

Тэр орой би Бүжин рүү залгасангүй. Гэхдээ ямар ч л байсан залгахаар шийдэв. “Яахав дээ. Ямар болж вэ? гэж ядаж сонирхоё л доо” гэж бодов. Шийдэж ядан байсаар миний сайн өдөр баасан гаригийн орой түүн рүү залгалаа. Би өөрийгөө өөрчлөгдөж, том болсон гэж бодож байсан боловч хуучны Долгион хэвээр аж. Бас л жаахан сандрав.

- Байна уу? Бүжин үү? гэхэд:

- Тийм байна. Хэн бэ?

- Би Долгион байна аа...

- Аан... гээд чимээгүй болчихов.

- Байна уу?

-...

- Би Долгион байна аа. Байна уу? Чи яваа? гэж хэлэхэд сая л нэг юм:

- Аан. Сайн уу?

- Сайн. Юу байна.

- Юмгүй ээ гэж хөндий дуугарав.

- Хичээл ном нь сайн биз дээ?

- Сайн. Сайн. Чи юу гэж ярьж байна гэж надаас асуув.

- Зүгээр л. Чиний мэндийг мэдэх гэж гэхэд:

- Чи хэзээнээс миний мэндийг мэддэг болоов?

- Их эртнээсээ. Би чиний мэндийг өдөр бүр л мэддэг шүү дээ.

- Худлаа яриад л.

- Нээрэн. Би чамайг өдөр бүр л хардаг. Чи л намайг таньдаггүй болохоос.

- Худлаа яриад л. Чи бид хоёр хаана тааралдсан юм бэ?

- Өдөр болгон л МУИС-ийн тэнд чи явж байдаг ш дээ.

- Нээрэн би чамтай тааралддаг гэж үү?

- Өдөр болгон. Бүр өдөр бүр шүү. Чи нөгөө улаан хүрэмтэйгээ, бас нэг хар цүнх барьчихсан явж харагддаг. Би ангийн чинь үүдэнд чамайг хүлээж байгаад уулзах гэхээр чи даанч намайг таньдаггүй гэж намайг залахад:

- Нээрэн тийм үү? Чи манай хичээл ордог ангийг мэддэг юм уу? гэж асуув. Гайхаж байгаа нь илт. Би ч:

- Чи яагаав. Давтлаганд яваад байгаа шүү дээ. Тэр ангийг л би хэлж байна гэж бас заллаа. Бүжин ихэд гайхаж байгаа нь илт. Намайг их өөр болсон гэж бодож байгаа бололтой.

- Чи тэгээд тийм их өөрчлөгдсөн юм уу? гэхэд:

- Би ч уг нь өөрийгөө өөрчлөгдөөгүй л гэж бодоод байгаа. Хүмүүс л намайг их өөр болж, том залуу болж л гээд байгаа хэмээн өөрийгөө рекламдаж орхив. Ичих ч шиг.

- Аан. Тийм үү? Тэгээд өөр зүйлгүй юу? гэж Бүжин хэлэв.

- Өөр зүйлгүй ээ. Чи сонин сайхнаасаа ярь л даа гэж намайг лавшруулан асуухад:

- За, за. Дараа ярья. Хоолоо ид гээд ээж дуудаад байна гэв. Би ч гэсэн:

- За тэгье. Баяртай гэхэд тэр:

- Баяртай гээд утсаа тавьлаа. Би инээв.

Бүжин надтай урьд нь үргэлж хүйтэн хөндий харьцаж, миний хэлсэн үгийг тоомсорлодоггүй байсан бол, энэ удаад миний ярьсанд ихэд гайхсанаар барахгүй, утсаа тавихдаа хүртэл “За. Дараа ярья” гэдэг байна ш дээ. Дараа ярина аа гэж... Ха-ха!

Ингээд би Бүжинтэй утсаар ярьдаг болов. Аль болох хөгжилтэй юм ярьж, түүнийг инээлгэхийг хичээнэ. Энэ оролдлого маань ч амжилттай болж, түүнийг инээлгэж, хөгжөөж чадна. Иймэрхүү маягаар ярьсаар бид хоёр бараг гурвансар шахуу болсон юм. Гэхдээ тэр миний “Хоёулаа уулзъя” гэсэн үгэнд үргэлж “Үгүй” гэж хэлдэг байв. Би түүнийг элдэв янзаар гуйхгүй байхыг хичээнэ. Тиймээс түүний найз Мөрөнгөөр Бүжингийн тухай яриулдаг байв. Харин Мөрөн надад Бүжингийн тухай ярьж өгөх гэж ёстой л өөрийгөө гуйлгаж байгаа юм шиг аягладаг байж билээ.

Энэ гурван сарын хугацаанд Бүжингийн надад хандах хандлага ч өөрчлөгдөж, би Бүжинтэй ярихад урьдынх шигээ сандрахаа больсон юм. Тэгээд би их баяртай. Миний ажил үйлс, сурлага ч өөдрөг байв. Харин хайрын тухай Бүжинд би огтхон ч яриагүй. Хэрэв энэ талаар ярьвал Бүжин уурлах байх гэж бодсон хэрэг. Тэгээд ч би энэ олон жил Бүжинг хайрлаж явчихаад, нэг л өдөр бүхнийг нураахыг хүссэнгүй. Бүжин урьдын адил миний хайрыг үгүйсгэвэл яах билээ. Өнөөдөртөө Бүжинтэй ингэж утсаар ярьж, инээлдэж, хөхрөлдөж байгаа минь надад хангалттай санагдана.

Нэг өдөр би Бүжин рүү залгалаа. Ээж нь утсаа аваад:

- Бүжин байхгүй ээ гээд утсаа тавьлаа. Түүнээс хойш хэд хэд залгасан боловч олигтой хариулт ололгүй бүр сүүлд нь утас нь хариулахаа болив. Бүхэл бүтэн хоёр сарын турш би тууштай залгав. Түүний явдаг зам, гэрийн ойролцоо сахиж зогсов. Харин тэр надад олдсонгүй. Бүжинг би үгүйлж байлаа.

Олон удаа асуусан боловч олигтой юм ярьж өгдөггүй байсан Мөрөн нэг өдөр:

- Бүжин Англи явсан гэв. Миний хувьд энэ нь огт санаанд ороогүй хариулт байсан бөгөөд:

- Хэзээ? гэхэд Мөрөн:

- Хоёр сарын өмнө явсан. Гэхдээ тэр явахдаа надад ч хэлээгүй явсан. Эхэндээ би ч гэсэн чам

шиг Бүжинг хайгаад олоогүй. Тэгсэн чинь Бүжингийн ээж надад хэлсэн. Бүжин ч над руу өчигдөр ярьж байна лээ. Тэнд байдаг найз бандийнхаа хойноос очсон гэж байсан гэв. Энэ нь миний хувьд үнэхээр том цохилт болж, Бүжин яагаад надтай хайрын тухай ярихыг хүсдэггүй байсан учрыг сая л нэг юм ойлгох шиг боллоо.

Бүжингийн талаар бодож байсан тэр сайхан итгэл, хүсэл бүхэн минь унтрав. Тиймээ! Тэр миний Бүжин биш. Өөр хүний хайр байжээ гэсэн бодол толгойд орж ирэн, үе үе санаа алдаж, түүгээр ч үл барам уйлж, “Бурхан надаар ихэд тоглох юм даа” хэмээн гомдоллож байсан юм. Хэдийгээр Бүжин надад юу ч амлаагүй, хайрын тухай ганц үг дуугараагүй ч гэлээ миний сэтгэлд “Тэр надад сайн” гэсэн жаахан ч гэсэн ИТГЭЛ, СЭТГЭЛ байсан билээ. Тэр бүгд минь хөсөр хаягдав. Одоо миний сэтгэлд улаан хүрэмтэй охин зам гаран алхаж байгаа дүр зураг л үлджээ.

7. Захидал

Бүжинг мартахаар, бүр тас мартахаар шийдэв. Мөрөнгөөс түүний тухай сонсоноос хойш би аль болох Бүжингийн тухай бодлоо өөрөөсөө нууж, хааяахан “Тэр найз банди дээрээ очоод жаргалтай сайхан байгаа байх даа” хэмээн тэр залууд нь атаархаж, хорсоно. Гэлээ гээд яах билээ. Би Улаанбаатарт, тэр Лондонд байгаа шүү дээ. Ер нь Улаанбаатарт байсан ч найзтай хүнийг яах ч байсан юм.

Их сургуульд орж, хичээл номоо сайн хийхийг хичээнэ. Олон таван юм бодож сэтгэлээ зовоохгүйг хүснэ. Тэгээд ч их сургуулийн оюутан байх гэдэг амаргүй ажил аж. Хичээлийн жилийн эхний хагасыг чүү ай давлаа. Шалгалтын дараа ядарч байв. Зарим нэг хичээлийг сайн давгаж, заримыг нь ангийнхаа онц сурлагатанаас хуулах аядаад ямар ч байсан арай ч хасагдчихсангүй. Арван жил, их сургууль хоёр тэнгэр газар шиг өөр ажээ.

Амралт эхлээд чөлөө зав ихтэй байсан учир ганц нэг, хоног гэртээ зурагт үзэн хэвтэж байгаад, найзуудтайгаа хамт сагс, бильярд тоглосон шиг өнгөрөөнө. Бас болоогүй ээ. Найз охинтой болов. Бүх зүйл хэвийн болж эхлэн, би ч Бүжинг бодохгүй байхыг хичээнэ. Одоо бол тэр зүгээр л миний анхны хайрын дурдатгал гэж бодох болжээ.

Хичээлийн жилийн хоёрдугаар хагас эхэлсэн эхний өдөр. Надад нэг, том бор дугтуйтай захиа ирэв.

From:

Road Code Gallery

436 Road Code

London SW 10 JLO

To:

МУИС

1 курсын оюутан Долгионд

Mongolia

гэж хаягласан байлаа. Би ч тэрхэн үедээ ихэд гайхаж, Лондонгоос надад хэн захиа явуулдаг байна аа гэж бодож байсан боловч “Бүжин” гэх бодол зурсхийн орж ирэн, зүрх зогсчих шахав. Тэгээд дугтуйгаа онгойлголоо. Гэтэл баахан уран зургийн танилцуулга, фото, зураачийн нэрийн хуудас, бас үзэсгэлэнгийн нээлтийн урилга, үзэсгэлэнг зохион байгуулж байгаа галерейн танилцуулга гэх мэт зүйлс байв. “Ямар ч утгагүй юм” гэж бодсон боловч, би нэг зүйл хайгаад л дахин, дахин сайн үзлээ. Тиймээ! Үзсэн.

Ха-ха! Хариу нь олдлоо. Галерейн танилцуулгын холбоо барих хэсэг дээр:

Assistant: Вужин Т. гэжээ. Бүжин ...

Хариад шууд л Мөрөн рүү утасдаж, болсон бүх явдлыг ярилаа. Харин Мөрөн Бүжингийн тухай бүх зүйлийг ярьж, тэр ямар ч найз бандигүй, ах руугаа явсан юм. Ах нь Лондонд байдаг. Тэгээд Бүжин эдийн засгийн чиглэлээр сурч байгаа, энэ тэр гээд л... Би баярлав....

... Гэхдээ яагаад ?...

Мөрөн:

-Бүжин намайг чи Долгионыг ярьвал нэг юм зохиогоод хэлчихээрэй! гэж хэлсэн юм гэв. Инээдтэй. Тэгээд энэ ирсэн захианд Бүжингээс надад зориулж бичсэн ганц ч үг алга. Зүгээр л түүний хаяг...

...Би бодлоо...

...Новш гэж...

... Би түүнд захиа бичиж чадсангүй. Гэхдээ нэг сар гүрийсэн юм шүү...

Дурлаж бичсэн захидлын минь дугаар номер нь нэг гэж байгаад л захиагаа бичээд явуулчихлаа.

...Бороо шаагин орсон нэгэн өдөр. Бүжин хичээлээсээ тараад ажлынхаа газар ирэв. Ажил дээр нь нам гүм. Хэдэн зураг хананд өлгөх ёстой тул тэднийг яаравчлан өлгөж эхлэв. Өлгөсөн зургаа хэр тэгшхэн болж хэмээн харвал өөдөөс нь нэгэн эр зурган дээрээс ялдамхан инээмсэглэх ажээ. Нэг л таньдаг хүн шиг.

“Энэ чинь хэн билээ” гэж өөрөө өөртөө асуулт тавив. “Ямар сонин юм бэ? Ийм хачин байдалд орж үзээгүй юмсан” гэж гайхлаа. Зурган дээрх эр түүнийг цоо ширтэх аж. Бүр ихэд хайрласан, харамласан шинжтэй төрх. “Энэ чинь юу билээ” хэмээн дахин өөрөөсөө асууж, бас жаахан ичингүйрэв. Нэг л таньдаг мэдрэмж. Уг нь бол ийм мэдрэмж мэдэрч, ийм байдалд орохдоо тэрбээр тас ширвээд өнгөрдөг сөн. Гэтэл энэ удаа тэгсэнгүй. Нэг л хачин. Өнөөх залуу өөрийг нь хараад байгаад баярламаар, хөөрмөөр, магадгүй баясаад гүймээр ажгуу.

Хүн гэдэг өөрөө их сонин амьтан юм. Гэрээсээ хол байхаар л амьдралын мөн чанарыг ойлгож, гэр орныхоо халуун дулаан уур амьсгал, анд нөхдийн сэтгэлд дотно яриа, магадгүй хайргүй, дургүй ч гэсэн хойноос нь гүйдэг хархүүг үгүйдэг аж. Бүх л зүйл байсан байрандаа байгаад байх юм шиг өнгөрсөн амьдралаа төсөөлж, өөрийнхөө чин зорилгыг л гадаадад сурч, мэргэжил эзэмших хэмээн ойлгож байсан нь одоо тэс өөр ч юм шиг. Байсан зүйл байсан байрандаа үгүй, баахан хүсэл мөрөөдөлтэйгөө танилцахаар онцын хүсэх зүйлгүй, ганцаар гэртээ суун хичээл давтахад гунигтай, нэг тийм хэвийн амьдрал, уйтай, уйтгартай өдрүүд өнгөрч байх юм. Өмнө нь Бүжин гадаад оронд очиж их сургуульд сурмаар байна гэж ээж, аавыгаа хамаг байдгаараа шалан байж арай гэж зөвшөөрүүлэн Лондонд ирсэн билээ. Ах нь Бүжинг ирсний дараа Монгол буцах болж, хэсэг хугацаанд хамт байгаад явсан. Тэгээд л өнөөх

сайхнаар төсөөлсөн гадаад улсад ганцаараа амьдарсан хэдхэн сардаа эх нутгаа санагалзаж, энд ирсэндээ бага зэрэг харамссан хэрэг. Гэхдээ бага зэрэг шүү. Аав, ээжийнхээ мөнгө, төгрөгийг үрэн байж энд ирчээд хаяад буцвал эвгүй. Тэгээд ч бас өмнөө тавьсан зорилгоосоо гэрээ санасан, ганцаардсан нэрийдлээр ухрана гэж байх ёсгүй. Гагцхүү ганцаардана гэдэг л аймшиг. Ангийн нөхдүүд энэ тэрүүгээр явья, зугаалъя гэх боловч тэдэнтэй байх тийм сонин биш.

Мөн сурахын хажуугаар ажилд орсон тул бүр их завгүй. Завгүй хүн ганцаардах завгүй мэт боловч, сүүл сүүлдээ хэчнээн завгүй ч хүний сэтгэл гэдэг үгээр дүслэхийн аргагүй тогтворгүй, донсолгоотой ертөнц гэдгийг ойлгох болов. Нэг хэвийн амьдрал бүр ганцаардуулдаг ажээ.

Бүжин бусад зурагнуудыг хананд өлгөж, ойр зуурын цаас, бичиг баримтаа цэгцэлж суухад зурган дээрх өнөөх залуу түүнийг цоо ширтсээр байлаа. Хачин. Ичмээр. Ичмээр ч гэж ичив. Гэхдээ хэнээс зурагнаас уу? ...

Үгүй ээ, өөрөө өөрөөсөө. Мэдээж зурагнаас ичнэ гэж юу байх билээ. Нарийн сайн ажвал тэр зурган дээрх залуу нь Долгион байлаа.

Ялангуяа нүд нь. Бага байхад Долгион Бүжингээс илт эмээсэн хэрнээ бас цаанаа нэг хүндэлж, хайрласан харцаар ширтдэг байж билээ. Тухайн үедээ Бүжин хайр энэ тэрийн тухай ер боддоггүй. Тийм хайр сэтгэл гэдгийг зөвхөн томчууд л мэддэг байх гэсэн бодолтой явсан билээ. Тийн явсаар арваа төгссөн. Аравдугаар анги төгсдөг жилээс хуучин ангийнх нь Долгион байн, байн түүн рүү ярих болж, Долгионы ярьж байгаа зүйл ч хөгжилтэй санагдаж байсан тул тэр ярианаас татгалздаггүй байв. Гэхдээ тэр Долгионыг зүгээр л утасны найз гэж бодсоноос биш зүрх сэтгэлдээ ойртуулж байсангүй. Бага байхад тэр Долгионыг үзэн яддаг байсан санагдана. Юм л бол өөр рүү нь гөлийчөөд, эсвэл хэрүүл өдөөд яг маанаг, эсвэл галзуурсан хүн шиг байдаг байж билээ. Одоо бодохоос инээдтэй. Түүнд Бүжин дургүй байсан ч дараа нь утсаар ярихад өөрчлөгдсөн мэт санагдаж байсан. Хөгжилтэй, өөртөө итгэлтэй өөр хүн шиг болсон мэт санагдаж билээ.

Энэ зургийн нүд нь Долгионы нүд мөн. Тэр Долгионд хайргүй ч, ер нь урьд нь хайрын тухай яагаад ч юм бодож байгаагүй ч зурган дээрх нүд түүнд ихэд дотно санагдаж байлаа.

Хачин юм шүү. Дотно санагдана гэдэг. Өнөөх зураг Бүжинг ширтсээр. Бүжин ажлаа хийсээр.

Шинэ үзэсгэлэнгийн нээлт болох гэж байсан тул тэр хүмүүст урилга бичиж байлаа. Үзэсгэлэнгээ нээж буй зураачийн танилцуулга, зарим нэг зургийн хуулбар, ажлынхаа газрын танилцуулга зэргийг хийсэн дугтуйн дээрээ хэвлэмэл хуудсан дээр бичсэн хаяг наах зуураа ээж, аавдаа бас нэг дугтуй илгээхээр шийдэж, компьютер дээр хаягийг нь бичив. Охиноо ямар ажил хийж, ямар шинэ үзэсгэлэн гаргах ажилд оролцож байгааг эцэг, эх нь мэдэг гэсэн хэрэг. Гэтэл яагаад ч юм энэ үед өнөөх зурган дээрээс өөрийг нь ширтэж буй залуу хажуунаас халуун харцаараа төөнөөд болсонгүй. Яг л амьд юм шиг харагдах тэр залуугийн зураг, Бүжинд хань болж, “Хажууд чинь бас нэгэн анд чинь байна шүү дээ. Бүү ганцаард” гэх мэт сайхан байлаа. Бүжин тэр зургийг харж жаахан зогсов. Зургийн галерейд ажлаад хэдэн сар болж буй тэрбээр ажлаасаа ч шалтгаалдаг юмуу, ер нь уран зургийг зах зухаас нь үнэлж

сурч эхэлж байсан юм. “Үл таних залуугийн хөрөг” нэртэй энэ зураг үнэхээр сайн бүтээл болжээ.

“Хүн, түүний хөргийг инээж буй, уйлж буй олон янзаар зурж болох боловч хамгийн гол сэтгэлийн илрэл нь нүднээс л харагддаг. Цаашаа хараад явж байгаа хүний зураг байлаа ч тэр хүн нааш эргэж харахгүй юм байх даа, царайг нь, нүдийг нь харах юмсан гэсэн сэтгэгдэл төрүүлж чадаж байвал тэр зураг сайн болсны шинж” гэж галерейн эзэн нэг удаа Бүжинд хэлж билээ. Тэгэхээр хөрөг зургийн нүд хамгийн их сонирхол татсан хэсэг байж болох юм. Өөрийг нь бусдаас харамласан, хайрласан харцаар харах тэр залуугийн үс нь ширэлдсэн, нүүр нь бага зэрэг халтартсан байх ба баруун шанаан дээр нь сорви тогтсон байлаа. Хальт харвал ядарч дээ, хөөрхий гэж уулга алдмаар боловч түүний харцанд шингэсэн хүлээсэн, эргэлзсэн, тэгсэн хэрнээ бас битгий яваач гэж гуйж буй мэт аргадсан байдал өөрийн эрхгүй сонирхол татах ажээ. Хэрэв хамаагүй хөдөлвөл хэзээ л бол хэзээ гараас нь бариад авах мэт, тэгээд хаашаа ч битгий яваач хэмээн өмнө нь сөгдөн гуйж мэдэх тийм л залуугийн хөрөг.

Ийн байх зуур гаднаас эмэгтэй, эрэгтэй хоёр хүн орж ирлээ. Гадаа бороо шаагин орж байсан тул энэ өдөр үйлчлүүлэгч орж ирнэ чинээ санаагүй байсан Бүжин тэр хоёрыг гайхан харав. Эрэгтэй нь ихэд соёлтой эр бололтой бүсгүйгээ ерөөс норгоогүй байх агаад харин өөрөө борооны шүхрээ эвтэйхэн шиг хаалганы дэргэд дэлгээтэй чигт нь орхиод шалба норсоноо ч үл хайхран өөрөөс нь түрүүлээд Бүжин рүү алхсан бүсгүйнхээ хойноос яаравчлан гүйцэж ирэв. Үл таних бүсгүй Бүжин рүү дөхөн ирээд:

- Сайн уу, зураг үзэж болно биз хэмээн ёсорхуу маягаар асуулаа.

- Болно, бололгүй яахав хэмээн хариулах зуураа энэ чинь хэн билээ гэж бодтол Spice Girls-ийн Mel C урд нь зогсож байх нь тэр.

Од ... од өмнө нь зогсож байв. Учиргүй баярлаад тэврэн авч өөрийнх нь гарын үсгийг гуймаар санагдавч, бас тэгсэнгүй. Саяхан гуниглаад зогсож байсан Бүжин дүр төрхөө тэгж хурдан хувиргасангүй. Тэгье ч гэж бодсонгүй. Галерейдаа ганцаараа байсан тул зурагнуудаа танилцуулж, түүнийг дагуулан явах ажлаа хийлээ. Тэгэх зуураа мэдээж эмэгтэй хүний сониуч зангаар өмссөн, зүүсэн хувцас, байгаа төрхийг нь ажихаа мартсангүй. Хамт дагаж яваа залуу нь бодвол бие хамгаалагч бололтой. Дуучин бүсгүй зурагнуудыг сонирхон үзэж явсаар нэг зураг авахаар болсон нь өнөөх Бүжингийн анхаарлыг татаад байсан “Үл таних залуугийн хөрөг” байв. Өгөхгүй гэлтэй нь биш өгөхөд хайран ч өөрөө ямар арван таван мянган паунд төлөөд өөртөө үлдээж чадахгүйгээс хойш дуучин бүсгүйд зарж орхилоо.

- Тооцоогоо хийгээд. Танд баярлалаа. Дараа ирээрэй. Баяртай гэхээс өөр үг хэлсэнгүй. Залуу, бүсгүй хоёр ч зургаа аваад гарч одов. Олон ч юм ярьсангүй. Саяхан л ганцаардлыг нь хуваалцаж байсан хөрөг үгүй. Дахиад л ганцаардал. Дотор нь бачимдаад уйлмаар юм шиг. Шууд гарч гүйгээд онгоцны буудал орж, билет аваад харимаар ч юм шиг. Тайвшрахыг хичээв. Жаахан тайвширлаа. Лондонгийн гудамжинд бороо асгарсаар л...

Нэг бодлын тэнэг хэрэг, нөгөө бодлын ухаалаг алхмыг эс мэдэвч Долгионд бас нэг захиа илгээхээр шийдэв. Ямар ч байсан энэ үед Бүжин өдөр тутмын ажлаасаа жаахан сэтгэлээ хөндийрүүлж, өөрийг нь гэдэг байсан тэр хүнд хаана байгаагаа мэдэгдье гэсэн бодлоор нэг

танилцуулга явуулахаар зэхэв.

“Тодорхой хаягийг нь мэдэхгүй, гагцхүү МУИС-д орно гэж хавар ярьж байсан нь санаанд орж МУИС-ийн 1 дүгээр курсын оюутан Долгионд” гэж товч хаяглаад шууданд хийх захиан дотроо нийлүүлж орхилоо. Долгион МУИС-д яг орсон ч юмуу, үгүй ч юмуу бүү мэд. Мөн Их Сургуульд маш олон салбар сургууль байдаг. Тэгээд бас олон л Долгион байдаг байлгүй. Нөгөө талаас би овгийг нь мэдэхгүй учраас энэ захиа очооч уу, үгүй ч үү хэн мэдлээ. Зүгээр л явуулчихъя. Олж үзвэл тэр л биз. Бас энэ танилцуулгын доод талд жижгээр бичсэн миний нэрийг харах эсэх нь эргэлзээтэй” гэж бодсон ч тэр захиа эзнээ олон очихыг тэр мэдсэнгүй билээ.

Цонх онгорхой. Чийглэг агаар өрөөнд ноёлно. Өнөөх бороо үргэлжлэн орсоор. Ер хэзээ дуусах бороо вэ? гэдгийг тааж хэлшгүй. Энэ их ус хаанаасаа ч ингэж тэнгэр эцэгт олддог юм бүү мэд. Болдогсон бол Монголын говь нутгийн ангасан элсний ширхэг бүрийг хөгжөөн, татаршгүй энэ борооны үүлийг хөөн аваачихсан. Нартай өдөр ч агаар нь чийглэг байдаг Лондон хот усаар дутагдаагүй бүр илүүдээд байхад бороо орсоор л байх нь гачлантай.

Бүжингийн амьдрал нэг хэвийн үргэлжилсээр. Эгээ л зурагдсан пянз нэг дороо эргэлдэн, нэг л авиагаа давтан байх адил өглөө хичээлдээ явж үдээс хойш ажилдаа ирээд, орой нь гэрийн зүг харих тийм нэг жимээрээ л огт хазайлгүй өдөр бүр алхсаар. Ядаж замд нь өдөр тутмын энэ жихүүцлийг арилгачихмаар адал явдал үл таарна. Нөгөө талаас Бүжин өөрөө ганцаардлын ангал руу өөрийгөө улам түлхэх гэсэн мэт орой үдэш үдэшлэг, цэнгүүнд явъя гэсэн үе чацуутны саналд үргэлж татгалзсан хариу өгсөөр тэд ч Бүжинд дахиж санал тавихаа бүр больжээ. Гав ганцаараа эх нутгаасаа хол ийнхүү байх нь аймшигтай мэт боловч, орчинтойгоо танилцан, өдөр бүр алхдаг гудамж талбайгаас эхлээд танил зүйлс олон болж, анх ирснийгээ бодвол тэдгээр зүйлсийг өөриймсөг нүдээр харах болсон нь нэг талаас ололт байж болох. Гэхдээ л түүний сэтгэлд хоосон орон зай оршсоор байв. Магадгүй, тэр эмэгтэй хүний биеийн болоод сэтгэлийн мэдрэмжээ энэ газар ирээд л таньж мэдсэн байх. Урьд Монголд тэр бүр өөрийгөө эмэгтэй хүн хэмээн онцлон бодож эсрэг хүйстнээ тогтон харж, хайрын тухай ярих бусдын үгсийг чихний хажуугаар өнгөрүүлдэг байлаа.

Арван жилд ангийн охидууд хайрын тухай, хөвгүүдийн тухай ярих, зарим нь ичих. Харин Бүжин тэдний яриаг амтархан сонсдог ч гэлээ, үерхэж, дурлаж, үнсүүлж үзэхийг төдийлөн шамдан хүсч, яагаадыг бүү мэд өөртэй нь ер хэзээ нэг цагт тэр зүйл тохиолдоно гэж ч бодож явсангүй. Зүгээр л бусдын тоглосон жүжгийг хөндлөнгөөс үзэгч байж, хайрын тухай жүжигт өөрийгөө гол дүрээр төсөөлж байсангүй.

Тэр Долгионд хайргүй. Энэ бол мэдээж. Ганцхан Долгионыг ч онцлох зүйл ер байхгүй. Есдүгээр ангидаа өөр сургуульд шилжин орж, хоёр жил сурахад шинэ ангийнх нь нэг банди бас хойноос нь гүйсэн. Нэг удаа бүр гэрээс нь дуудан гаргаж ирээд “Хоёулаа үерхье” хэмээн хэлж, үнсэх гэж дайрч байсан удаатай. Юун үерхэх, үнсэх гээд “зайл” хэмээн тэр бандийг хөөж явуулж байсан нь тод санагдана. Тэр үед тийм л охин байж. Ямар ч эрэгтэй хүүхэд байсан бүгдийг нь үл тоодог байжээ.

Харин сүүлийн үед тэр ямар нэгэн далдын хүчинд автаж, хайрын тухай бодолд хааяахан дарагдана. Гудамжаар алхаж явахад хосоороо хөтлөлцөн алхах залуус, эрэгтэй нь бүсгүйгээ

энхрийлж, бүсгүй нь залуудаа эрхлэн буй дүр зургийг хараад нэг л гоё юм шиг, хамтдаа ингээд алхдаг хүнтэй ч болоосой хэмээн өөрийн эрхгүй бодох болжээ. Магадгүй энэ нь ганцаардлаас үүдсэн бодол ч байж болох. Эс бөгөөс эмэгтэй хүний шинж төрх насаа дагаад түүний амьдралд ирсэн байж болох юм. Ямар ч байсан тэр хайрыг хүсэх эерэг цэнэг зүрхэнд нь үүсч буйг мэдэрч байлаа.

Заримдаа сургуулийнх нь ганц нэг залуу түүнийг хоолонд, эсвэл кино үзэхийг урина. Харин Бүжин тэр бүгдэд татгалзана. Магадгүй, тэр тийм нүүрэмгий зангүй, тэгье орой уулзъя гээд хэлчих гэхээр нэг л эвгүй байдгаас тэдэнд татгалздаг байх. Гэхдээ хэрвээ үнэхээр тэр урьсан залуутайгаа хамт байхыг хүсвэл, ядаж дусал ч болов шалтгаан байвал тэр “тэгье” гээд хөнгөхөн хэлчихэж чадна гэдгээ сайн мэднэ. Тийм учраас өнөөх дурлалын эзэн ханхүү нь өдий болтол учраагүй л хэрэг.

Гадаа бороо орсоор л байлаа. Цонх онгорхой. Чийглэг агаар өрөөнд ноёлно. Шуудан зөөгч тэргээ түрсээр ирж байгаа харагдана. Хаалганы дэргэдэх шуудангийн хайрцаг руу хэдэн захиа хийгээд, Бүжин рүү инээмсэглэн толгой дохиод цаашаа явж одлоо. Өдөр болгон л энэ хэвшил давтагддаг тул Бүжин ер тоосонгүй. Галерейд өдөр бүр албан ажлын холбогдолтой захиа ирдэг. Тэгээд ч Бүжин хэн нэгнээс захиа хүлээсэн юм байхгүй. И-мэйл, интернет, утас байгаа болохоор гэр орон, найз нөхөдтэйгөө төвөггүй холбогдчихож болно. Шуудангийн ширээн дээр тавих нь түүний үүрэг учраас хайрцагнаас захиануудыг авахаар гарлаа. Хайрцганд арваад захиа хийжээ. Бас ганц нэг зар сурталчилгааны хуудас байх аж.

Зарын хуудаснуудыг тэр ялган хогийн сав руу хийгээд, даргын ширээн дээр ирсэн захиануудыг тавив. Тэр ширээн дээр тавихдаа мөн л төлбөр тооцоо, банкны бичиг, өөр бусад захиа гэх маягаар ангилж тавих ёстой. Энэ нь дарга өөрийн хүлээж байсан захиаг төвөггүй олж уншихад дөхөм болдог. Заримдаа дарга хүүхэн нь захиануудыг уншиж байхдаа харааж гарна. Ялангуяа мөнгөний нэхэмжлэхтэй захиаг задлахдаа тун дургүй.

Ирсэн захиаг ялгаж байх зуур түүний нүдэнд нэгэн захиа тусав. Захианы хаяг дээр T. Vujin гэжээ. Ахиулан харвал Долгионоос ирсэн захиа байлаа. Хэзээ ч билээ, саваагүй зан нь хөдлөн Долгионд үзэсгэлэнгийн урилга явуулснаа санах. Тэр явуулсан захиагаа эзэндээ очно гэдэгт үл итгэсэн билээ. Тэгээд ч тийм захиа явуулснаа бараг мартсан байв.

Шууд задлаад уншихмаар санагдавч, тэр тэгсэнгүй. Түүнд энэ мэдрэмж сайхан байлаа. Тэр захиандаа юу гэж бичсэн бол гэдэг нэн сонин. Тийм учраас л тэр сонин байх зүйлийг нандигнавал зүгээр. Тиймээс тэр одоо задлахаасаа татгалзлаа. Захиаг аваад цүнхэндээ хийчихэв.

Энэ үед Эмили гаднаас орж ирлээ.

Эмили бол Бүжинтэй хамт ажилладаг Ирланд бүсгүй. Сайхан сэтгэлтэй, их нийтгэгч, бас их царайлаг. Жаахан махлагдуу л гэж голохгүй бол тун дажгүй бүсгүй. Мэргэжил нь урлаг судлаач. Тиймээс тэр үзэсгэлэнд нэлээд чухал хүн. Ялангуяа уран зургийн талаар их мэдлэгтэй худалдан авагч нарт Эмили үйлчилнэ. Уран зургийн төрөл, өнгө, дүрсний ялгарал гээд Бүжингийн мэдэхгүй зүйлс их бий. Мэргэжлийн хүмүүс л ойлгохоор бас сонин үг хэллэг хэрэглэх тохиолдолд Эмилигүй бол ажил хийхэд хэцүү. Тиймээс Бүжин энэ бүсгүйг

хүндэлдэг байлаа.

Эмили Бүжинг хараад л шууд:

- Чи чинь ямар их баяр баясгалантай байх юм. Ойрд чамайг ингэж баярлаж байхыг хараагүй гэхэд захидал авснаасаа хойш өөрийгөө ихэд баяртай байгааг ч анзаараагүй байсан Бүжин “Нээрэн би чинь яагаад ийм их баяртай байдаг билээ” гэж бодон ичингүйрэв.

- Тийм үү, зүгээр л. Өнөөдөр их сайхан өдөр байна гэхэд Эмили:

- Зүгээр нэг баярлана гэж байдаггүй юм шүү дээ. Ямар сонин юм хэмээн эмэгтэй хүний сониуч зангаар Бүжингээс үг өдлөө. Бүжин дуугай л инээмсэглэв.

- Чи дурлачихаа юу? хэмээн Эмилиг асуухад Бүжин бүр гайхав. Эмили Бүжингээс хэд эгч гэсэндээ хааяа түүнд зөвлөгөө өгөх, сургаал айлдах дуртай. Гэхдээ урьд нь “Дурлачихаа юу” гэж ер асууж байсангүй.

- Хүн дурлачихаараа ингээд дуугүй инээмсэглээд байдаг юм даа, Бүжин минь гэж хэлээд Бүжин рүү харан инээмсэглэснээ нэг юм бодсон бололтой санаа алдав.

- Ай, нэг сайхан дурлах юмсан хэмээн үргэлжлүүлэн хэллээ. Тэр найз залуугаасаа салаад удаагүй байгааг Бүжин мэдэх тул гайхсангүй, дуугүй л өөрийнхөө урдах ажлыг хийж байлаа. Эмили өөрийнх нь яриаг Бүжин нэг их сонирхохгүй байна гэж бодсон уу:

- За, за. Ажлаа хий гээд үзэсгэлэнгийн танхимын мухарт байх өрөө рүүгээ алхлаа. Ажил тарав. Өнөөх захиан дээр юу гэж бичсэн бол гэдгийг мэдэх сонирхол ихэд төрнө.

Метроны буудал руу алхлаа. Цүнхнээсээ захиагаа гаргаж ирээд сайн харав. Бор өнгийн даруухан дугтуйнд хийж, Монгол эмэгтэйн зураг бүхий марк наажээ. Мөн Монгол шуудан гэсэн дугариг тамга үзэгдэх аж. Нөгөө буланд нь Английн шуудангийн дөрвөлжин тамгыг нэжгээдийг дарсан байв.

Хүнээс захиа авна гэдэг бас гоё шүү. Гараар бичсэн захидлыг үг бүрчлэн унших сайхан. Имэйлээр захиа бичих, уншихад тухайн хүний өөрийн гараар бичсэн бичлэг үгүй тул ямар нэгэн зүйл дугуу юм шиг сэтгэгдэл төрдөг бол харин захиа бол тийм биш.

Бичсэн үг болгоны утга сайхан, муухай, далий, мурий ч бичсэн байснаас үл хамааран илэрч, захиа бичсэн хүний уг байдал, сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлж чаддаг гэмээр. Угтаа кинотеатрт кино үзэх, зурагтаар кино үзэх хоёрын ялгаа их байдаг шиг л гараар бичсэн захиа амьд байдаг билээ.

Метроны буудал дээр ирэв. Захдуухан хэдэн сандал байх тул очиж суулаа. Ингээд захиаг задлан уншлаа. Дөрвөлжин шугамтай, тооны дэвтрийн заасан дээр ихэд нямбай бичсэн цэвэр бичигтний үгс зурайна. Бүжин чухамдаа энд ямархуу утга бүхий үгс байгааг мэдэж байгаа ч юм шиг, мэдэхгүй ч юм шиг байсан тул өөрийн бодсон мэдрэмжээ, угтаа бол хайрын үгс байгаа болов уу хэмээн гадарлан захиаг нээсэн билээ. Ингээд захиан дээр юу бичсэнийг

сийрүүлье.

“Сайн байна уу, Бүжээн

Дурлаж бичсэн захидлын минь дугаар номер нэг юм шүү гэж анхны захидлаа залуучууд бичдэг юм гэнэ лээ. Гэхдээ энд ингэж бичих сонин санагдчихлаа...

Чиний хичээл, сурлага сайн биз дээ. Амьдрал чинь өөдрөг, гялалзаж яваа гэдэгт би эргэлзэхгүй байна. Угаасаа л багын чи сурлага сайтай, тэргүүлэгчдийн нэг байсан санагдана.

Саяхан би нэг захиа авлаа. Чиний нэр бүхий үзэсгэлэнгийн зурагнуудын танилцуулга байсан. Үнэндээ тэндээс чиний нэрнээс бусдыг нь юу ч ойлгосонгүй. Ямар ч байсан чиний хаяг байх гэж бодоод энэ захиаг бичиж байгаа минь энэ.

Би энд хичээлдээ яваад л байж байна. Оюутан байх сурагч байхаас хэцүү л юм. Гэхдээ гадаадад Англи хэл дээр хичээл үзэж байгаа чамд Монголд оюутан байгаа би хичээлийн хэцүүг ярьвал инээдтэй сонсогдох байх.

За, тэгээд нэг тиймэрхүү л байна даа. Чамд амжилт хүсье. Захиа бичээрэй.

Хүндэтгэсэн

Долгион” гэжээ.

Бүжин жаахан гайхасхийв. Өнөөх өөрийг нь гуйж гувшаад байдаг Долгион мөн үү, энэ чинь. За байз, сүүлд утсаар ярьдаг байхад ихэд өөрчлөгдсөн юм шиг санагдаж байсан ч өөрийг нь гэх сэтгэлээ хааяа, хааяа цухуйлгаж байсан билээ. Харин захиан дээр Бүжингийн хүлээж байсан хайртай, дуртай гэх үгс байсангүй.

“Дурлаж бичсэн захидлын минь

Дугаар номер нэг юм шүү гэж анхны захидлаа залуучууд бичдэг юм гэнэ лээ. Гэхдээ энд ингэж бичих сонин санагдчихлаа, гэдэг чинь юу гэсэн үг вэ? За байз, би одоо тэгээд өөрийнхөө хаягийг явуулсан чинь... энэ одоо намайг өөрт нь сайн, гуйгаад байна гэж бодсон юм байх даа” гэж Бүжин бодлоо. Нээрээ л сайн хараад байсан чинь их хөндий бичжээ.

Энэ мэтчилэн гайхаж байх зуураа ер нь Долгион гэж хэн билээ гэдэг асуултыг өөртөө тавихад хүрэв. Санаанд сайн бууж өгсөнгүй. Арван жилийнх нь ангийн хүүхэд. Жаахан хэрүүлч, бас юм л бол Бүжинтэй өрсөлдөж байх дуртай, нэг бол яах гээд байгаа нь мэдэгдэхгүй Бүжингийн дэргэдүүр байнга сүүтэгнэж байдаг банди. Багадаа өөрийгөө их атамаан гэж бодоод тэнэг зан их гаргадаг байсан санагдана. Ангийнхаа банди нарыг зодож, айлгах дуртай муу сурдаг хүүхэд байснаа сүүлд дунд ангиас хичээлдээ гайгүй болж эхэлсэн. Найм төгсөх жил Бүжин өөрөө ч сонсоогүй ч ангийн хэдэн охины ярьснаар өөрт нь хайртай хэмээн замын нөгөө талаас орилж байсан гэх. Бүжин тиймэрхүү зүйл болно чинээ санаж байсангүй. Гэхдээ бас итгээгүй. Долгион тэр үед их сонин байсныг санаж байна. Нэг л хачин юм болох гээд байна гэж бодоод айгаад, бас Долгионтой хоёулхнаа зогсож байгаадаа ангийнхнаасаа ичээд

бушуухан л Долгионоос салахын түүс болон зам гаран гүйсэн сэн. Гэхдээ хайрын үг сонсоогүй ээ. Найзууд нь тоглож байна гэж бодоод Долгионыг өөрт нь хайртай гэж орилж, уйлж байсан тухай түүхэнд үнэмшээгүй билээ. Гэсэн хэдий ч Долгион өөрт нь сайн гэдгийг Бүжин мэднэ. Аан-гийн. Нэг захиа өгсөн. Хайр майр л гээд байсан. Тоогоогүй.

Үгийг нь өөрөөс нь сонсоогүй ч үйлдлээр нь мэднэ шүү дээ. Ангийн хүүхдүүд цасаар тоглох зэрэгт Долгион л Бүжинг цасаар угааж, Долгион л түүнийг элдэж хөөдөг байж билээ. Эхэндээ энэ Долгион яагаад өөрийг нь ингэж тойроод эргэлдээд байгааг гайхдаг байсан ч хэн нэгний анхаарлын төвд байх нь эмэгтэй хүнд таалагддаг ч юм уу, яваандаа өөрөө ч анзааралгүй тэр байдалд дассан билээ.

Хожим нь өнгөрсөн хавар Долгион түүн рүү ярих болсон. Өөрийгөө ихэд өөрчлөгдсөн гэж хэлж байсан. Бас Бүжин өөрийг нь харчихаад таньдаггүй өнгөрдөг гэсэн. Гэхдээ хуучны Долгион биш шал өөр Долгион болсон юм шиг санагдаж байсан билээ. Жаахан биеэ тоосон ч юм шиг.

Гэтэл энэ захиаг бас л Долгионы өөрчлөгдсөн гэдгийг батлах мэт хэнэггүй хэрнээ их ихэмсэг бичсэн байх юм. Нөгөө өөрийг нь тойрон эргүүтдэг байсан банди яавч биш.

Сүүлдээ бүр өөрийгөө ч ойлгохоо байлаа. Бүжин тэр бандийн тухай хэзээ ч нухацтай бодож байгаагүй ч өөртөө сайн гэдгийг нь мэддэг ч юм шиг, эсвэл үгүй ч юм шиг. Нэг бол Бүжин өөрөө түүнийг онцгойлон үзэж ханддаг байсан, эсвэл хандаад ч байгаа юм шиг. Үгүй бол Долгионоос хайрын үг хүсээд, эсвэл Долгион түүнээс хайр хүсээд ч байгаа юм шиг. Ер нь энэ Долгион гэж хэн юм бэ? Яагаад ийм чухал болчихов? Гэв гэнэт л гарч ирээд бөөн асуултын эзэн болчихож гэнэ гэх мэтээр олон асуултын дунд живж орхив.

Нэг бодлын энэ банди зүгээр ч захиа бичсэн юм шиг. Яахав дээ, ангийнхаа охины амар мэндийг л эрсэн байна. Гэхдээ бас “Дурлаж бичсэн захидлын минь дугаар номер нэг гэж бичих ч сонин л байна” гэж бичих энэ бид хоёрт ямар хэрэг байна аа? Энэ одоо өөрийгөө юу гэж бодоод байгаа юм бол? Ер нь би яагаад энэ захианаас болж цухалдаад байгаа юм, сонин юм?

Энэ мэтээр өөрийгөө ч ойлгохоо байлаа. Долгион гэдэг нэг нууцлагдмал хүн түүний ертөнцөд бий болж, түүний сонирхлыг татах эхлэл энэ байлаа. Ер нь яруу найрагч Ц.Хулангийн хэлснээр:

Олуулаа инээж авахуулсан гэрэл зурган дээр

Орь ганцаараа гунигтай мэт байдаг

Бүжгийн талбайд ховорхон үзэгдэж

Бүүдгэр үдэш, сумын тэнд дандаа л тааралддаг

Чамд би хайртай

Аль хэдийнээ дасал болсон

Цагаан өнгийн цамцан дээр

Адаглаад зангиа зүүдэггүйд чинь

Чамд би хайртай

Араас нэхэл дагал болдоггүйд чинь

Анхнаасаа ер нь намайг тоодоггүйд чинь

Бүүр их хайртай гэдэг шиг эмэгтэй хүний өмнө сөгдөх бүрийд эмэгтэй хүн эр хүнийг үл ойшоож, магадгүй бүр гутлын алчуур шиг өшиглөөд оддог байж болох юм. Харин эсрэгээр нь хааяа нэг үл тоомсорлосон мөртлөө өнөөх бүсгүйдээ ямар нэгэн байдлаар дотно ханддагаа илэрхийлж байвал бүсгүй хүн үл тайлагдах оньсогонд дуртай учир нэг л мэдэхэд тэр хүнд дурлачихна. Дурлахгүй юм аа гэхэд өөрийг нь үгүүлдэг, бусдыг хардгаас өөр харцаар хардаг болсон байж болох ажээ.

Энэ удаад Долгион яг тэгж бодоогүй ч гэлээ, ямар ч байсан онцгой ихээр “жижигрэхгүй” гэж шийдэн бичсэн захидал нь ийнхүү Бүжинг алмайруулж орхижээ.

8. Захидлын хариу

Захидал бичиж явуулснаас хойш даруй хоёр сар болжээ. Долгион өвөл танилцсан охиноосоо нэг л мэдэхэд больсон байлаа. 19 настай эр хүн гэдэг тайлж хэлэхийн аргагүй ертөнц ажээ. Хүүхэд насаа гэж, том хүн болсон гэж бодох боловч хааяа аливаад бас ахмад хүний дэргэд гэнэн, бас буурь сууриар тааруухан гэдгээ алхам тутамд мэдэрнэ. Нэг харахад бүдүүн дуу, сахал үс, хөл гар гээд бие эрхтний хувьд том эр болсон мэт боловч алхаа, гишгээ нь тогтворгүй, юм л бол үсэрч цовхорсон хөөцөлдөж гүйсэн, эс бөгөөс элдэв шалдав хэрэгт орооцолдчих гээд ер болохгүй.

Хааяа бас тамхи татаж, архи уунаа болоогүй. Тав дахь өдрийн орой бол бүр гарцаагүй. Тэгээд л нэг мэдэхэд “Чи, би”-дээ тулсан зодоон цохионы голд давхиж явах. Эсвэл архи ууж сураагүй байдаг юмуу, хэмжээгээ мэдэхгүй “тас” үсрээд, өглөө нь урьд шөнө юу болсноо арай гэж эвлүүлэн бодно. Тэгээд ичиж үхнэ. Бас найзуудтайгаа охидын тухай ярьж өгнө. Тэр охинтой тэгж танилцаад, тэр ингээд гэх мэтээр ярилцацгааж, татаж унтлаа инээнэ.

Арай насаар хэд ах залуусыг харахад тэд биднээс бас өөр шүү. Юм л бол зодоон энэ тэрд орооцолдоод, архи дарс хэтрүүлж уун онигоонд ороод байхгүй. Ер нь нэг тийм. Тиймэрхүү гэх үү дээ. Би ч бас өөрийгөө арай л балчир байна гэдгээ мэдрээд л байгаа юм.

Бүжинд жигтэйхэн хайртай хэрнээ, бас дажгүй гоё охин харахаараа мартчих гээд ч байх шиг. Ер бүү мэдээ.

Дахиад л нэг хавар болж байлаа. Надад захиа ирэв. Бүжингээс ирсэн байна хэмээн баярлаж, онгойлгоод хартал үнэхээр Бүжингээс иржээ. Нэг инээж байгаа алиалагчийн зурагтай ил захидал байх аж. Дотор нь “Инээдмийн баярын мэнд хүргэе. Бүжин” гэсэн таван үг л байв.

Жаахан гайхав. Захидлыг эргүүлж тойруулж хэсэг харав. Юу ч алга. Дөрвөн сарын нэгний мэнд хүргэж байгаа бололтой юм. Гайхмаар.

За, байз би эртээд чинь “Сайн уу, юу байна. Нам тайван. Чи нам тайван биз дээ” гэх маягийн захиа бичсэнээс өөр юм бичээгүй санагдана.

Гэхдээ би энэ өдөр маш баяртай байлаа. “Бүжингээс захиа авлаа шүү дээ. Дахиад захиа бичдэг хэрэг ээ” гэж бодов.

Хүний амьдрал гэдэг бас сонин шүү. Өсвөр насандаа яаж Бүжинд дурлаж, сэтгэл зүрхээ өгч байлаа. Тэгээд ямар их зовж, сэтгэлийн шаналан эдэлж байсан билээ. Өөрийг минь Бүжин л хайрлавал болох юм шигээр төсөөлж, ертөнцөд Бүжингээс өөр охин байхгүй гэж бодож өсчээ. Тэгээд сүүлдээ Бүжин бол миний хүршгүй оргил, давшгүй даваа л гэж боддог байж. Гэтэл сэтгэлийг минь суурин дээрээ ширвэж орхиод одсон тэр салхи миний зүг сэвшиж эхэлсний дараа нэг л сонирхол төрөхөө байчихав. Хайртай хүнээсээ захиа авлаа гэж баярлаж байвч, үнэндээ хайртай гэдэгтээ эргэлзэж байлаа. Бүжин намайг гуйлгах гэж эсвэл өөрөө ичсэндээ “Инээдмийн баярын мэнд хүргэе. Бүжин” гэсэн товчхон захиа бичжээ. Надад захиа бичихгүй байсан бол би бичихгүй байх байсан. Харин бичих байсан бол энгийн аятайхан

захиа бичиж бас болно. “Сайн байна уу. Ангийн хүүхдүүд сайн биз дээ” гэх мэтчилэнгээр амар мэнд асуугаад ангийн найзууд шиг энгийн аятайхан захиа бичиж болох. Гэтэл хүн шоолж байгаа мэт “Инээдмийн баярын мэнд хүргэе” гэж бичсэн нь нэн сонин.



Уг нь би ингэж бодъё гэж бодоогүй ч, юм үзээгүй гэнэн хонгор насны гайгаар биеэ тоох өвчинд нэрвэгдэж эхэлсэн минь тэр байлаа. Зугаа цэнгэлд дуртай болж, үеийн охид өөрт сайн байх тусам онгироо, эрдүү, занд идэгдэж эхэлсэн үе юм. Аав маань ажилдаа дэвшиж, албаны машин унадаг болсон нь ч энд нөлөөлсөн байх. Би гэдэг хүн аавын өвгөн бензний эзнээр тодорч, хичээлдээ машинаар явдаг лут эр. Бас өнөөх төмөр өргөдөг дасгалаа хийсээр байсан тул бие цэгц, бадриун тэрний хэрээр бас өөртөө улам л итгэлтэй болсон байлаа. Агуу их спорт гэдэг хүнийг биеийн хувьд цэгцлээд зогсохгүй, бас сэтгэлийн хувьд өөртөө итгэлтэй болгодог аж.

Охид өөрт минь сайн. Аа-яа-яа. Хорвоогийн жамаар эр өсч, эмэгтэй хүнийг гэнэн багын нүдээр харахаас арай өөрөөр хардаг болов. Охид, хүүхнүүд сайн байх тусам би эр хүн гэдэгтээ улам эрдэнэ. Сүүлдээ найрч болдоггүй охин гэж байдаггүй хэмээн үеийн нөхдөдөө онгирно. Иймэрхүү байдлаар амьдарч байсан үед захидал ирсэн болоод ч тэр үү, захиа бичихээр шийдсэн ч яагаад ч юм, завгүй байсан хэрэг үү, Бүжинд хоёр дахь захиагаа явуулсангүй ээ.

Бүжин өнөөх захианаас болоод хоёр, гурван өдөр өөртөө ихэд сэтгэл дундуур байлаа. Долгионоос их хайр хүлээж байсан гэж хэлэхгүй ч бас өөрийг нь гэсэн жаахан ч болов сэтгэл энэ захианаас үнэртэнэ гэж найдаж байсан билээ. Одоо тэр бүр ганцаардав. Эсвэл тэр захиа ирсэнд баярлах ёстой юм болов уу, бүү мэд. Далдыг үздэг шидтэй бол өөрийг нь хайж яваа тэр ханхүүг хаа явааг олж мэдэх- сэн.

Тэр ханхүү нь харин Долгион бол биш аж. Хүн захиа бичиж байхад хариуд нь захиа бичих хэрэгтэй нь ойлгомжтой тул захиа бичихээр суулаа. Хэдэн янзаар бичиж үзсэн боловч ер болсонгүй.

“Сайн уу? Долгионоо

Чи сайн биз дээ. Би сайн. Хичээл номоо давтаад, хичээлдээ яваад их завгүй байна...” хэмээн эхэлсэн захиагаа ураад хаячихлаа. Учир нь “Сайн уу? Долгионоо” гэхээр их нялуун юм шиг,

бүр “Сайн уу? Хайрт минь” гэж байгаа юм шиг санагдаад болсонгүй. Дараа нь “Сайн байна уу? Долгион. Би сайн. Чи сайн. Чи сайн биз дээ. Энд их бороотой хүйтэн байна. Наана чинь ямар байна вэ?” гэж бичээд дахиад урж орхив. “Юун бороо, цаг агаар вэ? Ямар цаг уурчид ярилцаж байгаа биш. Тэгээд ч Монголд эндэхээс илүү хүйтэн байгаа биз. Бас би сайн гэнэ ээ. Ер нь Долгион миний сайныг асуулуу, яалаа” гэж бодох зуураа өнөөх “Дурлаж бичсэн захидлын минь, Дугаар номер нэг юм шүү гэж анхны захидлаа залуучууд бичдэг юм гэнэ лээ. Гэхдээ энд ингэж бичих сонин санагдчихлаа...” гэсэн зэвүүн үг санаанд бугаад Долгионд ерөөсөө захиа бичихээ болихоор шийдэв.

“Угаасаа л анхнаасаа хэрэггүй тэр үзэсгэлэнгийн урилгыг явуулсан юм. Өөрийгөө ч доош хийгээд, хүнийг ч доош хийгээд. Долгион бодвол багын Долгион биш болсон биз дээ. Тэгэхэд би энд ийм хачин юм бичээд сууж байх” гэж хэмээн захиа бичих учраа олохгүй байсандаа бухимдан бодлоо.

Мөн л хэд хоногийн дараа галерейд шинэ үзэсгэлэнгийн нээлт болох гэж байсан тул тэр баахан урилга хийсэн хайрцаг барьсаар замын нөгөө талд орших шуудангийн салбар руу орлоо. Хайрцагтай зүйлээ хэдийнээ танил болсон шуудан ч залууд өгөөд гарахдаа хэдэн ил захиа үзэж сонирхов. Хөгжүүн нь аргагүй инээсэн, бүр сайн харвал хүний янз үзсэн юм шиг, шоолж байгаа мэтээр төсөөлөгдөхөөр алиалагчийн зурагтай ил захидал нүдэнд нь туслаа. Нөгөө л нэг сахилгагүй зан нь хөдөлж, Долгионд тэр ил захидлыг явуулъя гэж бодов. Хаягийг нь мэдэх тул “МУИС, ХЗС-ийн 1 дүгээр курсыг оюутан Долгионд, Mongolia” хэмээн дугтуйн дээр бичээд, ил захидал дээрээ “Инээдмийн баярын мэнд хүргэе. Бүжин” гэж бичээд дугтуйлж хайрцганд хийлээ.

Гараад зам гарч явахдаа “Дэмий ч зүйл хийчихэв үү. Буцаж ороод авдгиймуу. Нэгэнт хайрцганд хийчихсэн юм чинь дэмий юм уу. Шууданч залууг гуйвал аваад өгөх л байх даа. Яах вэ?” гэж эргэж, буцан бодож яваад золтой л замын голд машинд дайруулчихсангүй. Нэг ууртай Англи залуу ганган тэрэгнийхээ цонхоор Америк маягаар харааж байгаа сонстов. Тэгсэн хэрнээ бас Англи акценттай шүү. За, тэрч яахав. Ингээд тэр захиаг буцааж авсангүй.

Бие биенээсээ ихэд хөндий хэрнээ, бас их ойр юм шиг сэтгэгдэл төрмөөр бүсгүй, залуу хоёрын сэтгэл, учир нь олдохгүй ийнхүү ээдэрч байлаа.

Ертөнцөд дурлал хэмээх зүйл ерөөс дурласан уу, дурласан, үнсэлцэх үү, үнсэлцэе хэмээн харилцан ярилцах мэт шууд ирдэггүй бололтой. Хүн бүрийн хайрын түүх өнгөц харахад ижил боловч, нарийн ажвал өөр өөрийн өнгө төрхийг илтгэмүй. Олон жил бие биенээ тэжээн алсыг зорих итгэл дүүрэн эхлээд, мөхөж болохын адил хормын төдийд дурлаад, хайрлаад үхэн үхтлээ үнэнч хагацашгүй замаар сэтгэлээ хөрвүүлж ч бас болох. Эс бөгөөс хормын төдийд дурлаад хормын төдийд төгссөн хайрын түүх, харцны учрал хүнд агуу ихийг мэдрүүлж, хожмын өдрийг нь гэрэлтүүлэх наран мэт утга төгөлдөр байж мэдэх юм. Ер хорвоо гэдэг баян, ертөнц гэдэг уужим учраас л амьдралд бид хайртай байдаг билээ.

9. Гэртээ ирлээ

Онгоц газардлаа. Нутгийн минь уул, толгод үзэгдэнэ. Бас онгоцны буудал. Буянт–Ухааг бусад хөгжингүй орнуудын онгоцны буудалтай харьцуулахад хариугүй жижигхэн ч гэлээ, хэрдээ цэвэрхэн, тохилог сайхан буудал билээ. Нэр нь зохисон, оносон гэж жигтэйхэн. Буянт Ухаа шүү дээ. Сайхан бэлгэдлийн ерөөлтэй нэрийг хэн гэдэг хүн энэ буудалд оноож өгсөн юм бол гэж сонирхмоор.

Вашингтоны Рийган онгоцны буудлаас онгоцонд суухаасаа эхлээд Буянт Ухаад буутал эх орноо санасан сэтгэл нь хүчтэй догдолж явсан билээ. Замд онгоцоо Сөүлийн Инчеоны буудал дээр солих хоёр цагийн хооронд бушуухан онгоцондоо сууж хурдан харих юмсан гэж жаахан хүүхэд шиг тэсгэл алдаж байв. Тэр хичээл номондоо сайн байсны буянаар дөрвөн жил Америк оронд эрдэм боловсрол эзэмших тэтгэлэг авч, Олон Улсын эрх зүйч болоод ирж байгаа нь энэ.

Бараг тасралтгүй хорин дөрвөн цаг онгоцоор ниссэн тул жаахан ядарч байлаа. Зорчигчид буулаа. Сэтгэл хоргодсон нутгийн минь эрмэг салхи хүүгээ ирлээ гэсэн шиг хацар нүүрийг минь илбэв. Яг л дуунд гардаг шиг эх орон гэдэг үнэхээр үнэтэй газар шороо ажээ. Ялангуяа сүүлийн гурван жилд гэртээ ирээгүй түүний хувьд нэн сайхан байлаа.

Хүмүүсээ би гэртээ ирлээ гээд дуулмаар юм шиг. Дуучин Эрдэнэбат ахын “Гэртээ ирлээ”- г хүн амьтнаас ч ичихгүй одоо л яг дуулвал гоё санагдана. Гэхдээ тэр тэгсэнгүй. Биеэ барив.

Гаалийн нэвтрэн өнгөрүүлэх бүс өнгөрөөд ээж, аавтайгаа тосон золголоо. Эгч минь бас хүүхэдтэйгээ иржээ. Хэдий ээж аавтайгаа уулзаад баясал төрж байсан ч гурван жил уулзаагүй тэд ямар их өөрчлөгдсөнийг хараад сэтгэлд бяцхан гуниг төрөв. Эгч мэдээж хэвээрээ, хүү нь харин их том болжээ. Танихын ч аргагүй том хүүхэд. Гурван жилийн өмнө ээжийнхээ өврөөс чаргууцалдан уйлж дуулсан хүүхэд одоо ахыгаа гайхан харж, таньдаг билүү, үгүй билүү гэсэн шиг сонирхон харан зогсох нэгдүгээр ангийн жаал болж. Түүнийг хараад мэдээж ах хүний хувьд өхөөрдөх, хайрлах сэтгэл төрсөн бол харин аав, ээж хоёроо хараад жаахан гайхав. Хүн гэдэг гурван жилийн дотор ямар их өөрчлөгддөгийг тэгэхэд мэдэрлээ. Аавынх нь үс бууралтаж, бүр нэг ч хар үс үлдсэнгүй. Өнөөх ханагар сайхан цээж, мөр нь багасч, жаахан туржээ. Өвгөрч байгаа нь энэ бололтой. Ээж нь толигор сайхан арьстай, тэгш гуалиг биетэй эмэгтэй байсан бол нүүрэнд нь үрчлээ сууж, бас жаахан таргалсан байх аж. Тэр хоёр минь бидний төлөө гэж явсаар хамаг сайн сайхнаа бидэнд өгчихсөн юм шиг нэн сонин. Гэхдээ энэ бодол удаан үргэлжилсэнгүй. Аавынх нь хөгжилтэй яриа, ээжийнх үргэлжийн залуу инээмсэглэл, дүүгийнх нь олон юм шалгаах сонирхол энэ бүхэн удалгүй түүнийг гэртээ ирснийг мэдрүүлж, эх сайхан нутагтаа цэнгэлийн манлайд хөтлөгдсөн билээ.

Ирснээс хойш гэрээсээ гаралгүй хоёр хонолоо. Ингээд өнөөдөр гарахаар шийдэв. Найзууд руугаа ирснээ хэлэн утасдтал “Ирчихээд, хоёр хоночихоод утасдахгүй муухай байна даа” гэлцэн дуу шуу болцгоолоо. Тэгээд орой уулзахаар тохирцгоов.

Гэхдээ тэрнээс өмнө хийх нэг ажил байлаа. Ажил ч гэж дээ, нэг хүнтэй уулзах. Долгион шүлэг бичих дуртай нэгэн. Анх Бүжинд дурласнаас хойш сэтгэл нь хөглөгдөж, удалгүй шүлэг

бичиж эхэлсэн билээ.

Долгион анх Бүжинд дурласан түүхээ бичиж тэмдэглэдэг байснаа сүүлдээ, шүлэг бичих болсон юм. Ялангуяа МУИС-ийн хуулийн сургуулийн нэгдүгээр курс төгсөөд, Америкт очсоноос хойш www.asuult.net –ийн уран зохиолын форумд байнга ордог болсон ба тэгэхдээ тэр олон янзын шүлэг, зохиолыг амтархан уншиж, бас хааяа өөрийн бичсэн ганц нэг шүлгээ тавьдаг байлаа. Өөрийнхөө нэрийг БОДОН гэж тавин нэтэд холбогдоно. Энэ дашрамд хэлэхэд өнөөх төмөр өргөдгөө бас л хаяагүй хичээллэсээр одоо бүр 150кг-аар цээжний шахалт хийж, 200кг-аар хөлд суудаг болсон билээ. Учирлаваас анх 30 кг-ыг чүү-ай даадаг байсан хүн зургаан жилийн дотор 150 кг-ыг өргөдөг болсон гэсэн үг. Бага байсныгаа бодвол жин нэмж, бас өндөр болжээ. Тэгээд Америкт нийлдэг байсан найз нар маань Бодон гэж шоолдог байснаас өөрийнхөө нэрийг нэтэд Бодон хэмээн өгсөн хэрэг.

Lion King гэдэг хүүхэлдэйн киног та санаж байгаа байх. Тимон хэмээх хөгжилтэй зурам шиг амьтан, бас нэг зэрлэг гахай гардаг даа. Гахайных нь нэрийг мартчихаж. Тэр хоёр өт, шавьжаар хооллодог. Тэгээд зөндөө их өт идчихээд гахай нь:

- Яая, гахай шиг их идчихлээ гэсэн чинь Тимон нь:

-Үгүй ээ, чи чинь угаасаа гахай шүү дээ гэхэд өнөөх нь:

- Юу гэнэ ээ, би гахай биш БОДОН мэдэв үү? хэмээн уурладаг билээ.Тэгэхээр Бодон гэдэг ч бас нэг их муугүй нэр шүү. За, энэ яахав.

Ингээд нэтэд ордог байхдаа нэгэн ухаалаг шүлэгч бүсгүйн үнэн үгсийг уншдаг байлаа. ID буюу нэр нь URIN. Урин хэмээх тэр гоё нэртэй бүсгүйтэй анхандаа бичсэн шүлгийг нь уншин танилцав. Танилцсан ч гэж дээ, яг жинхэнэ нэр усыг нь мэдэхгүй ч гэсэн түүний уран үгстэй танилцсан билээ.

Америкт анх очоод би Вашингтонд нэг охинтой үерхсэн юм. Бараг хамт амьдарна. Тэднийх Арлингтоны Mongol town гэж нэрлэгдсэн гурван байшингийн нэгэнд, харин манайх DC-д байдаг байв. Сүүлдээ тэр ихэнхдээ манайд амьдардаг боллоо. Би тэр охиндоо өөрийгөө хайртай л гэж боддог байлаа. Гэхдээ л дандаа хамт байхаар хэцүү. Ялангуяа их хэрүүл хийнэ. Тэгсэн хэрнээ бүр явуулчихаж бас чадахгүй. Орой хичээл тараад ирэхэд хоол хийгээд тавьчихсан, гэр орон цэвэрхэн байхад үнэхээр сайхан.

Хувцас хунарыг үнэн сэтгэлээсээ угааж, надад халамж тавина. Эх нутгаасаа, гэрээсээ хол байхаар өөрийн эрхгүй эмэгтэй хүний халамж үгүйддэг юм уу, түүнээс холдох хөндийрөх гэхээр хэцүү санагдана.

Гэвч бид хоёр сайны хажуугаар саар гэгчээр хэрүүл тасраагүй жижигхэн зүйлээс л хэрүүл үүсчихнэ. Тав дахь, хагас сайнд манай хүн баардаж, бүжиглэхийн нэл өвчин. Бас архи пивийг нэлээд ууна. Бас тамхи татна. Ер нь жаахан шоучин гар гэх үү дээ. Харин би найз охиноо тиймэрхүү байдалтай байхад ясны дургүй. Ер нь би тамхи татдаг эмэгтэй хүнд ясны дургүй. Тэр мэтчилэнгийн зүйлээс болж, хэрүүл их хийдэг байлаа. Байгалиасаа таарахгүй хүмүүс гэж байдаг бололтой юм. Би угаасаа өөрийнхөө эхнэр болох хүнийг тийм хүнээр хэзээ ч

төсөөлж байгаагүй.

Ингээд бид хоёр бараг таван сар амьдарсны эцэст салахаар шийдэж, би түүнийг явуулсан билээ. Гэхдээ түүнээс салсны дараа буцаад очиж гуймаар санагдах мөч олон байв. Тэгж байх үедээ би нэг шүлэг бичиж asuult.net –ийн уран зохиолын форумд өөрийнхөө нэртэй самбарт тавьсан санагдана.

“Чадал мэдэн зугтъя гэж бодоод

Чадал мэдэн зугтахаар бэлдтэл

Чамайг хараад хөшиж орхилоо

Чадал мэдэн буцаад гүйлээ” хэмээн найз охиноосоо сэтгэлээ бүрэн татаж авч чадахгүй байгаагаа бичсэн билээ. Үнэндээ түүнийг ороод ирвэл тэврээд л хэдэн цаг ч хамаагүй зогчихмоор санагдана. Гэхдээ өнөөх шоучин, бусад залуустай эрээ, цээргүй маяглах, бас тамхичин төрх нь бодогдоод өөрийгөө барьж байлаа. Гэтэл миний бичсэн шүлгийн дор Урин хэмээх өнөөх гоё шүлэг бичдэг хүн шүлэг бичиж орхижээ.

Chadal meden chamaig yavah gevel

Changaaj bi setgeleeree horih bolno

Chadal meddeg er zorigiig chin

Tsag hugatsaagaar nomhotgoh bolno

Sar jiluudiin aysiig

Saatan hoyulaa tuulsan bolohoor

Salj nadaas zugtana gevel

Sanaani garz biz dee hongor min

Hehehehe tiim ch amarhan yavuulahgui baihaa ~~~гэж бичсэн байлаа. Яг л найз охин минь ирээд, халуун дулаан үг хэлж байгаа юм шиг. Найз охиноо хөөгөөд явуулчихсан би тэр үгсийг сонсоод сэтгэл тайвшрав. Ингээд хариуд нь:

Chi namaig ginjilsen chinee sanaa yu

Chinii dergedees haa holdohiin gej hairaar namaig utna uu,

Negen gazraa togtdoggui salhunii huu, bi er hun

Torolh huvi zayagaa dagaad toorood ch bolov alga boloyo.

Chamaas l holdoj baival jargal gedeg ni teree

Chadal hureh bailgui. Goridoj bгаа ni ene

Jaahan hamt baihaar zalhaad baigaa ni teree

Jargal haigaad zugtval sanaad baih bolov уу.

гэж бичлээ. Удалгүй хариуд нь:

Erh hongor salhi chi

Ermeg hundiid esgerch dur zorgoor nis dee

Er hunii zorilgo uul us shigee uudam bolohoor

Erhlen horij bi zurhleghi

Holdon odoj bui setgel tani

Horogdoj naddaa irehgui bol

Hongorhon setgeliin ariun hair ni

Hudal huurmag gedegt bi itgene гэж Урин бичсэн байв. Тэгэхээр нь:

Uujim ene setgel chini l

Urhidaad bgaam namaig

Holdon odoh geheer horgodood bgaam chamd

Erhlen zorij zurhleghuid chini bi

Tunirhaad bгаа ni ene

Egel ene setgeld chini ginjlegdchiheed

Erchit shuurga gedgee martchihaad baih yum, halag

Uul baisan bol boroo bolood orohson

Dol baisan bol durelzeed shataj duusahsan

Nar baisan bol jargaad sariig urihsan

Salhi bolohoor l setgel mini sevsheed togtohgui ni Urihan minee гэж бичиж орхилоо.

Нэг л өөриймсөг сэтгэлд шингэсэн уран үгийг Урин бичдэг байлаа. Яваандаа түүний шүлгэнд татагдаж, түүнтэй танилцахыг хүсэв. Би Америкт, тэр хаана байдгийг би үл мэднэ. Нэрийг нь хэн гэдэг, хэдэн настайг нь бас мэдэхгүй. Ямар ч байсан үгэнд нь үнэхээр дурласнаа мэдэж байлаа. Ийнхүү нэтэд бие биенийхээ бичсэн шүлгэнд хариу болгон бичсээр гурван жилийг ардаа орхисон юм. Нааш гарахаасаа өмнө түүний asuult.net –ийн хаяг руу захиа бичсэн билээ.

“Сайн байна уу? Урьхан минь,

Би Монгол буцах гэж байна. Чи хаана байдаг, хэн гэдэг хүн бэ? Би чамтай танилцмаар байна” гээд өөрийнхөө нэр, усыг ч тавилгүй мартаад явуулчихав. Хариуд нь: “Нэр усыг уулзаж байгаад хэлье. Би ч бас удахгүй Монгол буцна. Уулзмаар байгаа бол зургаан сарын хоёронд Сүхбаатар ахын дор дөрвөн цагаас уулзъя. Бодон гуай” гэжээ. Хөгжилтэй бас их хөөрхөн.

10. Болзоо

Урины бичсэн шүлгэнд нь би үнэхээр дурласан гэх үү дээ. Түүний бичсэн шүлэг бүрийг амтархан уншдаг байлаа. Найрагч бүсгүйн шүлгэнд татагдсандаа ч тэр үү тайвширсан. Хуучин найз охиноосоо би тэгээд л салсан. Тун удалгүй өнөөх маань өөр залуутай хүзүү сээрээрээ холбогдоод л гүйж харагдсан. Ухаан богино бүсгүй хүний занг яалтай билээ. Надаас өмнө хэдэн ч залуутай байсан юм, хэн мэдлээ.

Бичсэн шүлгийг нь уншаад, бас хааяа нэг бусдын бичсэн шүлгэнд хариу бичсэнийг уншаад би түүнийг ямар ч байсан ганц бие гэдгийг ойлгов. Учир нь нэг удаа ORNY гэдэг нэрээр ордог нэг бүсгүйн нөхөртөө зориулж бичсэн шүлэг байлаа. Тэр нь их гоё:

Хайрт Очкоодоо

Хүйтэн өвлийн жихүүн салхи цонхон цаана исгэрч Хөнжилдөө хурган хурган бээрэн хэвгэхэд

Алс холын өвгөн бодол үзүүр тэмтчин ирж

Авааль нөхөр чамайгаа би сэтгэлдээ үгүйлнэ.

Хөөр хөгжөөнтэй оюутан цагтаа сургуулийн хонгилоор чамтайгаа зөрөөгүй бол

Хөл тушигдан зэрэгцэн зогсож сониучирхсан харц хоорондоо мөргөлдөөгүй бол

Хайрын оч тэрхүү харцнаас үсэрч ханьсахын галын тулгыг тулахгүй

Хангай шиг түшигтэй чинийхээ нөмөрт ангаахай шиг би чинь орохгүй л байсан

Гадаа шуурах шуурга ч намдах шиг

Хөнжил дулаацан хацар улайсан нь

Хонгор чи минь ирснийх байжээ.

2005.12.08 /гэртээ хурдан ирж байгаарай/ гэжээ.

Ногоон цас нойтон дурлал



Харин энэ шүлгийн дор URIN сэтгэгдлээ бичсэн байв. Wow orny chamd byatshan ataarhah setgel turj bna shuu hanitai baih saihan yumaa. Chamd болон ger buliinhend chini az jargal husiye гэжээ. Ингэхээр тэр ямар ч байсан нөхөргүй юм байна гэж бодов. Тэгээд түүний бичсэн шүлгийг олон сар уншсан даа. Ингээд яагаад ч юм түүнд дурлаж эхэллээ. Би ч бас шүлэг бичсээр, тэр уншсаар, тэр бичсээр би уншсаар эчнээ танилууд болцгоов. Харин би түүнд нэг ч захиа бичсэнгүй зүгээр л дотроо түүний гоё үгсэд сэтгэл цаддаг байлаа. Харин Монгол буцахын өмнө түүнтэй танилцмаар санагдаж захидал бичсэн минь тэр. Шүлэгч бүсгүй ч надтай болзсон нь тэр байлаа. Бодон, Урин хоёр уулзахаар болсон нь тэр.

Гадаа гарлаа. Зуны эхэн сарын тогтуухан сайхан өдөр. Өчигдөр хүүхдийн баяр байсан. Ээж, аав хоёр надад бялуу авч өгсөн. Хэдий би 23-тай эр хүн ч гэлээ, айлын эрх хүүхэд. Хоёр хүүхэдтэй айлын отгон нь, одоо болтол энэ зангаа тавихгүй эрхэлсээр л байгаа. За, энэ ч яахав.

Дурлал гэдэг үнэхээр өндөрт нисээд, газарт буухаа мэдэхгүй шувуухай шүү. Бүжинд дунд ангидаа дурлаж үхэнгээ алдаж байж билээ. Дараа нь бас л хэд хэдэн охинд дурласан. Дурлал гэдгийг үүрдийнх юм даа гэхээр л зуурдынх болчихоод байдаг тогтворгүй сонин эд шүү. Одоо бас нэг шүлэгч бүсгүйд дурлачихсан байдаг. Гэхдээ хэн гэдгийг нь мэдэхгүй учир бусад дурлалаас минь жаахан өөр. Сонин, тийм хачин дурлал.

Гэлээ гээд яахав, дурлачихсан л юм чинь. Цэцгийн дэлгүүр орж баглаа сарнай авлаа.

Урингийн хэлснээр “Сүхбаатар ахын дор дөрвөн цагаас” гэсэн тодотголтой болзоондоо цэцгээ барьсаар очлоо. Цаг гурван цаг тавин таван минут.

Байн байн цагаа харсаар зогсов. Ямархуу хүн ирэх бол гэж түгшиж байсан нь мэдээж. Гоё залуухан охин ирэх болов уу, эсвэл аймар хөгшин авгай хүрээд ирэхвий дээ гэж айна. Ер нь тийм болзоо эвгүй шүү дээ. Бие биенээ мэдэхгүй хоёр захиа бичилцээд уулзахад сонин л байж таараа.

Дээхэн манай нэг найз мессежээр нэг охинтой танилцаад болзсон чинь тэр нь аймар матар байхаар нь зугтаачихсан гэж ярьсныг санахаар нээрэн матар байвал яана аа гэж айв. За, гэхдээ дүүрч гурван жил шүлгийг нь уншчихаад юун сүртэй юм бэ, ямар хайртай дуртай гээд хэлчихсэн биш. Муухай, эсвэл хөгшин хүүхэн байвал таны шүлгийг гурван жил уншлаа. Та их сайхан шүлэг бичдэг шүү” гээд л ганц нэг үг хэлж яриад хоолонд орно биз. Тэгээд л болоо шүү дээ.

Ийн бодон зогстол насаар миний үеийн болов уу гэмээр цэвэрхэн хувцасласан, дунд зэргийн нуруутай бүсгүй миний зогсож байсан Сүхээ ахын хөшөөний яг дор ирээд зогсчихлоо. Нүүрийг нь сайн харвал нэг л биш ээ. Таньдаг хүн шиг. Намайг танихгүй байгаа бололтой. Урин лав биш болох нь тодорхой боллоо. Арай нөгөө Урин маань биш байгаа гэж бас бодно. Учир нь хажууд минь ирэн зогссон бүсгүй бол миний анхны хайрын эзэн Бүжин байлаа. Амьдралаа гэж, хатуу самар даа. Арвин баян амьдралд юу эсийг үзэх билээ дээ.

Өнөөх гайт Бүжин. Харахаар салахын аргагүй миний үзэсгэлэн. Анхны хайрын минь эзэн. Хиртэй гараар хүрэмгүй булбарайхан, ариухан хайрын минь дурдатгалын хатан хаан. Хэгжүүн бөгөөд намайг үл тоох өнөөх Бүжин. Хожим би түүнээс захиа аваад хариу бичээгүйгээ саналаа. Өөртөө эрдэж галзуурч явсан гэнэн нас байж дээ. Одоогоос дөрвөн жилийн өмнө санагдана. Өөр охидын дунд толгой эргэн хөлчүүрч явсан үе. Тэгээд ч бас Бүжин үнэндээ надаар тоглож, зугаагаа гаргаж байсан уу, эсвэл надаас бас хайр хүсч байсан уу, би тэгэхэд сайн ойлгоогүй шүү дээ. Ингэж бодохоор сэтгэл хямрах ч шиг хачин болчихов.

Нарны шилээ аваад би түүнийг дахин сайн харлаа. Хээнцэр дэгжин, цоглог хүүхэн болжээ. Анхны хайр минь угаасаа л тийм байсан шүү дээ. Өөртөө итгэлтэй цоглог охин байсан. Харин одоо өөрчлөгдсөн зүйл гэвэл эмэгтэй хүний шинж төрхийг илтгэсэн бие галбир байлаа. Бас зан нь хэрхэн өөрчлөгдсөнийг хэн мэдлээ. Би түүн рүү инээгээд л хараад байв.

Намайг өөрийг нь инээмсэглэн харан зогсохыг харсан Бүжин намайг бас сонирхон харлаа. Гайхаж байгаа байх. Нөгөө газрын гай, хэрүүлч Долгион л мөн үү гэж харж байгаа байх даа гэж бодон байтал намайг таньсан бололтой инээмсэглэн над руу ойртон ирлээ. За, ингээд өнөөдөр чинь анхны хайртайгаа учирдаг байжээ.

Би:

- Сайн уу? гэлээ.

- Сайн, сайн байна уу гээд нүдээрээ инээмсэглэн надаас үг хүлээв. Эргэлзээд байна хөөрхий. Намайг таньж байна гэж бодсон чинь танихгүй байгаа нь илт.

- Чи хүнтэй энд болзоо юу? хэмээн асуувал:

- Тийм, та Бодон уу? гэж наадаг байна ш дээ, харин. Дотроо “АА-ЙЙ-НН” хэмээн дуу алдсан ч, анхны хайрынхаа өхөөрдөм инээмсэглэхийг хараад дуугүй л инээлээ.

- Тиймээ Бодон гэсэн чинь:

- Би Урин байна аа гэж байна. Одоо яая гэхэв дээ. Намайг танихгүй байгаа хүнийг чинь. Бүжин намайг харалгүй, за байз, долоон жил болжээ. Харин би түүнийг таван жил хараагүй юм байна. Би чинь наймдугаар ангидаа 64 кг байсан байх. Харин одоо 105 болчихсон байдаг. Бас өндөр маань 175 ч бил үү, байсан байх. Харин 187 болсон. Нэг их том нүдний шил зүүдэг байсан бол одоо бараг линз зүүгээд нүдний шилээ бага зүүж байгаа. Өнөөдөр нарны шил зүүж гарсан тул линз зүүсэн юм.

За, нэг иймэрхүү хөгжилтэй юм болж байлаа. Анхны хайртаа харах тусам өхөөрдөөд байлаа. Бас болоогүй их гоё шүлэг бичдэг, шүлэгч бүсгүй болсон байх нь, миний дурласан шүлэгч маань Бүжин байж таарах нь.

- Сайн байна уу? Ингэж нэг уулздаг юм байж хэмээн гар бариад цэцгээ өглөө. Тэр цэцгийг аваад ихэд баярлаж, өөрийгөө танилцууллаа.

- Намайг Бүжин гэдэг. Англид эдийн засгийн сургууль төгсөөд саяхан ирсэн гэж байна. Нэг жаахан өөрчлөгдсөн зүйл нь жаахан яриа болсон юм шиг санагдав. Би дуугүй л инээгээд зогсоод байлаа.

- Таны нэр тэгээд хэн бэ? гэж байна. Намайг танихгүй байгаан дээр намайг өөрөөс нь ах гэж бодож байгаа бололтой. Би нэрээ:

- Дол.... –гээд яг хэлэх гэснээ нэгт, Бүжинг эвгүй байдалд оруулчих байх, хоёрт бас Бүжингээр жаахан тоглоё гэж санаад -...лиг... гэж хэлж орхив. Бүжин намайг гайхаж байгаа бололтой нэг харснаа:

- Доллиг оо ... ямар сонин нэртэй юм гэж хэсэг гайхсанаа намайг тультраа гэж бодсон юмуу:

- Дорлиг юм уу гэж байна. Тэгэхээр нь би толгой дохин:

- Тийм Доллиг гэж хэллээ. Би инээсээр байлаа. Бүжинг харахаар бүр инээд хүрээд, бас өхөөрдөөд. Өнөөх анхны хайр нь их хөөрхөн болжээ. Би ч их өөрчлөгдсөн юм уу, Бүжинг харахаар л хэл гацчихаад байдаг байсан харин одоо Бүжингээс ер айхгүй хэрнээ үеийн тэр бүсгүйг ахмад хүн шиг өхөөрдөж зогссон юм. Хүн гэдэг их өөрчлөгдөх юм даа. Аргагүй ч байх аа даа. Одоо би чинь юм юмны захаас үзсэн, хорвоотой танилцсан хорин гурван настай эр хүн шүү дээ.

Хүүхэн хүнээс айхаа байсан нь тэр үү, хөгжилтэй бүсгүйг хараад сэтгэл тайвширсан юм уу, бүү мэд.

- Дорлигоо, чи юу хийдэг вэ? Чиний шүлэгнүүд надад бас маш их таалагдсан шүү гэж байна.

- Аан, би юу. Би бас чам шиг саяхан АмеЛигт суЛгууль төгсөөд иЛсэн. Хуульч гэлээ. Тультраа

хүн шиг ярихаар шийдэв. Бүр инээд хүрээд байлаа. Тэсгэлгүй бүр тасхийтэл инээж орхимоор санагдана. Гэвч биеэ барив. Ингээд бид хоёр шүлгийн тухай олон зүйл ярьлаа. Хоёулаа л гадаадад очоод гэр орноо санасан учир хааяа зав чөлөө гарахдаа шүлэг бичдэг болсон. Asuult.net-ийн уран зохиолын форумыг хэдэн жил бараг өдөр болгон үздэг байснаа ярилцацгаав. Дараа нь нэг газар орж жаахан сууж хоол идлээ.

Энэ үед миний гар утас дуугарлаа.

- Долгион уу? гэж нэг эр хүний ширүүн хоолой сонстов.

- Тийм байна гэвэл:

- Болдоо байна аа. За, миний найз сайн явж ирэв үү? Цаад хэд чинь над руу яриад чамайг ирснийг сая л хэллээ гэж миний багын найз, нөгөө миний чихийг хөлдөөдөг Болдоо ярьж байх нь тэр.

- Сайн. Сайн. 7 цагт уулзъя гэсэн. Төв шуудангийн өмнө гэлээ. Тэгтэл мань эр ч долоод ирэхээр болоод утсаа тавьлаа. Ашгүй Болдоогийн хоолойг, намайг нэрээр минь дуудахыг Бүжин сонссонгүй. Тэр ер нь их яриа болжээ. Юм яриад л, яриад л байх юм. Би инээгээд л сонсоод байлаа. Ийн байсаар цаг зургаа дөч болов. Бүжин:

- За, би явья даа. Чи долоогоос ажилтай гээ биз дээ гэвэл би:

- Үгүй ээ, ажил ч гэж дээ. Найз наЛтайгаа уулзах юм. Чи хамт яв л даа. Онцын ажилгүй бол гэсэнд Бүжин жаахан татгалзаж байснаа сүүлд нь зөвшөөрөв. Угаасаа гэртээ хийх ажилгүй гэнэ. Үнэндээ бол би түүнд таалагдаж байгаагаа мэдэрч байлаа. Бүжин бол баргийн хүнийг дагаад найз нартай нь танилцах гээд явах хүн биш билээ. Тэр тусмаа анхны болзоон дээрээ. Гэхдээ бас яаж мэдэхэв дээ. Гадаадад очоод яаж ч өөрчлөгдсөн юм билээ, би мэдэхгүй шүү дээ. Галуу шувууны мах их идээд, тиймээ.

Уг нь тэр минь урдных шигээ үнэ цэнэтэй нэгэн байгаасай гэж би бодож байв.

Ингээд бид хоёр төв шуудан руу алхав. Би янзыг нь үзээд гарнаас нь хөтөллөө. Жаахан хөтлөх аядсанаа эвгүй байгаа бололтой гараа авчихав. Тэр тусам нь би баярлаж байлаа. Харин тэр намайг инээгээд л байхыг ажаад гайхан асуувч, би юунд түүндээ үнэнээ хэлэх билээ. Би зүгээЛ л инээх дуЛтай гэж худал хэлэв.

Цаг долоо. Төв шуудангийн өмнө ирлээ. Найзууд маань цуглажээ. Би Бүжинд аятайхнаар жаахан байж байгааЛай гэж хэлээд түүнийг хэдэн алхмын цаана орхиод нөгөө хэд дээрээ ирлээ. Бүжин ч угаасаа өөрөө үлдэх сонирхолтой байв. Танихгүй эрчүүд дунд яваад очих эвгүй байсан байх.

Миний хамгийн дотно үерхдэг гурван найз байдаг ба тэдний нэг нь та бидний таних Болдоо, нөгөө хоёр нь манай их сургуулийн найзууд болох Ганаа, Сайханаа хоёр. Бид хамтдаа нэг жил хуульд сурсан билээ. Надаар дамжин Биеийн тамирын дээдийн оюутан Болдоо, хуулийн сургуулийн хоёртой маань танилцаж бас сайн найзууд болсон. Болдоо маань их өөр болжээ.

Өндөр намаараа над шиг. Тэгээд бас надаас бүдүүн. Өнгөрсөн жил аймгийн наадамд барилдаад аймгийн арслан цолтой болсон гэнэ. Ерөөсөө л хүр, хархийсэн лут эр зогсож байх нь тэр. Нөгөө хоёр маань хоёулаа бараг хэвэндээ жин жаахан л нэмсэн харагдана. Бүгд л дуу шуу болон угтав. Тэдэнтэй мэндэлчихээд, зайдуухан зогсож байсан Бүжин рүү нэг харчихаад Болдоод санууллаа.

Бүжин намайг танихгүй байгаа, миний нэрийг Дорлиг шүү гэж хэлэв. Нөгөө хэд маань юу болоод байгааг ер ойлгосонгүй. Гурван жил уулзаагүй найз нь ирчихээд л нинжаа царайлчихаад тэнэг, тэнэг юм яриад байхаар гайхсан байх.

Би сүүлд нь гараа зангаж байгаад л Бүжин рүү байн байн эргэн харж байгаад сайн тайлбарлав. Тэд ч ойлгосон бололтой, би Бүжинг дуудаж танилцууллаа.

- За, Бүжээн уучлааЛай, жаахан хүлээлгэчлээ. Манай найз наЛ танилц гэв. Ингэж хэлэнгүүт нөгөө хэд маань бүр гайхчихав. Энэ бас яагаад тультраатаад унаваа гэж бодсон нь илт. Намайг танихгүй байсан Бүжин харин Болдоог таньж байна.

- Хүүе, яасан сонин хүн бэ? Болдоо мөн үү, энэ чинь гээд гар барьцгаав. Болдоо тэгсэн татаж аваад л хацар дээр нь үнсэж байгаа харагдлаа. Их эрээ.

Нөгөө хоёртой ч бас танилцаж, ингээд бид цааш явцгаав. Ганаа авгай авсан гэнэ. Авгай нь төв шуудангаас холгүй нэг газар караоке баар ажиллуулдаг гээд бид тийшээ явцгаав.

Замдаа би олон юм ярьсангүй. Найзууд руугаа инээгээд л явлаа. Тэгж байгаад Болдоо, Бүжин хоёр хуучин танилууд учир ярих юм их байгаа бололтой бидний хойно ороод явлаа. Энэ үед би ч маяглалгүйгээр ярьж, нөгөө хоёртойгоо аж амьдрал, ойр зуурын зүйлсийг хөөрөлдөн урд нь алхаж байлаа.

Болдоо бөх хүний бүдүүн хадуун үгээр Бүжинг ёжилж байгаа нь хойно сонстов.

- Ингэхэд нөгөө Долгион хаана явааг чи мэдэх үү гэж байна. Бүжин:

- Мэдэхгүй ээ гээд чимээгүй болсноо:

- Та хоёр чинь найз байсан ш дээ. Одоо чи найзлахаа больчихсон юм уу гэж байна.

- Аан, би энэ гуравтай найзалснаасаа хойш тэр Долгионтой харьцахаа байсан. Их сонин залуу ш дээ.

- Тийм үү, Долгион яасын гэсэн чинь:

- Биеэ тоогоод, бас их бүдүүрээд, бас нэлээн өндөр болсон байх. Бүр танигдахын аргагүй болсон байна лээ. Бас тэгээд угийн л дээрэлхүү байсан. Томроод бүр хачин болсон ш дээ. Хэ-хэ гэж инээн намайг явуулбал Бүжин:

- Яанаа, тийм үү. Уг нь гайгүй л хүүхэд байсан ш дээ гээд чимээгүй болчихов. Би дотроо өөрийнхөө тухай ийн ярилцаж байгааг арай ядан сонсож байлаа. Болдоог намайг муулаад

байхаар чимээгүй байгаач гэж нэг хэлэх гэснээ Бүжинг юу гэх нь вэ гэж бодоод цааш сонсвол чихэнд чимэгтэй үг хэлэх нь тэр. “Уг нь гайгүй л хүүхэд байсан ш дээ” гэж.

“Тийм шүү. Би ч гайгүй хүүхэд байсан шүү” гэж дотроо Бүжинг дэмжлээ. Бүжин ч биеэ бариад байсан, Болдоог хараад гайгүй болж, хөгжилтэй хөхүүн яриагаараа биднийг инээлгэж эхлэв. Ганаагийн бааранд иртэл авгай нь ээжийнх рүүгээ явсан оройхон ирнэ гэж дуулдав. Ингээд Ганаа бидэнд үйлчилж бид ч баахан хөөрөлдлөө. Болдоо, Бүжин хоёр ойрхон суугаад ангийнхныхаа тухай ярьсаар, би Сайханаа, Ганаа нартай ярих юм байсан тул баахан ярилцав. Дараа нь дуу дуулцгаалаа. Эх орон, нутаг ус, амраг хайр, ээж аавын тухай баахан дуулцгаав.

Бүжин бас дуулав. Их хөөрхөн дуулах аж. Бүжин Орос дуу их дууллаа. Харин тэнд миний нэг ажсан зүйл бол Бүжин ерөөсөө л ус юмуу, жимсний шүүс уух аж. Бид харин пиво ууцгаалаа. Ганаа, Сайханаа хоёр тамхи татдаг тул тамхиа татна. Бүжинг “татах уу” гэвэл “татдаггүй” гэнэ. Би баярлаж суулаа.

Удалгүй Ганаагийн эхнэр ирж бид танилцлаа. Манай Ганаа дажгүй сайхан бүсгүйтэй гэрлэжээ. Эхнэр нь надад таалагдав.

Ийн суусаар орой болгосон, нөгөө талаас Бүжин гэртээ харих болсон тул би түүнийг дөхүүлж өгөхөөр шийдлээ. Гэвч Бүжин миний хүргэж өгье гэсэн саналыг эрс үгүйсгэв. Харин тэр Болдоогоор хүргүүлэх юм боллоо. Болдоогийнх уг нь яг Бүжингийн хажуугийн байшин гэдгийг би мэдэх боловч, Болдоогоос Бүжинг харамлах сэтгэл өөрийн эрхгүй төрөв. Болдоо ч бас өглөө эрт бэлтгэлтэй гээд харихаар болж тэр хоёр гарлаа. Би дагаад явчихмаар байвч, нэгд манай гэр нэгдүгээр хороололд биш, уг нь байсын. Тэгээд дараа нь нүүчихсэн. Хоёрт Болдоотой явчихна гээд байгаа хүнийг заавал хүргэж өгнө гээд зүтгэх нь эр хүний хувьд нэр төрөө уландаа гишгэсэн хэрэг байв. Ганцаараа явна гэсэн бол мэдээж хүргэж өгнө хэмээн шулуухан дайрах нь зөв. Харин хаанаас нь харсан ханхайсан Болдоо шиг бөх хүн хамт явж байхад би илүүц. Мөн яагаа ч үгүй өөрт нь таалагдаж байгаагаа илэрхийлээд, халамж тавиад эхлэхэд эмэгтэйчүүд дуртай ч гэсэн тэд биеэ тоохын өвчинд нэрвэгдэж, дараа нь илүү их гуйлгах гээд байдаг улс. Тэднийг жаахан үл тоомсорлосон хэрнээ сонирхсон, юу юугүй наалдаад авахыг урьтал болголгүй нууцлагдмал сэтгэгдэл төрүүлэхээр аашлахад хөнгөхөн уургалж болно. Өөрөөр хэлбэл, найрагч Ц.Хулан эгчийн хэлсэн дээрх шүлгэнд гардаг эр хүн шиг л байх хэрэгтэй гэсэн философи надад байв.

Явахаасаа өмнө харин Бүжин миний утасны дугаарыг авсан. Харин би албаар түүний гар утасны дугаарыг асуусангүй. Тэртэй, тэргүй одоо бол олоод л авчихна. Эсвэл Болдоо мэдээж, замдаа утасных нь дугаарыг асууж л таараа хэмээн эмэгтэйчүүдтэй харилцаж сурсан ангуучин шиг л бодож суулаа.

Эр хүн гэдэг тэгээд муухай амьтан юм даа. Хамаг юмаа тооцоолоод байдаг болчих юм. Өнөөх сэтгэлийн хөөрлөөр бүгдийг хийж, Бүжинг хайрлаж байсан гэнэн томоогүй хүү ийм болчих гэж. Магадгүй, амьдрал хүнийг сургаж, хүмүүжүүлж байгаа нь тэр биз дээ. Америкт байхад миний нэг найзалдаг ах байлаа. Нэр нь Довчин. Довчин ах, бид хоёр амьдралын тухай их ярина. Надаас нэлээд ах дөч гарсан хүн л дээ, уг нь. Гэсэн хэдий ч бид их сайн найзууд байлаа. Би амьдралаа бодож, санах юмгүй бүгдийг нь ярина. Довчин ах ч сайн сонсоно, бас сайн зөвлөнө. Эрчүүд ганц, хоёр лонх шар айраг дундаа тавьчихаад хээгүй сайхнаар

амьдралын тухай, мөнгө, төгрөг, улс төр, эх орны тухай, цаашилбал авгай, хүүхний тухай бие биенээсээ нуух зүйлгүй, илэн далангүй, биеэ барилгүй ярихад үнэхээр сайхан байдаг шүү дээ. Тэр л жинхэнэ найз нөхөд эрчүүдийн мөн чанар гэж би бас хааяа боддог юм. Довчин ахад би олон зүйлээ чин сэтгэлээсээ ярихад зарим нь ахад их сонирхолтой, зарим нь жаахан сонирхолгүй санагддаг юмуу “Миний дүү одоо залуу байна аа. Амьдрал бүхнийг харуулна” гэж хэлнэ, бас тайтгаруулна. Бас “Хэдий найз нөхөд, аав, ээж хүний хүмүүжилд нөлөөлдөг гэсэн. Хамгийн гол нь амьдрал чамайг өөрөө төлөвшүүлдэг юм” гэж нэг удаа хэлж билээ. Амьдрал намайг ийм л эр хүн болгочих юм даа. Анхны хайртаараа тоглоод л, янзыг нь үзээд л хөөрхийг. За, энэ ч яахав.

Уг нь миний түүнийг гэх сэтгэл хэвээрээ юм шүү дээ. Би хэн байлаа. Одоо хэн болчихов. Миний өнгөрсөн арван жилийн амьдралд хамгийн их нөлөөлсөн хүн бол яах аргагүй Бүжин. Өөрийгөө би түүнийг гэсэн сэтгэлээр ялан дийлсэн мэт санагдана. Хичээлдээ муу хүүхэд сайжирч, сул дорой оюун сэтгэхүйг хөвчилж, биеийн тамираар хичээллэсэн минь бүгд Бүжинг гэсэн сэтгэлийн хүч. Жинхэнэ хайрын хүч.

Гэхдээ одоо миний бурхан мэт шүтэж байсан Бүжин арай л өөр болжээ. Эсвэл би түүнийг арай өөр өнцгөөс хараад байж болох юм. Түүнд хайраа илчлэх надад ямар хэцүү байсан билээ. Хүршгүй оргил минь Бүжин байсан. Тэгсэн одоо би “Бүжээн би чамд хайртай” гэж хэлээд шууд барьж аваад үнсчихэд сийхгүй болсон байна. Сонин юм шүү. Эсвэл би бас нас ахиад их муухай амьтан болсон байж таарах нь.

11. Миний Бүжин

Би түүн рүү эхэлж ярьсангүй. Түүний утсыг харин Болдоогоос авсан байлаа. Гэхдээ ярихыг хүссэнгүй.

Цаг оройн долоо. Ингээд тэссэнгүй, гэрийнхээ утсыг аван Бүжингийн утас руу залгахаар шийдэн гар утсан дээрээсээ Болдоогоос авсан утасны дугаарыг харахаар оролдож байтал харин намайг залгахаас өмнө Бүжин миний утас руу залгаж таарлаа. “Овоо ш дээ, охидууд уг нь ингэдэг сэн” гэж тэрхэн зуур өөрийгөө дөвийлгөн бодоод амжив. Дахин хэлье, би их муухайгаар өөрчлөгджээ.

- Байна уу?

- Байна. Дорлиг уу?

- Тийм байна. Юу байна?

- Тайван даа. За өдрийг юу хийж өнгөрөөв дөө.

- ГЭЛ зуул гэх үү дээ. Хааяа чиний тухай бодсон шиг л өдлийг өнгөлөөлөө.

- Миний тухай бодоод оо, юун инээдтэй юм. Миний тухай тэгээд юу гэж бодов?

- Юм юм л бодлоо.

- Яг юу бодсын.

- Яахав. Сайхан шүлэг бичдэг дажгүй бүсгүй шүү л гэж бодлоо.

- Аан... Баярлалаа... Өөр тэгээд юу байна?

- Юм юм л байна.

- Тэгээд сонин сайхнаа яриач дээ гэж Бүжинг илт хандрахад би албаар:

- За, за би чам Луу жаахан байж байгаад залгая. Ээж хоолоо ид гэж дуудаад байна хэмээн худал хэллээ.

- За, за гээд Бүжин утсаа тавив.

Утсаар ярьсны дараа шал утгагүй санагдчихлаа. Миний өнөөх хайрлаж байсан Бүжин биш болжээ. Надад хөл алдсан, бараг намайг найрах гэж байгаа юм шиг нэг тийм хямдхан хүүхэн болсон юм шиг санагдав. Бусад эрчүүдэд ямар байдаг юм, бүү мэд. Би бол өөрөө гуйх дуртай. Тэгэхгүй бол над руу хандарсан хүүхэнтэй хэсэг зуур л гал халуухан байгаад эцэст нь уйдаж таарна. Харин би бол одоо эхнэр болох хүнээ хайж байгаа гэх үү дээ. Ээж, аав хоёр одооноос нэг юм олж аваад үерх, тэгээд ганц, нэг жил сайхан бие биенээ таньж мэдэж байгаад суувал

зүгээр гэх маягийн юм хэлсэн нь ч энэ бодолд нөлөөлсөн байж болох.

Ер нь найз нараа хараад байхад ихэнх нь л найз охидтой, зарим нь бүр эхнэр хүүхэдтэй болсон байна. За, тэр нь ч бас яахав, уг нь дөнгөж хорин гурван нас шүү дээ. Эхнэр ч бас яамай. Гэхдээ л энэ сая ярьсан Бүжин миний Бүжин биш байна аа, яавч биш байна. Нөгөө намайг үл тоох Бүжин минь байвал би одоо дахиад өнөөх гэнэн дурлалынхаа баатар болон хувирахад ч бэлэн. Тэгээд түүнийг найрах гэж гоё адал явдалтай учрах сан. Яг л бага байсан шигээ, өөрийгөө дайчлаад л бас гоё шүү, золиг гэж.

Ийн бодож хэсэг суугаад би Бүжин рүү эргүүлэн залгалаа.

- Байна уу?

- Дорлиг байна аа?

- Ингэхэд чиний наад хэл чинь яагаад зүгээр болчихов оо? гэж Бүжинг гайхан асуухад сая л тультраатаж ярихаа мартчихсанаа санан бага зэрэг сандарлаа.

- Аан.. юу л даа. Өргөс орчихсон байсан юм гэж би сандарсандаа мангартав.

- Юун өргөс...?

- Нээрэн юун өргөс... гэж өөрөө өөрийгөө юу яриад байгааг үл ойлгосон би бас л тэнэг юм ярьж амжив. Тэгснээ зөгийд хатгуулчихсан юм....

- Юун зөгий... гэж хэсэг чимээгүй байснаа.... зөгий яаж хүний хэлэн дээр хаздаг юм бэ? гэж гайхлаа. Би ч бас гайхав. Зөгий нээрэн яаж хүний хэлэн дээр хазахав дээ.

- Бишээ, хэл биш нүдэн дээр хазчихсан юм гэж бүр хачин юм зохиов.

Гэтэл Бүжин нэг л өөр болж, дуугаа өөрчлөн:

За,за. Чи ер нь надаар тоглоод байх шиг байна гэж хэлээд утсаа тавьчихав. Би юу ч хэлсэнгүй. Өөрийгөө ч зүхсэнгүй. Юундаа ингэж сандарсан юм бол гэж гайхав. Тэгсэн чинь долдугаар ангид байхдаа Бүжин рүү шинэ жилээр залгаснаа саначихлаа. Тэр л давтагдаж байгаа бололтой. Ялгаатай нь би утсаар яриад тэнэгтээд байлаа. Тэр үед утсаар ч яриагүй шүү дээ. Саяхан л их тайван, Бүжинг дорд үзээд байсан хэрнээ яагаад өнөөх сандардаг байдал сэдрээд байгааг ойлгосонгүй.

Би дахин залгалаа. Уучлал эрээд, цагийн дараа уулзахаар тохиролцов. Би жаахан байж байгаад гарч машинаа асаагаад нэгдүгээр хороолол руу давхилаа. Машин гэдэг маань өнөө муу өвгөн бенз маань шүү дээ. Сайхан эд дээ. Яваад л байгаа юм.

Байрных нь гадаа очтол Бүжин аль хэдийнээ орцныхоо үүдэнд гараад иржээ.

- Чи төөрсөнгүй шууд олоод ирэв үү? хэмээн тэр хөгжилтэй дуугаар асуулаа.

- Тэглээ, би нэгдүгээр хорооллыг сайн мэднэ ээ, манайх хуучин энд байсан юм хэмээн хэлбэл:

- Тийм үү, аль байранд гэвэл байшингуудын завсраар харагдаж буй хуучин байр руу заан:

- Тэнд гэлээ

- Тийм үү. Манай байрнаас жаахан хол болохоор би сайн мэдэхгүй л дээ, тэр байрныхныг. За байз... Манай ангид Долгион гэдэг банди тэр байранд амьдардаг байсан. Чи таних уу? гэж асууж байна.

- Ямар нөгөө том нүдний шилтэй, дэлдэн чихтэй хүүхэд үү. Мэдэлгүй яадгийм. Тэр чинь манай байрны тавдугаар орцонд байсан ш дээ гэхэд:

- Тийм үү, одоо байгаа болов уу? тэндээ гэж Бүжин манайхыг сонирхов.

- Би сайн мэдэхгүй байна. Нүүчихсэн байх аа.

- Аан ...

За, тэгээд нэг иймэрхүү юм баахан ярьж суулаа. Гадаа сайхан байсан тул гадуур жаахан алхав.

- Өө, нээрэн чиний наад хэл чинь яагаад зүгээр болчихвоо. Чи надаар тоглож байсан юм уу? хэмээн хөөрхөн нүдээрээ инээмсэглэн миний анхны хайр надаас асуув.

- Үгүй ээ, өнөөдрөөс л зүгээр болчихлоо. Хааяа зүгээр болчихоод, хааяа тультраад байдгийм гэж яах аргагүй худал хэллээ. Өөр зохиогоод хэлчихмээр юм олсонгүй. Бүжин бодвол итгээгүй байх.

Удалгүй гадаа харанхуй боллоо. Бүжин хөгжилтэй юм ярьсаар явна. Түүнд би их таалагдаж байгаа бололтой, эсвэл тэр арван жилээсээ хойш их өөрчлөгджээ. Магадгүй, найз залуутай ч байж үзсэн биз. Амьдрал гэдэг хүнийг нэг дор нь бариад байх биш дээ. Гэнэн хонгор жаахан охин тэр чигтээ байна гэж юу байх билээ.

Би түүнийг орцонд нь оруулж өгөв. Ингээд:

- За баяртай. Маргаашнаас ярья гэж Бүжин хэллээ. Энэ үед ерөөс зүгээр байж болсонгүй, багын дурлал сэдрэв үү яав, барьж болдоггүй зуршил хөдлөв үү, эмэгтэй хүнийг ингээд зүгээр гэрт оруулчихаж чадсангүй. Гараас нь татаж авчраад л шууд уруул дээр нь үнслээ. Өөртөө дэндүү итгэснийх.

Бараг л үнсээд орхивол яах бол гэж басамжилсан, янз үзсэн бодол толгойд орж ирсэн байж болох.

Хэдий түүнтэй шүлэг бичилцэн олон саруудыг арлаа орхисон ч гэлээ, тэр бол зүгээр нэг Урин биш, миний анхны хайр Бүжин шүү дээ. Тэгэхээр яах аргагүй миний хувьд шүлэгч

бүсгүй Урин гэхээс илүү анхны хайр Бүжин нүдэнд үзэгдээд, анхны хайрын дурдатгал зүрх сэдрээгээд байсан минь тэр. Бүжинг надад сайн байж, наалинхайтах тусам анхны хайрын эзнээ ийм болчих гэж, хайран юм гэж халаглаж байлаа. Ер нь юу гэмээр юм бэ дээ. Хайраа харамласан байж болох, эсвэл өөрөө түүнийг гэж хэдэн жил амьдарснаа шал дэмий зүйл хайрлаж, шаналж, сэтгэлдээ ариухнаар мөнхөлж байж гэж бодсон хэрэг. Өөрөөр хэлбэл, зорьсон зорилгодоо хүртэл тэр нь анх бодсон шиг алт байсангүй. Зүгээр нэг шороо байжээ гээд ихийг санан алсыг зорьсондоо гутрах шиг болж байлаа. Ийм л амархан бүтэх хайр, хөнгөн охин байсан юм бол би төдий олон жил өөрийгөө дэмий зовоосон байж таарав.

Тэр гайхаад, тэгснээ толгойг минь барьсан гарыг минь тавиулах гэж хичээв. Би тавьсангүй, бүр озсоор байлаа. Надад түүний эсэргүүцэл таалагдав. Цааш нь яахыг харья гэж тэрхэн зуур бодож амжлаа. Бүжин тийчлэж эхлэв. Одоо ингэсгээд номхроод өөдөөс үнсэх байх гэтэл тэгсэнгүй бүр бачимдан, уурлаж байгаа нь мэдэгдэв. Надад бүр их таалагдав. Одоо нэг алгадаад авбал ч бүр гоё доо гэж бодох.

Бүжин тийм амархан бүсгүй биш байгаасай гэж бодогдоно.

Би бүр давраад нуруугаар нь нэг гараа оруулан тэврээд авлаа. Тэгсэн чинь хоёр хөлийн завсар түсхийгээд би салтаагаа барин өөрийн мэдэлгүй газар суух нь тэр.

Ёох... дуу ч гардаггүй. Аймар өвдөж байлаа. Би бас аймар баярлаж байлаа. Нэн сонин гайхмаар. Хүн өөрийнх нь хөлийн хоорондохыг өшиглөж байхад би түүнд нь баярлаж байдаг. Тэрхэн зуур энэ миний хайр мөн байна. Анхны минь хайр Бүжин, миний Бүжин гэх баяр төрнө. Юу юуны туханд хүрэлгүй л шууд эхнэрээ болгож авна ч гэх шиг алсын бодол толгойд эргэлдэв. Алгадуулна гэж бодсон хулхидуулсан болж таарав. Тэгээд би:

-Ёох, чи яаж байна аа? хэмээн арай ядан дуугартал сэтгэл нь хямраад, доромжлогдсон Бүжин ихэд гомдсон бололтой уйлж, нус нулимсандаа баригдсан амьтан:

- Чи битгий хуц. Чи ямар муухай балиар амьтан бэ? гэж байна.

- Эр хүний эмзэг газар руу өшиглөдөг чи харин яасан муухай амьтан бэ? гэж би бас тэнэгтэв. Бүлдэгдүүлсэндээ бие суларч, ухаан балартсан юм уу, эсвэл эхнэрээ болгоно гэж бат итгэсэн үү, магадгүй бүр баярласандаа хөөрсөн үү төмсгөө барьсан чигтээ:

- Алсдаа чамд л хэрэгтэй байх. Би ч яахав гэж хэлэв.

- Юу хэрэгтэй гэж? ...

- ...Төмсөг... гэж би бат итгэлтэй дуугарав. Бүжин бүр нүд нь орой дээрээ гарах шахан гайхаж, энэ муу яасан биеэ тоосон новш вэ? гэж бодсон байх:

- Юу гэнэ ээ, чи. Май чи гээд дахиад өшиглөхөд нь арай гэж л гараараа хааж амжлаа.

- Дорлигоо, би чамайг арай ч ийм бүдүүлэг амьтан гэж бодсонгүй. Би уг нь чамайг арай өөр хүн гэж бодож явсан юм. Би чамд дурлачихаад явж байлаа. Чи гэтэл даанч яав даа хэмээн дуу

алдан уйлсаар нэг давхар өгсөөд гэртээ орж явчихав. Гэрийнхэн нь гайхан дуу алдаж:

- Яав, юу болов гэгцгээж байгаа сонсогдоно. Би төмсгөө барьсан чигтээ хогийн бункерийн тийшээ нуугдаж амжлаа. Аягүй бол уйлсан охиноо хараад ээж, аав нь цагдаа дуудаж мэднэ. Бөөн юм болно. Нүдэнд нь үзэгдээд хэрэггүй гэж айсан нь тэр.

Би ихэд баяртай гэрийн зүг жолоо залав. Хэдий төмсөгдүүлж, хайртыгаа гомдоосон ч гэсэн. Би түүнийгээ буцаан олж авлаа шүү дээ. Маргаашнаас бүх юм өөрчлөгдөнө.

Миний Бүжин мөн байна. Хар багаасаа дурласан сэтгэл сэдрэх нь тэр. Хайрын нандин үгээ одоо л чамдаа хэлнэ дээ. Би чамд хайртай, Бүжээн.

Гэм нь бие жаахан хөндүүртэй. Ёо-ёо-ёо.

12. Анхны хайр

Би түүнд аажим аажмаар дурлаж эхэллээ. Зүс царайг нь үзээгүй ч гэлээ, би тэр залууд дурласан юм. Тэр надад хайртай хэмээн хэлээгүй, би түүнд ч бас хайраа илчлээгүй ч гэсэн бие биенээ танихгүй бидэн хоёрын сэтгэл нэг зүгт чиглэж байгаа мэт сэтгэгдэл төрнө. Зүсийг нь үзээгүй, хоолойг нь сонсоогүй ч гэлээ би түүнийг сайн хүн, сайхан хүн гэдэгт итгэж байсан юм. Бичсэн шүлэгнийх нь дор би бас хааяа шүлэг бичнэ. Миний бичсэн шүлгэнд тэр хариу бичихдээ “Урьхан минь ээ” хэмээн энхрийлэн дууддаг нь сэтгэлд нэг л ойр гэх үү дээ. “Урьхан минь” гэж бичсэн нь намайг ихэд ойрхноор төсөөлсөн, магадгүй бүр энхрийлсэн мэт сэтгэгдэл төрнө. Гэхдээ энэ бол зөвхөн миний л бодол. Бодонгийн бодол биш.

Би их мундаг шүлэг бичиж чадахгүй ч гэлээ сэтгэлдээ хөглөгдсөнөө цаасан дээр буулгах дуртай. Ялангуяа аравдугаар ангидаа хүүхдийн яруу найргийн “Хүрэл тулга” тэмцээнд орж, гуравдугаар байр эзэлснээсээ хойш бүр их урам орсон билээ.

Хэ-хэ, Бодон шүү. Бодон байхдаа яахав дээ. Тийм аймар нэр өөртөө өгчихөөд бас шүлэг бичээд байдаг нь нэн сонин. Хайрын тухай уянгын шүлэг бичдэг хүнд энэ нэр огт тохирохгүй юм шиг. Бодон. Магадгүй гахай ч гэсэн хайр сэтгэлтэй учирч болно гэсэн сэтгэлээр тэр өөртөө ийм нэр өгсөн байх л даа. Гэвч хааяа тэр их сонин өнгө аястай шүлэг бичнэ. Жишээ нь: Мунхаг гэдэг шүлгээ нэтэд тавьсан байсныг хэлвээс:

Мунхаг

Нэг харсан чинь

Тэдэн оны тэдэн сараас тэдэн оны тэдэн сар гэсэн

Нар, салхинд илэгдэж, эмхэрсэн цементэн хавтан дээр

Би шээж байлаа.

Намайг хүн болохоос өмнө төрөөд

Нартыг бас л аль эрт орхисон

Хэн нэгний хэнд ч хэрэггүй,

Хэмхэрч нурсан булш байлаа.

Тархинд бүжиглэх тамхины утаа,

Тааж, мартуулах тансаг ундаа...

Халамцуу би “түүн” дээр бас бөөлжлөө.

Харин тэгсэн тэр

Хүүе гээд давхийн боссонгүй

Хүү минь яахнав дээ гэж аргадсангүй

Хөшүүн хөдөлгөөнгүй тэр булш

Хүний орчлонг цочоосонгүй ээ.

Мунхаг намайг тэр өөртөө ойртож байгааг л мэдрээд

Муулсан ч үгүй, сайшаасан ч үгүй.

Хойд төрөлдөө хоёулаа уулзахаас хойш гээд

Хоёр гурван үг ч солихыг хүссэнгүй ээ гэж бичсэн байлаа.

Нэг бодлын аймаар ч юм шиг, эс бөгөөс нэлээн архи уудаг нэгэн шиг.

Иймэрхүү булш мулшны тухай бичсэн байсан. Тиймээс би түүнийг жаахан танхайдуу эр байх гэж төсөөлж байлаа.

Гэхдээ бас захиа бичихгүй байх шалтгаан бас бий. Тэр хүнийг одоогийнх шигээ сайн сайхнаар төсөөлөөд, үл таних тэр эрийг далдхан хайраараа бүүвэйлээд, алсаас бичсэн үгэнд нь согтоод цаашид амьдрах надад сайхан байлаа. Энэ гэгээхэн мэдрэмжийг заавал тэр хүнтэй уулзаж, эвдээд юу хийх билээ дээ. Магадгүй миний төсөөлснөөс шал өөр, муухай хүн байвал яана. Тиймээс түүнд далдхан дасаад л хайрлаад явж баймаар санагдана. Түүнийг үнсэх ч үгүй, үнсүүлэх ч үгүй. Өдөр бүр тэр минь asuult.net-д орж юм бичиж үү хэмээн догдлон суух нь миний жаргал байлаа.

Англид ирснээс хойш адал явдал гэх юм байхгүй жирийн нэг өдрүүд өнгөрсөөр байлаа. Хичээлд явна, тараад ажилдаа очино, ирээд унтана. Хагас бүтэн сайнд найзуудтайгаа жаахан гадуур явна тэгээд болоо. Энд ирсэн эхний жил хүндхэн байв. Хүн амьтантай ч нийлэхгүй уйтгарлаад л, бас дээр нь гэрээ их санана. Дараа нь гайгүй болсон. Дасч эхэлсэн.

Нөгөө Долгион гээд байсан “хачин” банди надад захиа бичээгүй, тэгээд л сураггүй болсон. Угаасаа ч яаж бичихэв дээ, би өөрөө жаахан мангартаад, бас дээр нь тэр үед төрж байсан сэтгэгдэл энгийн нэг шохоорхол гэдэг нь батлагдаж, би түүнийг бүр мартчихсан билээ. Зуны амралтаараа Монголд хоёр удаа очсон боловч ер тааралдаагүй, сураг ч сонсоогүй...

Хайраа гэж...

Хайр нь юмуу, шохоорхол нь юмуу, алин болохыг таньж мэдэхийн аргагүй. Жирийн нэг өдрүүд ээлжлэн өнгөрсөөр би нэг л мэдэхэд сургуулиа төгслөө. Гэтэл Монгол буцахаас өмнөхөн нэг өдөр миний нэтийн хаяганд Бодонгоос захиа ирсэн юм.

“Сайн байна уу? Урьхан минь,

Би Монгол буцах гэж байна. Чи хаана байдаг, хэн гэдэг хүн бэ? Би чамтай танилцмаар байна” гэсэн захиа байлаа. Сэтгэл догдолж, ихэд баярлав. Монгол буцах гэж байгаа гэдэг нь тэр яг л над шиг өнөө маргаашгүй харих гэж байгаа бололтой гэж таамаглаад хариуд нь:

“Нэр усыг уулзаж байгаад хэлье. Би ч бас удахгүй Монгол буцна. Уулзмаар байгаа бол зургаан сарын хоёронд Сүхбаатар ахын дор дөрвөн цагаас уулзъя. Бодон гуай” гэж бичээд явуулчихлаа.

Заавал зургаан сарын хоёрон байдаг нь зургаан сарын гурванд миний төрсөн өдөр. Би төрсөн өдрөөсөө өмнө түүнтэй танилцаж, магадгүй төрсөн өдрөөрөө түүнийг урина гэсэн бодол тээсэн байж болох юм. Тэр өдрийг би догдлон хүлээсэн, түүнийг ямар хүн байгаа бол хэмээн чин сэтгэлээсээ догдолсон.

Зургаан сарын хоёрны өдөр. Сүхбаатарын талбай. Би өөрөө ч мэдэлгүй болзсон газар руугаа алхах биш бараг гүйж байлаа. Болзооноосоо таван минутын өмнө ирээд зогсов. Ойр хавьд нэг цэцэг барьсан, нүдэнд дулаахан, биерхүү залуугаас өөр хүнгүй байлаа. Энэ залууг Бодон мөн байгаасай хэмээн ихэд хүсч, бурхандаа залбирав. Үнэндээ би Бодон биш ч байсан шууд л анхны харцаар дурлчих шиг боллоо.

Би хэзээ ч эр хүнийг анх хараад ингэж сэтгэл алдарч байсангүй. Би найз залуутай ч байж үзээгүй. Аав, ах хоёроосоо өөр эр хүнд үнсүүлж үзээгүй хацар минь жаахан ичингүйрэн улайлаа.

Тэр залуугаас “Бодон мөн үү” гэж асуухаас өмнө ээжийнхээ зааж өгсөн хүсэл бүтээгч маанийг дотроо ихэд хичээнгүйлэн байж, бурхандаа залбиран гурвантаа уншив. Бодон мөн байгаасай хэмээн чин сэтгэлээсээ хүссэн нь тэр.

Түүнтэй мэндлэв. Асуув. Цэцэг авав. Мөн байна, тэр минь мөн байна. Зүрх түг түг цохилон, жаргалдаа мансуураад би золтой л муураад уначихсангүй. Болдогсон бол түүнд шууд тэврүүлээд энгэрт нь наалдах сан. Би ямар их жаргалтай байна вэ, бурхан минь баярлалаа.

Би одоо болтол найз залуугүй явсан минь, хүнд тоогддоггүй, царай муутай эсвэл эр хүнийг өөртөө татах увидасгүйдээ биш гэдгээ би мэднэ. Надад эрчүүл хайраа илчилж байсаан үнэн. Олон биш ч гэлээ, надад сайн хүмүүс байсан би тэр болгонд сэтгэл алдарч байсангүй. Угаасаа хайргүй, эсвэл хайр төрөхгүй бол өөрийнхөө сэтгэлийг хуурч, зуурдын жаргал хөөхийг би хүсдэггүй. Найз охид маань намайг эрчүүдтэй дэндүү шударга харьцдаг, бас тэдэнд өөрт минь ойртох нэг ч бололцоо олгодоггүй, ширвээд алга болдог хэмээн буруушаадаг билээ. Би өөрийнхөө тиймийг мэдэх ч гэсэн, миний хайж байгаа хүн энэ амьдралд байгаа гэдэгт харин эргэлзээгүй. Миний хайрын бурхан намайг нэг газар хүлээж л суугаа гэдэгт би бат итгэлтэй байлаа.

Харин би энэ удаад хазаж болдоггүй алим, харж болдоггүй үзэсгэлэн байхыг хүссэнгүй. Бодондоо... бишээ, түүний хэлснээр Дорлигтоо аль болох сайн хандахыг хүслээ. Магадгүй найз охид шигээ эр хүнд жаахан наалинхайтаад авахад буруу нь юу байх билээ. Эрчүүд

эмэгтэй хүний ийм занд дуртай байдаг гэж хүүхнүүд ярих. Нэгэнт л энэ хүн надад таалагдаж, би түүнийг алдахыг хүсэхгүй байгаа болохоор урьдны “шударга” охин Бүжин биш, бүсгүй хүн Бүжин байхыг хичээлээ. Дорлиг жаахан тультраа юм. Гэхдээ тэр яахав, би түүнийг гэсэн сэтгэлээ нэгэнт хорьж дийлэхээ байжээ.

Намайг өөрт нь сайн байгаад байхад Дорлиг анх танилцсан шигээ л хөндий ч биш, ойр ч биш, хүйтэн ч биш, нэг л ихэмсэг байлаа. Яагаад байгааг нь ер ойлгосонгүй. Гэтэл түүний сайн найз нь манай арван жилийн Болдоо болж таарав. Уг нь Долгионы найз шиг санагдана. Тэгтэл тэр Долгион нь хүнээ байсан юм байх. Багадаа л жаахан дэггүй товариш байсан, одоо бүр дийлдэхээ байсан гэнэ. Ер нь л муу хүн болсон гэхийг найзаас нь сонсоод бодвол архичин болоод эсвэл гэмт хэрэгтэн болоод бүр хүнээ байсан байх нь гэж бодлоо. Хайран залуу. Уг нь найм төгсөх жил хичээлдээ их сайн болсон байсан. Дараа нь их сургуулийн хуулийн ангид орсон гэсэн шүү дээ. Арав төгсдөг жил манайх руу хөөрхий их залгадаг байж билээ.

Нэг үдшийг бид Дорлиг болон түүний найз нартай ихэд зугаатай өнгөрөөв. Үдэш би Дорлигтой юм ярихыг хүссэн ч тэр надаас жаахан зайгаа бариад байгаа юмуу, эсвэл найзуудтайгаа ярих ёстой тийм чухал зүйл байсан юмуу, намайг Болдоотой суулгачихаад надтай бараг юм ярьсангүй. Бид каракед орсон болохоор дуу дуулцгаасан. Би Дорлигт жаахан гомдоод, Болдоогоор хүргүүлсэн билээ.

Бүсгүй хүний сэтгэл гэдэг хөөрхийлөлтэй зүйл байдгийг би өнөөдөр л ойлгов. Эр хүн байсан бол таалагдсан бүсгүйгээ өөрийн болгох гэж чаддаг бүхнээ хийхсэн. Энэ нь эр хүний нэр төрийн хэрэг, эр хүн болж төрснийх нь баталгаа байж болох. Харин эмэгтэй хүн таалагдсан эр хүнээ хүлээхээс өөр замгүй, эм хүний сэтгэл гэдэг ёстой заяа төөрөг нь л мэдсэн хэрэг ажээ. Эмэгтэй хүн бүхнийг хийнэ гэдэг нэн сонин ойлголт. Эр хүнийг ямар, тэдний хэлдгээр найралтай биш. Нэр хүндээ алдаж, бусдын доог тохуу болохын нэр. Ийн бодсоор унтаж орхилоо. Маргааш миний төрсөн өдөр.

... Төрсөн өдрийн өглөө би ихэд жаргалтай сэрлээ. Гэрийнхэн маань баяр хүргэж, ээж аав хоёр минь намайг өхөөрдөөд л сайхан байв. Би нэг ахтай, айлын отгон нь. Эрх гэж жигтэйхэн. Багаасаа л эрхлэх өвчнөөр занимаалдчихсан ...Таван цагт найзууд маань ирлээ. Ээжийн хийсэн хоолыг амтархан идэж, хүслээ дотроо шивнэн бялуугаа хуваав. Дотроо Дорлигийг л бодож хүслээ хэлсэн. Дорлигийг утасдах байх гэж хүлээсэн боловч, би түүнд утсаа өгөөгүйдээ харамсаж байлаа. Өөрөө эхэлж залгавал ичгүүртэй хэрэг болно. Тэр надад утсаа өгчихөөд, харин минийхийг аваагүй, гомдмоор...

Бас нэг гомдмоор зүйл нь би өдөржин нэтэд орж захиагаа шалгасан боловч түүнээс юу ч ирээгүй. Сэтгэл үймрээд ихэд эвгүй. Уг нь өнөө өглөө их сэргэлэн сэрж, сэтгэл өөдрөг байсан сан...

Цаг оройн долоо. Тэсэлгүй утас цохилоо. Тэр минь жаахан хөндийвтөр байснаа утсаа тавиад, над руу дахин залгав. Цагийн дараа уулзахаар болж, би гэрээ зааж өглөө. Миний багын найз Мөрөн, түүний нөхөр, бас хэсэг найз нар маань ирсэн байсан юм. Тэд нар маань гадуур гарч, нэг газар жаахан сууя гэсэн санал тавьсан боловч би тэдэнд нэг хүнтэй уулзах ёстойгоо эвтэйхэн хэлж ойлгуулсан. Тэд миний өмнөөс их баяртай байлаа. Олон ч юм асуусангүй,

хүнтэй болжээ гэдгийг гадарлацгаав.

...Тэр минь ирлээ. Дөнгөж өчигдөр танилцсан ч, хэзээ ч надад ийм мэдрэмж төрж байсангүй. Хайр гэж байдаг бол, тэгээд бас анхны хайр гэж байдаг бол тэр миний анхны хайр. Амьдралд минь учирсан анхны хайр. Урьд нь төрж байгаагүй тэр л мэдрэмжийн эзэн. Дорлиг минь дээ, би чамд ямар их хайртай гээч... Дорлиг минь...

...Бид зугааллаа. Мөхөөлдөс авч идэв. Урьд нь зөндөө л мөхөөлдөс авч идэж байсан, гэхдээ ийм амттай мөхөөлдөс идсэн нь анхных. Ямар гоё мөхөөлдөс байв аа...

Дорлигийн бичсэн нэг шүлгийг би өөрт нь уншиж өгөв.

Хавар үгүй бол өвөл зун гэж байхгүй юм шиг

Хайр үгүй бол чи бидэн хоёр уулзахгүй юм шиг

Нар үгүй бол шөнө гэж байхгүй юм шиг

Намайг үгүй бол чи бас үгүй юм шигээ...

Юм шиг гэдэг үг энд илүүдсэн ч юм шиг

Юм юмны захаас өгүүлмээр ч юм шиг

Хайрынхаа нууцыг дэлгэмээр юм шиг

Халуун зуныг хүйтрүүлмээр юм шиг

Үнсэж орхичихоод зугтмаар юм шиг

Үүлгүй тэнгэрт нисмээр юм шиг

Гуниггүй сэтгэлийг тарчлаамаар ч юм шиг

Гутарч байснаа инээмээр ч юм шиг

Дөнгөж авсан зүйлээ гээчмээр ч юм шиг

Дөнгөлж орхисон сэтгэлээ буцаамаар ч юм шиг

Юм шиг гэдэг үг энд илүүдсэн ч юм шиг

Юм юмны захаас чамтай ярьмаар ч юм шигээ...

Тэр дуугүй л инээгээд байлаа. Хайр үгүй бол Дорлиг, бид хоёр нээрэн учрахгүй юм шиг л санагдаж байв.

Гадаа харанхуй болж, би гэртээ орох боллоо. Манайх таван давхарт. Бид хоёр дөрвөн давхрын

шатаан дээр жаахан зогсож ярилцав. Ярилцах ч гэж дээ. Би л ер нь, энэ хоёр өдөрт их ярьсан юм байна. Дуугүй байгаад байвал Дорлигийн намайг гэсэн сонирхол буурчихвий гэж айсан хэрэг. Дорлиг ерөөсөө угийн ийм хүн юмуу, мэдэхгүй. Их сонин зантай ч юм шиг. Өчигдөр тультраатаад байсан, өнөөдөр зүгээр болчих юм. Тэгээд намайг нэг л сонин харцаар шинжээд байгаа юм шиг харна, ер бүү мэд ээ. Эсвэл янз үзээд байгаа ч юм шиг. Гэхдээ тэр бүгд нь сонин ч, би түүнд татагдаж байсан юм. Нэг бол намайг тоохгүй байна гэж бодохоор гомдол төрнө.

Чухамдаа түүнд л хайртай сэтгэлээр Бүжин өөрчлөгдөж, наалинхайтаж, чөлөөтэй байхыг хичээн олон хөгжилтэй зүйл ярьж байгааг тэр ойлгоогүй. Гэртээ орохын өмнө “Баяртай” гэж хэлээд салахын зуур тэр намайг өөр рүүгээ татаад түрэмгийлэн үнслээ. Надад түүний энэ зан таалагдсангүй. Эмэгтэй хүнтэй уян зөөлөн, хүндэтгэлтэй харьцаж болно шүү дээ. Юу болох нь энэ вэ, арай ч дээ. Би анхны үнсэлтээ ийм балиар байдлаар төсөөлж байсангүй. Шалиг завхай эр хүний гар цамцны дотуур ар нуруугаар минь орж тэвэрлээ. Илж таалах нь бүр заваан. Уг нь би Дорлигийн тэвэрт эрхэлж, түүнд үнсүүлэхийг хүсч байсан. Гэтэл тэр Дорлиг нь эзэрхийлж, түрэмгийлсэн шалиг эр болж таарав. Гарыг нь нуруунаасаа авах гэж хэчнээн хичээж, уруулыг нь зайлуулах гэж хэчнээн тийчигнэсэн ч сул дорой бүсгүй хүн залуу эрийн булчинлаг гараас мултарч чадсангүй би цөхөрлөө. Дотроо түүнийг битгий, болиоч дээ, гуйя гэж хэлж байсан боловч, түүний талаарх сайхан бодол хормын төдийд өөрчлөгдлөө. Тэр миний бодож байсан хүн биш байх нь.

Аргаа ядсандаа би шууд түүнийг өшиглөж орхилоо. Жаргалдаа ташуурсан сэтгэл минь зовлонгоор эргэж, золгүй миний анхны хайр хоёрхон хоногийн настай байжээ. Гомдсон сэтгэлээр уйлсаар гэртээ орлоо. Дахиж энэ заваан залуутай уулзахгүй гэж өөртөө тангараглав. Би азгүй бүсгүй ажээ.

Хайр гэдэг зүйлийг мэдрээгүй байж нэг удаа муу ёрлоод би ийм нэг шүлэг бичсэн юм.

...Олон сайн хөвгүүний сэтгэлийг

Ойшоож би хараагүй хэрнээ

Огтоос надад хайргүй нэгэнд

Өөрөө би дурлалчихсан...URIN

Одоо яг л энэ түүх надад тохиолдож байна. Би түүнтэй дахиж уулзахгүй, хэзээ ч. Хэрэв тэр надад хайртай байсан бол, өчүүхэн ч гэсэн хүндэлж харьцсан бол намайг ингэж доромжлохгүй шүү дээ. Дорлигийн аахилах амьсгаа, заваан шүлс, нуруугаар нь дур мэдэн, эзэрхийлэн тэнэсэн тэр гар, хүч түрэмгийлсэн тэр байдлыг бодохоос ой гутав. Яаж ашгүй хүчиндүүлчихэлгүй салсан юм.

Сэтгэл эмтэрсэн, дахин эрэгтэй хүнд тийм амар итгэж чадахгүй гэдгээ л сайн ойлгож байлаа.

... Анхны хайр...

Анхны хайр ариухан гэдэг худал ажээ.

13. Уучлал

Хоёр, гурав хоног бэлтгэл хийж жаахан гүйсний ачаар арай ч бахардаад уначихалгүй үзээд байлаа. Сумын наадмын торгон ногоон дэвжээнд хүчит бөхчүүдийн дунд ингээд барилдаад зогсож байна гэж хэн санах билээ. Амьдралыг минь өөрчилж, үргэлж шинийг эрэлхийлүүлэн байдаг өнөөх анхны хайрын хүч бөлгөө. Чиний төлөө би бүхнийг хийж ирсний хэрээр өөрийгөө өдөр бүр туршиж нээж ирсэндээ анхны хайр минь чамдаа би баярлана. Анхны хайр магадгүй үхэн үхглээ сэтгэлээ зориулах цорын ганц хайр ч байж болох юм. Хэн мэдлээ, цаг хугацаа бүгдийг харуулна бизээ.

Гурвын даваанд цолтой бөхчүүд ам авахаар хөлийн цэц рүү алхаж байгаа харагдана. За, тэгээд хэнбугайд нь амлуулж, ясаа яйруулах юм болдоо хэмээн дотроо жаахан эмээж л суулаа. Болдоогийн өмнө нэг хөгшин арслан ам аваад буцав. Болдоо ч гэсэн амаа аваад ирлээ. Хажууд дуугүй л ирээд суучихав. Мэдээж Болдоо намайг авахгүй. Харин тэгж явсаар би гучин тав орчим насны шарангуй царайтай сумын заанд амлуулж таарлаа. Сонсвол шуундаа их бярттай, нэлээн хөдөлгөөнтэй барилддаг эр гэнэ. Бас сумын сургуулийн биеийн тамирын багш юм байх.

Айх сэтгэл ер төрсөнгүй. Юунаасаа ч айх билээ дээ. Үнэндээ надаас илүү бярттай хүн энд байхгүй юм шиг л санагдаж байлаа. Би Болдоог аймгийн арслан гээд мундаг пээдэлзээд байхаар нь их бярттай байх гэж бодоод, хүчний бэлтгэл дээр нь хамт очиж түүнийг харсан. Гэтэл Болдоо 130 кг –аар нусаа хацартаа нааж, чацга алдах нь холгүй юм болж байж цээжээрээ хоёр, гурав өргөхчөөн аядсан юмдаг. Харин би тэрийг аажуухан хорь өргөчихсөн. Тэрнээс хойш би Болдоог бөх гэхээр мундаг эр гэж сүрдээд байсан маань хормын төдий алга болчихож билээ. Найзыгаа мундаг бөх, аймгийн арслан гээд шүтэж байсан маань хормын төдийд алга болчихсон. Учир нь юу гэвэл би ч гэсэн жаахан барилдаад эхэлвэл бөх болж болох юм байна шүү дээ. Торгон ногоон дэвжээн дээр эрийн дээд бөх хүний зодог, шуудагнаас барилцаад, давахгүй юмаа гэхэд хийморио сэргээгээд авна гэдэг сайхан хэрэг. Гэхдээ бөх гэдэг ганцхан хүчний бэлтгэл биш юм гэдгийг сүүлд ойлгосон доо. Туулын эрэг дээр очиж барилдахдаа Болдоод хагартлаа хэд сайн шидүүлж аваад хаширсан, өнөөх өөрийгөө дөвийлгөсөн бодлоо орхисон. Харин Болдоо намайг өсөх ирээдүйтэй сайн залуу бөх байна гэж магтаж билээ. Тэгээд сумын наадамд бол чи торохгүй түрүүлэх юм байна хэмээн урам өгснөөр би энэ сумын наадамд хүчээ үзэх гэж ирээд сууж байгаа минь энэ.



Бас нөгөө нэг учир бол энэ сумын наадамд Бүжин гэрийнхэнтэйгээ ирсэн байгаа. Аав нь энэ нутгийнх болохоор нутгийнхаа наадмыг үзэж амрахаар гэр бүлээрээ энд ирснийг Мөрөнгөөс би сонссон.

Өөрийнхөө бүтэлгүйгээс болж хайртай хүнээ алдахгүйн тулд өнөөх эр хүний арван гурван мэхний нэгийг хэрэглэж үзье гэж бодсон юм. Бас өөрийгөө хэн билээ гэдгийг албан ёсоор мэдүүлэх гэсэн хэрэг. Би чинь, Дорлиг биш, Бодон биш, зүгээр л нэг Долгион шүү дээ. Улсын наадам болоход хэд хоног дугуу боловч намайг гуйсан учраас Болдоо надтай хамт энд ирсэн. Хоёулаа үзүүр түрүүнд үлдэх санаатай гэх үү дээ.

Эмэгтэй хүн гэдэг нэн сонин ертөнц. Тэд нэг бол доожоогүй гэх юм уу, дуугүй нэгэнд сэтгэл алдаж мэднэ. Тэгснээ жаахан байж байгаад сонирхол нь буурч мэднэ. Эсвэл хүч чадлаа гайхуулсан сайхан залуу эрийг хараад өөрийн эрхгүй бахдал төрнө. Тэгээд тэр төрсөн бахдал дээр нь нэг дөрөөлөөд авбал өөрийн болгоход их амархан мэт. Эмэгтэй хүн гэдэг үнэхээр сонин ертөнц шүү. Өөрт нь хайртай хүнийг өчнөөн жил гуйлгаж гувшуулж, үл тоочихоод, хормын төдийд өөр нэгэн залуугийн тэвэрт үг дуу ч үгүй давхиад орж мэдэх тийм л нэг ертөнц. Тааж мэдэхийн аргагүй. Энэ нь өнөөх л хайрын хүчтэй холбоотой асуудал. Хайрын хүч хүнийг ухаантай ч болгож мэднэ. Эс бөгөөс ухааныг нь алдуулж мэднэ.

Нэгхэн шөнийг хамтдаа өнгөрүүлээд дайнд явсан залууг насаараа хүлээсэн эмэгтэй хүн ч байх, нэг бол насаараа хамт амьдарчихаад насны эцэст өвгөнөө өдөр шөнөжин далд ороосой хэмээн үглэх эмгэн ч байх.

Эсвэл энэ бүхэн зүгээр л амьдрал баян гэдгийн баталгаа байж мэднэ.

Харин Бүжингийн хувьд Дорлигийг ч тэр, Бодонг ч тэр, бүр Долгионыг ч тэр харахыг үл хүснэ. Хэчнээн оролдож хичээгээд ч, тусыг эс олов. Түүнтэй уулзах гээд яваад очихоор харааж, зүхээд хөөгөөд байх. Өөрийгөө Долгион байна, Дорлиг биш гэхээр тоглоом хийгээд байна гэж бүр тэс өөр зүйл ярина.

Харин сумын наадамд нэрээ дуудуулаад гарахад эрх биш үнэмших байх хэмээн бас горьдсон

Сумын заан. Хэ-хэ”

Туг тойров. Өнөө эхний даваанд болжмор шиг байсан бөх чинь одоо нөгөө хангарьд, начин, шонхор шиг гэлтэй бөгс тээр хойно, цээж тээр урд, гар гэдэг чинь яг л БОИНГ-ны далавч шиг дэвж гараваа, хөөрхий.

Даанч Бүжин л байсангүй.

Яруу найрагч Ш.Дулмаагийн хэлсэнчлэн “Хайртай бүхэн ханьсдаггүй салаа замын уулзвараас харууслын мананд төөрч өнчин зүрх гансарсан” гэдэг үг үнэн ажээ. Үнэхээр хувь зохиол гэдэг бурханы зурсан төөргөөр гэлдэрдэг болж таарлаа. Энэ хол газар зөвхөн Бүжинг зорьж ирээд түүнийгээ олсонгүй. Бас л нэг шалгуур давж бөх болчихов. Хэдий би өөрийгөө бөх гэж бодохгүй байгаа ч гэсэн Улсын наадмын тухай хуульд сумын заан гээд цол заачихсан байхад би яах билээ гэж өөрийгөө дөвийлгөнө. Өнөөх бага насандаа Бүжингийн төлөө хэмээн өөрийгөө дайчилдаг байсан тэр эрхэм нандин чанар одоо сэргэж байх шиг. Өнгөрсөн амьдралаа эргэн харахад, миний амьдралын сайн сайхан, гэрэл гэгээтэй бүхэн ээж, аавтай минь, дараа нь Бүжинтэй холбоотой аж. Нурамгар нусгай жаал өдий зэрэгтэй эр хүн болоход Бүжингийн нөлөө, Бүжинг гэх хайрын хүч их байжээ.

14. Учрал

Би түүнийг үнэхээр их хайрлаж байлаа. Хайж олохыг хүсч байлаа. Намайг уучлаач хэмээн хэлж, учир зүйгээ олохыг яарч байлаа. Тийм учраас энэ хөдөө газар түүнийг хайн ирсэн билээ.

Суманд түрүүлсэн бөхдөө нутгийн захиргаа нь даага өгдөг юм байна. Тэгээд даагыг чинь зүсэлж өгнө гээд сумынхан Болдоо, бид хоёрыг дагуулаад хөдөөгийн нэг айлд ирэв.

Айлд хэдэн гадаад жуулчин ирсэн юмсанж. Ганц нэг юм асуухаар нь хэлж өглөө. Яриан завсар эндхийн нэг хүүхнийг маш цэвэр Англиар ярьж байхыг сонсоод тэр жуулчид ихэд гайхсаныг бас мэдэв.

Энд тэндээ цоорхойтой илэгдэж, хуучирсан дээл, өнгө халтартаж, хээгүй болох шахсан алчуур, өөрт нь элбэгдсэн бололтой түрийтэй гутал жийж, бүс олдоогүй юм болов уу, шидэмсээр дээлээ бүсэлсэн бүсгүй Англиар ярьдаг болж таарлаа. Түрийтэй гутлынх нь цахилгаан эвдэрч, энд тэндээ онгойж, дотроос нь хиртэй цагаан оймс цухуйсан байх агаад гутлынх нь нүхээр аргал, хоргол орж цагаан оймсыг улам халтартуулсан харагдана. Хөдөөгийн ийм эгэл бүсгүй Англиар ярьдаг байх гэж хэмээн бодоход хэцүү байлаа. Өрөвдмөөр хувцасласан тэр халтар бүсгүй яаж Англиар ярих вэ дээ. Нүүрээ нуугаад, ичингүйрээд байхаар нь над мэтийн сайхан залуу, тэгээд сумын наадамд түрүүлээд ирж байгаа бөх залуугаас хөдөөгийн бүсгүйчүүд ичингүйрдэг байж таараа гэх мэтийн ойворгон бодолд хөтлөгдөн бүсгүйн ингэж аяглахад гайхсангүй. Харин ч бүр таатай байлаа.

Нэг унага тайлаад, эхийг нь заалган хөхүүлэхэд өнөөх бүсгүй хэл ам нь дийлдэхээ байсан эгчмэд хүүхний заавраар миний татсан унаганы эхийг саахаар ирэв. Доош тонгойж суучихаад, гүүгээ саалаа. Харин тэгтэл турь муутай юмуу, эсвэл ур дүйгүй юмуу нэг л бишээ. Гүү саахад дадлагажаагүй нь илт. Эсвэл гүү маань сүү багатай, саамшаагүй юмуу олигтой юм гаргаж чадахгүй байгааг би хувинд орж байгаа саамны чимээгээр сонсож, дэлэн шувтрах гарын хөдөлгөөнийг ажин зогсов. Айлд ирчихээд заалтай биш. Манай адуу бол хамаа алга сан. Өнөөх бүсгүй нусаа шорхийтэл татаад л хичээгээд байх юм. Үнээ саавал хуруу гар нь бүр цуцах бололтой. Хөлс нь гоожиж байгаа бололтой нүүрээ арчина.

Үнэндээ би хөдөөгийн амьдралыг тэр дундаа адууг бол бүр гайгүй гадарлана. Багаасаа зуны амралтаараа байнга хөдөө явж, адуу айрган дээр олон зуныг өнгөрөөсөн билээ. Миний өвөө Эрдэнэт хотын хамгийн анхны жилийн наадмаар азаргаа хурданд тавьж, түрүүлж байсан нутагтаа нэртэй уяач байсан юм. Харин хожим нь өвөөг өнгөрсний дараа манай ах Эрдэнэтийн хорин жилийн ойгоор мөн л азаргаа түрүүлгэж, хурдан удамт адууны эзэн, хурдтай айлын хүү гэдгээ харуулж байсан билээ. Тиймээс би адуутай, айрагтай айлын хүүхэд учир хөдөөгийн ахуй, тэр дундаа адуу, айрагны талаар ерөнхийдөө багцаална.

Харин манай саальчин нэг л бишээ. Эгчмэд хүүхэн:

- Өө, тосоор гоожоо. Гүүгээ сааж чаддаггүй юу. Халхын сайхан залууд хөл алдав уу, хар гүүний дэлэнд хуруу хальтрав уу хэмээн тачигнатал инээхэд бусад нь мөн даган инээлдэж,

халтар саальчинг шоолцгоолоо. Тэгж байснаа өнөөх эгчмэд хүүхэн ирж:

- Алив, эгээ нь гээд өнөөх халтар саальчныг хийж чадахгүй ажлаас нь “авран” гүү сааж өгөв. Би халтар саальчинг бүр өрөвдчихлөө. Нүүрээ харуулахгүй бүр нугдайж орхив. Хөөрхийг яах нь вэ дээ гэж бодлоо. Хувцас хунар нь авах юм байхгүй, бас дээр нь ажил мэдэхгүй, хүний нүүр рүү эгцлээд харж чадахгүй ийм бүсгүйчүүлийг үнэхээр яалтай билээ дээ, хөөрхий.

Дорлигт би үнэхээр гомдсон байлаа. Аймшигтай ихээр гомдсон. Гэртээ ороод ээж, аавынхаа яав, ийв гэснийг ч үл тоон шууд өрөөндөө орж хаалгаа түгжээд дэрэндээ нүүрээ наан уйлж гарлаа. Ёстой муухай амьтан...

Маргааш нь Дорлигийг над руу нэг их баярлачихсан, баатар гээд өөрийгөө бодчихсон байдлаар ярихаар нь бүр уур хүрч үхэх гэж байлаа.

- Сайн уу? Бүжээн

- Муу...

- Өчигдрийн болсон явдалд уучлаарай...

-

- Миний төмсөг өвдөөд жаахан тийм л байна.

- Хохь чинь ш дээ.

- За, чи битгий муухай аашил л даа.

-

- Уучлаарай гээд байхад сүртэй ш дээ.

-

- Хөөе, байна уу?

- Чамд л сүртэй байх. Баяртай. Над руу дахиж битгий залгаарай гээд утсаа таслачихав.

Тэрнээс хойш Дорлиг над руу өчнөөн залгаж, мессеж бичив. Би мессежийг нь уншихыг ч хүссэнгүй шууд устгаад, утас дуугараад байхаар нь унтрааж орхилоо. Үнэндээ тийм шалиг заваан, түрэмгий залуутай дахиж уулзахыг хүссэнгүй. Тэгээд миний зүрх өвдөж байсан юм. Бүр хөдөлгөхгүй тас тэврээд, зүгээр аятайхан үнсэхгүй, нэг их том хэл нь ам руу орж, гарч долоогоод, тэгээд нэг их заваан шүлдэснийг нь яана. Бас тэр цамцан дотуур гараа шургуулж, биеийг минь илсэнд нь одоо бодохоор бүр дур гутмаар.

Магадгүй, би хорин хоёр, гурав хүртлээ хүнд үнсүүлж ч үзээгүй ганцаараа явсаар байгаад эрчүүдээс харшилтай болчихсон байж мэднэ. Анхны үнсэлтээ үнэхээр ингэж төсөөлж

явсангүй зарим нэг бүсгүйчүүд түрэмгий эрд дуртай байдаг юм гэнэ лээ. Харин би бол тийм биш. Яахаараа түрэмгий эрд дуртай байдаг байна аа. Сонин юм.

Маргааш өглөө нь утсаа нээтэл Дорлигоос баахан “Уучлаарай, хайртай” гэсэн мессеж ирсэн байлаа. Энэ өдөр би өчигдрийнхийг бодвол арай тайвширчээ.

Удалгүй Дорлиг дахиад залгалаа. Би бас л авсангүй. Утсаа унтраачихлаа.

Удаах өдрийн өглөө утсаа нээвэл мөн л баахан мессеж. Уучлаарай, чамтай улзмаар байна гэж зөндөө юм бичжээ. Түүнийг нь нэг их тоосонгүй. Тэгсэн чинь сүүлийн мессежийг уншвал “hi. Bi unendee Dorlig bishee. Dolgion baina. Chi namaig taniagui. Bi chamd hairtai” гэсэн байлаа. Гайхчихав...

Ямар Долгион билээ гээд бодохоор манай ангийн Долгионоос өөр Долгионыг би танихгүй. Өөр ганц мэддэг Долгион нь нөгөө ая зохиогч Долгион гэж надаас хамаагүй хөгшин байдаг. Тэгээд би бүр гайхчихлаа.

Нээрэн бодсон чинь Дорлиг гэдэг хүн Долгион болж таарав. Бодоод байхад яг мөн. Би яагаад түүнийг таньсангүй вэ? Хүн ингэж өөрчлөгдөх гэж. Яанаа, ямар ичмээр юм бэ?

Эсвэл уур хүрмээр. Тэгээд намайг Бүжин гэж мэдсээр байж янз үзэж, толгой эргүүлснийг нь бодохоор бүр үхлээ уур хүрэв. Бас их ичив. Учраа олохгүй хөөрч, Дорлигт хөл алдан унаж тусаж байснаа бодохоор үнэхээр ичмээр. Долгион гэдгийг нь таньсан бол арай өөр байх байсан. Бас Болдоогоос Долгионы тухай асууж байснаа ч санах. Хүн ингэж өөрчлөгдөх гэж байх уу даа. Эсвэл би өөрөө их тэнэг байх аа.

Ингээд ямар ч байсан Дорлиг хэмээх Долгионтой уулзахыг хүссэнгүй. Хэд хонолоо. Тэр над руу залгаж мессеж бичиж байснаа бүр таг болчихов.

Удалгүй наадам дөхөж би аавыгаа даган нутаг руу нь амрахаар явав. Ээж ажилтай тул хотод үлдсэн юм.

Би багадаа ганц нэгхэн удаа хөдөө явж үзсэн. Харин энэ удаад уйтгарласан сэтгэлээ засах гэж бас нөгөө талаас хөдөөгийн амьдралыг нүдээр үзэхээр явсан юм. Хөдөө ирээд ахындаа мал ахуйд нь тусалж, адуу мал, үнээ тугал гээд аль болох хөдөөгийн амьдралтай танилцах сонирхол үнэхээр байлаа. Аав ч гэсэн намайг ойрын үед бие нь өвдсөн хүн шиг уйтгарлах болсныг анзаараад Монгол хүн хөдөө үзэж, ялангуяа эмэгтэй хүн гүү сааж, айраг бүлж, сүү хөөрүүлж сурах хэрэгтэй хэмээн зөвлөж, эмээдээ туслахыг бараг “шаардаж” байв. Эртээд уйлж орж ирснээсээ хойш ийнхүү уйтгарлаж байгаад минь сэтгэл өвдөж охиныхоо сэтгэлийг засахыг бодсондоо аав минь тэгж зөвлөсөн хэрэг. Би ч гэсэн Англид очоод Монголын тухай хүмүүсийн асуусанд хариулж чадахгүй, ялангуяа хөдөөний амьдрал ахуйг асуухад “Мэдэхгүй. Би хотын хүүхэд” хэмээн мэдэн будилж байсандаа жаахан ичсэн юм болов уу, үнэхээр хөдөөний амьдралыг сонирхож байсан билээ. Монгол хүн тэрхүү эгэл амьдралыг сонирхож мэдэхгүй бол Монгол хүн гэж өөрийгөө хэлээд яахсан билээ.

Хөдөө ирж ганц нэг хоног. Аав нутагтаа ирсэн хүн гэсэн шиг л хэд хоног айраг цагаа уун, бас

хотоос авчирсан архи, дарсаа нутгийн хүмүүст гарган сэтгэл өег байлаа. Ээж байсан бол аавыг загнаж үглэх байсан байх. Харин би хориод нэмэргүй гэдгийг мэдэх тул хөөрхий муу аавыгаа төрөл садан, багын найз нартайгаа өөрийн дураар байг дээ хэмээн бодох тул эс хорино. Аав минь жаахан халж, дуу нь чангарахаараа “Миний муу охин” хэмээн толгойг минь яг л жаахан хүүхэд эрхлүүлж байгаа мэт өхөөрдөн үнэрлэж, илнэ.

Эмэгтэй хүн угийн ийм байдаг юмуу, эсвэл би гэж ийм сонин хүн юмуу Долгионтой дахин уулзмаар санагдаж, өөрийнхөө тэнэгийг гайхах болов. Эрчүүд угаасаа тэгдэг байх. Тэгж үнсдэг байх. Гэтэл би гэж юу ч үзээгүй тэнэг юм, түүнийгээ зодоод, хөөгөөд явуулчихлаа. Яах гэж тэгэвээ. Тэр төмсөг энэ тэр нь зүгээр болов уу гэж одоо бүр Долгионыг өрөвдөж, өөрийгөө зүхэж эхлэв. Бодоод байх нь ээ, нээрэн тэр төмсөг гэдэг их эмзэг зүйл байдаг гэсэн. Арай хагарчихаагүй байгаа гэж бас санаа зовно. Арай эмнэлэгт хэвтчихсэн юм биш байгаа. Тэгээд сүүлийн хэд хоног чимээгүй болчихов уу. Нөгөө Долгион маань тийм залуу болчих гэж. Сонин юм.

Ийн бодсоор би ер нь өөрөө юу болоод байгаагаа ч ойлгохоо байлаа. Бодол нэг газраа тогтохгүй гэгэлзээд нэг л биш. Бодоод байх нь Англид байхдаа тэр зургийг харж Долгионыг бодож, захиа явуулж, бүр тэрнээс өмнө аравдугаар ангидаа түүнтэй утсаар ярихад баярлаж, хөөрдөггүй байсан гэж үү. Магадгүй, тэрнээс өмнө дунд ангид байхдаа Долгионд талтай байсан ч байж мэдэх. Их сайн хүүхэд байсан шүү дээ гэж бодохоор өөрийгөө улам бүр үзэн ядаж, хот руу очоод түүнтэй заавал уулзана хэмээн сэтгэлдээ яарч байлаа. Түүнийг заавал үнсэнэ, тэгээд биеийг нь асууна гэж бодож байв.

Хүн дурлахаараа ер нь галзуурдаг байхаа. Эцэст нь түүнийг бодсоор бүр галзуурч эхлэв. Гэхдээ ямар ч байсан би Долгионтой уулзахыг хүсч байсан юм. Уг нь саяхан л үзэн ядаж байсан сан.

Нэг өдөр гүү саахыг сонирхлоо. Өөрөө саагаагүй ч, ерөнхийд нь яаж саадгийг ажигласан юм. Тэгээд дараагийн сааман дээр би саана шүү хэмээн хөөрцөглөв. Нэг сонин зүйл нь дандаа жижигхэн унаганы дотор нэг том алаг унага байлаа. Энэ одоо яагаад зөнөчихөөд энд байгаа юм гэж лавлавал дүү нь энэ хавар үхчихсэн юм, тэгээд ээж нь сүүтэй болохоор ахыг нь энэ жил барьчихсан юм гэлээ. Хөөрхий дүүгээ алдсан даага гэж бодлоо. Том биетэй хэрнээ бас өхөөрдөм амьтан байв. Эгчийн хэлж байгаагаар энэ алаг даага манай өвөөгийн адууны удам гэнэ. Олон жил болохоор сүүлдээ яг өвөөгийн адууны удмын адуу цөөрчих юм гэж эгч ярьж байв. Нэгдэл задарч, өмч хувьчлахад хэдэн адуу авсан боловч, сумын захиргаанд үлдсэн адуунд энэ алаг дааганы эцэг азарга байсан гэнэ. Сүүлд нь ах захиргааны адуу маллах болж, өвөөгийн гэх хэсэг адуу иржээ. Бусад нь энд тэндхийн цус холилдсон адуу юм байх.

Тэр наадмын дараа сумын наадамд түрүүлсэн бөхчүүд гээд хэдэн бүдүүн залуучууд ирцгээлээ. Надад ямар хамаа байхав гээд сонирхож харсангүй.

Сумын наадам болж байна гэдгийг сонссон. Бас ахыг бөхийн шагналд өгөх даагыг наадмын талбай руу хүргэж өг гэж эгчийн үглэснийг сонсож байсан тул ямар ч байсан наадам болж байгааг мэдэж байлаа. Өглөөгүүр ах, аав хоёр хурдаа үзнэ гээд уян дээр байсан хэдэн морьдыг уралдуулахаар манай дүү нарыг дагуулан явсныг ч мэдэж байв. Гэтэл морь үзсэний дараа ахын нэг морь түрүүлсэн гээд гэртээ ирснээс хойш аав, ах хоёр найз нартайгаа өнөөх

хагуу эдээ хүртээд, ах сум руу шагналын даагыг ч аваачиж өгсөнгүй. Харин хүүхдүүд нь сумын наадам руу давхин одоцгоов.

Эгч тэднийг явсны дараа бас л халаглалаа.

- Энэ лүдийг ингээд архи уугаад суухыг мэдсээр байж хүүхдүүдэд даага хөтлөөд яв гэж хэлэхээ мартчихаж. Энэ толгойг уу, цусаараа тээглэ гэнэ. “Цусаараа тээглэ” аягүй эвгүй сонсогдоно. Нэг бол балай, балайрсан юм гэж хараана. Тэрнийгээ ч анзаарахгүй.

Манай авга ахын эхнэрийг Пагма гэх. Пагма эгч ёстой гайхалтай дайчин хүүхэн байлаа. Тэгээд хэлж ярих гэж ёстой үзүүлж өгнө. Санаж бодсоноо шүлэг уншиж байгаа мэт толгой холбон хэлж, бас их шооч тул бусдыг үгээрээ инээлгэсэн хөдөөний нэгэн жаргалтай айлын гэрийн эзэгтэй. Хараад байхад манай ах гэж нэг нөхөр аавыг ирснээс хойш тэр үү, эсвэл угаасаа тийм юмуу, ерөөс гэрийн ажилд оролцохгүй юм. Өглөө босоод л айраг уух, лонх задлах ажилдаа аав, тэр хоёр орно. Эхнэрийнхээ хийж өгсөн хоолыг идчихээд л улс төрийн тухай эсвэл адуу, малын наймаа гээд л яриад суучихна. Пагма эгч, хүүхдүүдтэйгээ бужигналдаж байгаад, хамаг юмаа хийнэ. Харин эмээ маань тэдний ажилд ер оролцохгүй. Ахын хаяанд нэг жижиг гэртэй. Түүндээ л цай, цүй болон сууна. Тэгээд бас эмээ маань угийн дуу муутай хүн тул тэр хавьдаа л хэдэн жаахан хүүхдэд бидний авчирсан чихрийг тараан жаргалтай байх юм. Хааяа ахынд орж аав, ах хоёрын юу ярихыг сонсож жаал сууна. Тэгээд аав “Миний муу ээж” гээд л ээждээ эрхлэнэ. Орой болохоор, эсвэл жаахан ядрахаараа эмээгийн дор орж унтана. Ер нь тэгээд л болоо. Аав маань бодвол эмээг ядраачихна гэж боддог юмуу, ахынд л өдөр өнгөрөөж байлаа. Харин би эмээдээ бараа болно. Гэхдээ бараа болно ч гэж дээ. Эмээгээс ганц нэг зүйл асуун тогоо шанаганд нь тусалж, ааруул бяслаг хийхийг заалгаж байлаа.

Тэр өдөр “саамандаа” хэмээн Пагма эгчийг илүү гэрээс дуудахад би:

- Эмээ, би гарч сааж үзлээ гэхэд эмээ:

- Миний хүү, ийм гоё хувцастай яаж зэл рүү явах вэ? гэхэд “зүгээрээ” гэлээ.

- Үгүй ээ, болохгүй ядаж энэ эрээн мяраан хувцсыг чинь хараад адуу үргэнэ. Тэгээд миний муу хүү аягүй бол гишгүүлж сүйд болно гэж хэлэхэд өөрийн өмссөн тод өнгийн өмд, цамцаа хараад нээрэн магадгүй гэж бодон дээгүүр нь эмээгийн өгсөн хувцсыг өмслөө. Бороотой өдөр өмсөөд, нил шавхай болчихсон байв. Нэгэнт л хөдөөний амьдралыг үзье гэсэн юм чинь өгсөн хувцсыг өмсөв. Гутал нь ихэд хуучин л юм. Үхрийн баас, шавхай болчихсон. Гэлээ гээд би чинь энэ хувцсыг өмсдөг энэ хүмүүсийн үр, ач шүү дээ. Тиймээс цэрвэж болохгүй. “Муухай гээд хэлчихвэл эмээ минь гомдоно” гэж саналаа. Алтан шаргал арьсан углаашаа тайлж, цахилгаан нь задарсан түрийтэй гутал өмсөв. Дотуур нь бас эмээгийн өгсөн оймсыг юу ч бодолгүй өмслөө. Дээл, алчуур энэ тэр гээд бүх л хувцсыг ёс төрөөр нь өмсөхөд эмээ минь тусаллаа. Толинд харвал ёстой инээдтэй харагдаж байлаа. Юун нөгөө Бүжин. Ингээд нэг зургаа авахуулж, Англид байдаг найз нартаа явуулбал яах бол гэж бодоход их хөгжилтэй.

Зэл рүү их хөгжилтэй амьтан очлоо. Тэгсэн чинь юу вэ? Тэнд хэн зогсож байсан гээч. Би бүр нүдэндээ итгэсэнгүй.

Тэр залуу үнэхээр нүд дүүрэн сайхан харагдаж байлаа. Өмссөн дээл, малгай гутал нь үнэхээр сайхан зохиж. Миний таних тэр том биетэй залуу Монгол дээл өмсөөд ч тэрүү, бүр их том харагдана. Би түүнийг хараад их баярлалаа. Бараг л гүйж очоод бүх бодсон зүйлээ ярьж, түүнээс уучлал эрж, тэгээд зөндөө юм асуух байлаа. Бас биеийг нь асууж, зүгээр эсэхийг сонирхож мэдмээр. Үнэндээ би түүний биеийг ямар байгаа бол түүнийг гэмтээчихээгүй байгаа гэж ихэд санаа зовж байсан билээ.

Гүйгээд очмоор санагдсан ч өөрөө ичив. Өмссөн хувцсаа харахаар аймаар санагдлаа.

Тэгээд нэгэнт зэлэн дээр ирчихсэн тул буцаад гүйчихэж болсонгүй. Ядаж байхад Пагма эгч “Англи хэлтэй бөх дээр очиж гүүгээ саа” гээд нүүр түлэх шахав.

Ёстой аймаар. Би яах билээ. Чадахгүй ч гэлээ. Их хичээгээд саалаа. Гар чичрээд, хөлс гоожоод ер болсонгүй, Долгионд нүүрээ харуулчихвий хэмээн эмээж нүүрээ нуун ихэд бөгтийлөө. Сандрахаар бүр учраа олохоо байдаг юм билээ. Халуун зунаар давхар хувцастай, толгойгоо бөнжийтөл алчуур ороочихсон миний хөлс цувж, бас ядаж байхад хамраас нус гоожоод болсонгүй. Нусаа татлаа. Ичмээр. Гүүнийхээ гэдэс рүү нүүрээ улам наагаад байлаа. Тэгэхээр бүр их халууцна.

Ёстой ичмээрээ... Ичмээр... бүр хэлэх үг олдохгүй нь...

Үнэхээр юу болоод байгааг ойлгоход бэрх. Би гүү саагаад, Долгион унага татаад, хаана, хэзээ ингэнэ гэж зүүдлэх билээ. Баярлаад, ичээд, гомдоод ёстой олон юм давхцаж байв. Пагма эгчийн шоолж, Долгион бид хоёрыг холбон инээхэд бүр их ичлээ.

Гэтэл Пагма эгч тусалж, би чадахгүй ажлаасаа аврагдлаа.

Босоод шууд гэр рүүгээ гүйв. Тэгсэн чинь өөдөөс аав, ах хоёр баахан хүн дагуулаад гараад ирлээ. Тэр хүмүүс дотор Болдоо байж байх юм. Эргээд гүйх гэхээр Долгион хараад байдаг ёстой хаачихаа мэдэхгүй болоод зогтуссанаа гэр рүүгээ зөнгөөрөө гүйлээ. Би Болдоогоос биш, Долгионоос их ичсэн байсан нь тэр байж. Нүүрээ дараад, аягүй мангараа, одоо бодохоор бүр иччихлээ.

Тэгсэн аав:

- Өө миний муу хүү гүү саагаа юу, яасан хөөрхөн саальчин хүүхэн бэ? Алив аав нь үнсье гэж авлаа. Нүүрээ дараад хажуугаар нь гарах гэсэн чинь Болдоо:

- Хүүе, Бүжин гээд бүр бажгадуулав. Яалтай билээ.

- Сайн байна уу гэж хотын гудамжинд танихгүй шахуу хүнтэй мэндэлж буй юм шиг мэндэлчихээд эмээгийнх рүүгээ гүйгээд орчихлоо. Болдоо гайхсан байлгүй. Аав ч гэсэн, бусад хүн ч гэсэн их гайхсан байх.

Эмээгийн дээ ороод л шууд хувцсаа солилоо.

- Шараа, шараа, ёстой шараа гэх хэрнээ учиргүй баярлаад дэвхцээд байгааг минь харсан

эмээгийн нүд нь орой дээрээ гарах шахав. Би өмссөн хувцсаа ийш тийш шидлээд, бас хөөрч баярлаад инээгээд байлаа. Аягүй мангараа.

- Миний хүү яасан? гэж эмээ бүр үнэн сэтгэлээсээ гайхан асуулаа. Би эмээ дээрээ гүйж очин эмээгийнхээ хацар дээр жаахан хүүхэд шиг үнсээд:

- Аягүй гоё, эмээ. Аягүй шараа. Хи-хи гэж инээгээд зүүн талын ор руу гүйн очоод нүүрээ дараад хэвгчихлээ. Тэгээд бас инээгээд, өөрийгөө барьж чадахгүй хөхөрсөөр байв. Эмээ гайхаад байлаа. Ач охин нь галзуу, солио тусчихав уу гэж бодсон нь илт...

...Тэр өдөр надад гүүн зэлэн дээрээс нэгэн алаг даага бэлэглэсэн юм. Нөгөө нүүрэндээ нуугаад байсан халтар хүүхэн маань Бүжин минь байсныг би Болдоогоос сонсоод эрүү мулт үсрэх шахаж билээ. Болдоо бид хоёр охиных нь ангийн хүүхдүүд гэдгийг аав нь мэдээд ихэд баяссан. Тэгээд орой найр хийх тул үлдэж, хоноод явахыг санал болголоо. Уул шугамандаа бол энэ айлд хурд, хүч хоёр энэ өдөр давхцаж, ихэд бэлэгшээсэн юм. Энэ суманд харваачид байхгүй тул эрийн гурван наадмын хоёр төрлийн аваргууд найрны гол чимэг болох аж.

Зэлэн дээрээс буцаж ирээд, Болдоо бид хоёр Бүжингийн байгаа гэр рүү яваад оров.

- За, сайхан зусацгааж байна уу.

- Сайхаан, сайхан зусаж байна уу? За, бөхчүүд бяр хүч их биз дээ.

- Ихээ, их. Эмээгийн бие данги.

- Сайн хүү минь, сайн гэж гэрийн эзэн буурал хэлээд ач охиндоо:

- Алив, хүүхээ цай хийж өг. Идээ ойртуул гэж хэлэв. Ач охиныг нь сайн харвал арай ч түрүүний халтар шиг охин биш юмаа. Нусаа татаад байсан нусгай арай ч биш юм. Бие хаа тэгшхэн, нүүр дүүрэн инээмсэглэсэн ямар ч залуугийн зүрхийг булаам үзэсгэлэн төгс нэгэн байх аж. Ач охин юу ч дуугарсангүй. Удалгүй:

- Цай уу гэж бид хоёрт цай хийж өглөө.

Харчихаад аашлаад, зөрөөд унавал яахсан билээ дээ хэмээн бодож, дотроо эмээж байсан минь бага багаар арилж бодлын гүнд нар мандуулж, чилээрхсэн биеийн алжаалыг тайлчихав. Иймийн тул биеэ барихаа больж шууд л учир жанцангаа дэлгэлээ.

- Чамайгаа л гээд энэ хол газар яваад ирлээ гэхэд Болдоо хажуугаас дэмжин:

- Энэ сумын зааны чинь хөлд арслан нь үрэгдэх дөхөх юм. Хэзээ байтлаасаа арслангаа заан нь чирээд явж байлаа. Уг нь дагамаар юм. Тэгээд бүр сумын заан шүү гэж бааварлав. Энэ үгийг Бүжин гайхан хүлээж аваад, намайг суманд түрүүлж заан цол авсныг сонсоод баяр хүргэлээ. Тэр минь үнэн сэтгэлээсээ баярласан нь илт. Инээж эхэллээ. Өхөөрдөм хөөрхөн үзэсгэлэн минь дээ. Чи миний хайр, чамдаа би ямар их хайртай гээч. Намайгаа уучил хэмээн хэлмээр санагдана.

Ийн бид жаал суув. Эмээ гараад явчихав. Болсон явдлуудыг эргэн дурсаж, намайг танихгүй байсанд өршөөл эрж, Болдоо бид хоёр түүнээр тоглосноосоо ч бас уучлал гуйлаа. Гэхдээ Болдоогийн дэргэд би нарийн нандинаа бас дэлгэсэнгүй. Би хэдий Болдоод бүх үнэнээ ярьсан ч гэсэн заавал тэгж муухай үнссэн, муудалцсанаа гурвуулаа ярих нь утгагүй.

Найр, наадам эхэллээ. Хавь ойрын хүмүүс цуглацгааж, дэмбээ, хуруу, дуу хуур болсоор дэлгэрхэн зуны жаргалтай өдрүүдийн нэг үргэлжилж байв. Болдоо улсын наадмаар барилдах учраас айраг, архи ерөөс уусангүй. Хушуу хүргээд буцаана.

Бас эрт амрахаар зэхэж, машиндаа орж ороо засаад унтаж орхилоо. Харин Бүжин бид хоёр хэсэгтээ зугаалав. Бүх зүйл үнэхээр сайхан байлаа. Учран золгосон хайрт хосууд сэтгэлийн шивнээгээ дэлгэж, урин дулаан зуны тэнгэр дор би түүнд хайрын түүхээ ярьсан юм. Харин энэ удаад Бүжин биш, би их ярьсан.

Анхны хайр хэрхэн надад ирж, тавдугаар ангийн бяцхан жаал чухам юу хийхээ мэдэхгүй сандарч байснаа, амьдрал минь хэрхэн өөрчлөгдөж би өөрийн гэсэн зорилготой болсноо, агуу их спортоор хичээллэж, амандаа зөвхөн Бүжингийн төлөө хэмээн хэлж, бүхнийг хийж ирснээ бүгдийг түүндээ ярьсан, түүний төлөө чихээ хөлдөөж, түүний төлөө хичээлээ сайн давгаж, түүний төлөө л үнэхээр би бүх зүйлийг хийсэн дээ.

Монголд ирээд Бүжинтэй уулзахад өөрийг нь танилгүй, Дорлиг хэмээх залууд хөл алдан гүйгээд байхаар нь Долгион гэдэг хувь хүнийхээ үүднээс ихэд гомдож, шархалсандаа эвгүй авир гаргаснаа хүртэл хуучилсан. Энэ бүхний эцэст тэр минь намайг уучилсан. Харин би энэ удаад яагаад ч юм бэ? Мэдэхгүй, “Би чамд хайртай” хэмээх үгийг зүрхлэн хэлэхээр яарсангүй.

Өдий болтол амьдарсан амьдралын минь өөдрөг гэгээлэг бүхэн Бүжинтэй холбоотой. Ижий аавын хайр, багшийн сургаалаас гадна амьдрал өөрөө хүнийг хүмүүжүүлдэг гэж үнэн бөлгөө. Амьдрал хайр дээр тогтдог учир хайрын хүч л амьдралыг утга учиртай болгодог ажгуу.

Миний хайрыг үл огоорсон мэт дүр эсгэж, магадгүй анхандаа үл огоорч байсан ч байж болох хайртынхаа сэтгэлийг би түүний бичсэн “Бүсгүйн сэтгэл” хэмээх шүлгээс хожим нь олж харсан билээ. Тэр бүх зүйлийг төлөвлөж, намайг өөртөө татаагүй ч амьдралд бүсгүй хүн ямар байх ёстойг энэ шүлгээс харж болох буй заа.

БҮСГҮЙН СЭТГЭЛ

Байж л байг, тэр залуу намайг хараад

Бахардаад бас дурлалдаа шатаад байж л байг

Бахдаад бахардаад байж л байг.

Байж л байг, тэр залуу намайг хараад

Хөдөлгөөн бүрийг минь нүд цавчилгүй ширтээд байж байг.

Хүссэн бүхнээ тэрхэн зуур авч болдоггүйг мэдэж аваг.

Үнэн төрхийг чинь таньтлаа би чамайг зовооё.

Үүрд биш ч гэлээ, байж л бай тэгээд намайг хараад.

Бал амтагдсан уруулыг минь хүсээд байж л бай залуу минь

Бахим чанга гар, сайхан төрхийг чинь би харж л байна

Ухаан бодлоо алдталаа намайг хар, хүс

Оргилсон сэтгэл, зүрх чинь тэсэртэл би чамайг зовооё.

Эгшиг даган нахилзах бэлхүүсэнд минь шунаж байна, би мэдэж байна

Эр хүн гэдгээ надад харуулах гэж хичээж байгааг чинь би үнэлж байна

Үнэр тансаг сүрчигэнд минь чи галзуурч байна, надад таатай

Үүр шөнөөр унтаж чадахгүй чи намайг бодож байна, би баясаж байна.

Эрвээхэй адил намайг тойрон чи эргэлдэж байна, тиймээ, би сарнай

Эргэцүүлж бодоод хариултыг нь олохгүй чи цөхөрч байна, тиймээ, би асуулт

Элдэв янзын арван гурван мэхийг чи сэдэж байна, би баярлаж байна

Энэ шөнийг л чи тэвчвэл би чинийх, чи мэдэж байна, би ичиж байна.

Зугтаад гүйгээд л баймаар санагдах юм

Зуурч болов гэхдээ чамайг хүлээмээр бас бодогдох юм

Тэвчээрийг чинь үнэлэн, тэвэрт чинь очьё доо,

амраг минь

Тэгсний дараа би чинийх, чи минийх, тэр л үед би хаашаа ч зугтах аргагүй

Чамдаа дурласан сэтгэл минь дуусашгүй,

Чамайгаа хайрлах итгэл минь нугарашгүй.

Үүнийг уншиж суухдаа эмэгтэй хүн өөрийгөө хүндэтгэж, бусдаар хүндлүүлж байж эр хүний хайрын бурхан болдог байх гэж бодсон юм. Учир нь хэдий Бүжин бага байсан, надад дургүй ч гэлээ намайг өөртөө ойртуулахгүй байсан тэр мөч бүхэн нь миний сэтгэлд түүнийг гэх орон зайг улам тэлж өгсөн билээ.

15. Төгсгөл

Хуримын ордон...

Цэцгийн баглаанд хучигдсан амраг хосууд, цээл хоолойт ерөөлчийн сайн сайхны хүсэлтийг шивнэн хоорондоо ярилцаад бидэн хоёр жаргалтай. Цэнгэлийн манлай хайрын нандин чавхдасанд хөг нийлж, цэлмэг хөх тэнгэрийн дор бидэн хоёр хуримлалаа.

Гэрийн хос багана болж, амьдралаа зохиох аянд мордож, гэргий чинийхээ гарын хуруунд үнэн батламжит бөгжийг чинь зүүн өгөв.

Сэтгэл дотроо удаан хадгалан хэлэх гэсэн үг минь ердөө л гуравхан үг...

Би чамд хайртай!

Би чамд хайртай

Зургийг: Ж. Мөнхжаргал

Эхийг бэлтгэсэн: Б.Боорчи

Хэвлэлийн хуудас: 6.5 хх

Цаасны хэмжээ: 148x210

“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.

Table of Contents

- [1. Харц](#)
- [2. Зүүд](#)
- [3. Шинэ жил](#)
- [4. Би чамд хайртай!](#)
- [5. Бүжингүйгээр би амьдарч чадна](#)
- [6. Улаан хүрэмтэй охин](#)
- [7. Захидал](#)
- [8. Захидлын хариу](#)
- [9. Гэртээ ирлээ](#)
- [10. Болзоо](#)
- [11. Миний Бүжин](#)
- [12. Анхны хайр](#)
- [13. Уучлал](#)
- [14. Учрал](#)
- [15. Төгсгөл](#)